

АГУУЛГА

I. Өгүүлэл нийтлэл.

Олон улсын гэрээ, хэлэлцээрийг шүүх, хуулийн практикт хэрэглэх нь

П.Оюунчимэг ХЭҮК-ын гишүүн

Усаар хангагдах эрхийн эрх зүйн зохицуулалт ба хэрэгжилт

Г.Далайжамц Хуульч

Даяаршил ба хүний эрх

Г.Нарантуяа ХЭҮК-ын Өргөдөл гомдол хариусан референт

Хүний Эрх ба Боловсрол

Ч.Алтангэрэл ХЭҮК-ын боловсрол хариусан референт

Боловсролын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт ба хүүхдийн эрх

Ц.Түвшинтөгс Монгол Улсын гавьяат багш

“Улаанбаатар” дээд сургуулийн хүүхэд, гэр бүл судлаач багш,

Хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн байдал

Б.Баярцэцэг МУБИС, Нийгмийн ухааны тэнхмийн туслах ажилтан

Мэдээллийн эрх, эрх чөлөөг хангах асуудалл

Ж. Соёмбо ХЭҮК-ын бодлого, дүн шинжилгээ хариусан референт

Парламентын гишүүний “Иммунитет-Индемнитет” эрхийн тухайд

А.Түвшинтулга. ХЗҮТ-ийн ТБХТС-ын ЭШДА

Монгол улс дахь шашин шүтэх эс шүтэх эрх чөлөөний өнөөгийн байдал

Б. Оюун-Эрдэнэ

Улаанбаатар Дээд Сургуулийн Гэр бүл судлалын тэнхмийн багш

**ХДХВ/ДОХ Хүний эрхийн үндэсний болон олон улсын баримт
бичигт**

Н.Дашдорж Хуульч

ДОХ-оос сэргийлэхэд боловсрол тусална.

Δ.Баасансүрэн. ЭМШҮИС-ийн Гистологийн тэнхмийн багш

II. Хүний эрхийн мэдлэгт:

Хүний эрхийг хамгаалах зарим үр нөлөөтэй туршлагуудаас
/Хүний эрхийг хамгаалах нь: Бусдын туршлагаас суралшая/
Бэлтгэсэн С.Болд ХЭҮК-ын олон талт хамтын ажиллагаа хариуцсан
референт

Хүний эрхийн зарим вэб хуудсын танилцуулга

Бэлтгэсэн Ч.Алтангэрэл ХЭҮК-ын боловсрол хариуцсан референт

III. Хүний эрхийн боловсролын зөвлөмж

Хүний эрхийн боловсролын багш бэлтгэх зөвлөмж

Хүний эрхийн боловсролын Стратеги төлөвлөлтийн үүзэл АНУ.
Нью-Йорк 2005

Хүний эрхийн боловсролын тухай зөвлөмж

Хүний Эрхийн Үндэсний Комисс Улаанбаатар хот. 2005

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ШҮҮХ ХУУЛИЙН ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ НЬ

П.Оюунчимэг ХЭҮК-ын гишүүн

Хураангуй:

Аливаа улс орон олон улсын гэрээ хэлэлцээрийг соёрхон баталснаар тухайн орон өөрийн үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил биелүүлэн хэрэгжүүлэх үүргийг нэн түрүүнэ хүлээдэг.

1961 онд НҮБ-ын гишүүн орон болсноос хойш өнөөдрийн байдлаар Монгол улс зөвхөн хүний эрхийн талаар 50 гаруй олон улсын гэрээ конвенцид нэгдэн оржээ.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн 10-р зүйлийн 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ... гэж заасан байна. Үүнээс харахад Үндсэн хуулийн механизмаар “босго” болгон тавьж тухайн нэгдэн орсон олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэх, эс хэрэглэх эсэхээ шийднэгэсэн үг юм. Тэгэхээр Монгол улсын шүүх ямар нэгэн хэрэг маргаанд шийдвэр гаргахдаа дотоодын хууль тогтоомжид заагдаагүй асуудлаар олон улсын гэрээ конвенцийн заалтуудыг удирдлага болгон шийдвэрлэж болно гэсэн үг юм.

Монгол улсад өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа 300 гаруй хуулинд судалгаа хийж үзэхэд 80 гаруй хувьд нь “...олон улсын гэрээнд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.” хэмээн заасан байдал.

Ер нь олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжоос давамгайлах хүчинтэй байдаг. Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцийн 27 дугаар зүйл “Гэрээнд оролцогч улс гүрэн гэрээ биелүүлээгүй явдлаа дотоодын хууль тогтоомжийн заалтаар зөвтгэж үл болно” гэж заажээ. Энэхүү зарчмын дагуу үндэсний хууль тогтоомж нь олон улсын гэрээний

заалттай нийцсэн байх ёстой. Харин тэдгээрийн хооронд зөрүү гарвал олон улсын гэрээг дагаж мөрддөг.

Олон улсын гэрээнд хяналт тавих талаар Олон улсын гэрээний тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсын Их Хурал нь соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээ болон шаардлагатай гэж үзсэн Монгол Улсын олон улсын аливаа гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж байна.” 20.2 заалтад “Монгол Улсын Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар байгуулсан олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг зохион байгуулж ажиллана.” хэмээн тус тус зааж өгжээ.

Мөн тус хуулинд зааснаар засгийн газрын гишүүн, агентлагийн дарга олон улсын гэрээний биелэлтийг жил бүрийн 6 болон 12 дугаар сарын 20-ны дотор гаргаж, Гадаад хэргийн яаманд ирүүлж байх бөгөөд тухайн яам биелэлтийн явцыг нэгтгэн дүгнэж шаардлагатай тохиолдолд Засгийн газарт оруулж хэлэлцүүлж байхаар тусгажээ. Олон улсын гэрээ конвенцийг соёрхон баталж, дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж эхэлсний дараа холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судалдаг.

Цаашлаад аливаа олон улсын гэрээг дагаж мөрдөж буй эсэхэд байнгын хяналт тавих механизмыг төлөвшүүлэх, ажиллуулах, шинээр батлагдан гарах хууль тогтоомжуудын заалтуудыг олон улсын нэгдэн орсон гэрээний заалтуудтай уялдуулан гаргах шаардлага зүй ёсоор тавигддаг.

Ер нь олон улсын харилцаанд олон улсын гэрээг үндэсний хууль тогтоомжид хэрхэн нийцүүлэх, хэрхэн хэрэглэх талаар гурван төрлийн онол буюу үзэл баримтлал оршсоор иржээ.

Нэгдүгээрт:- Үндэсний эрх зүй, хууль тогтоомжоо олон улсын эрх зүй, түүний хэм хэмжээнээс дээгүүр тавих явдал. Энэ онолыг Германы философич Гегель өнгөрсөн 19 дүгээр зуунд дэвшигүүлэн тавьсан байдаг.

Хоёрдугаарт:- Дуализмийн /хосолмол/ онол,

Гуравдугаарт:- Австрийн хуульч Г.Кельзений онол буюу дотоодын

эрх зүйн хэм хэмжээнээс олон улсын эрх зүйн хэм хэмжээ давуу байх тухай онол байдаг.

Өнөөдөр дэлхий нийтийн практикаас үзэхэд ихэнхи улс орнуудад Кельзений онол буюу энэхүү үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрч, даган мөрдөж байна.

Кельзений энэхүү онолыг заримдаа монизм буюу инкорпораци /нэгтгэх нийлүүлэх/ хандлага хэмээн нэрлэдэг бөгөөд энэ нь олон улсын эрх зүйг дотоодын эрх зүйн салшгүй хэсэг хэмээн үзэж, олон улсын нэгдэн орсон эрх зүйн актууд нь шууд тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэгдэг бөгөөд тэдгээрийг хүчин төгөлдөр болгон дотоодын хууль тогтоомждоо нийцүүлэх ямар нэгэн үндсэн хуулийн болон бусад механизм шаардлагагүй хэмээн үздэг.

Ром Германы эрх зүйн тогтолцоотой зарим улс орнуудын хувьд, жишээ нь Германы Үндсэн хуулинд “ олон улсын түгээмэл эрх зүйн үндсэн дүрмүүд нь холбооны хууль тогтоомжийн нэгэн салшгүй хэсэг бөгөөд тэдгээр нь холбооны нутаг дэвсгэр дээр оршин суугчдал үүрэг хариушлага шууд үүсгэж, хууль тогтоомжоос илүү давамгай байна хэмээн заасан нь олон улсын эрх зүйн зарчмууд нь дотоодын хууль тогтоомжийг хүчингүй болгох эрхтэй эсэх, эсхүл Үндсэн хуулийг нь хүртэл хөндөж болох эсэх асуудлаар санал зөрөлдөөн үүсгэж байсан байна. Гэхдээ олон улсын гэрээг дотоодын хууль тогтоомжтой нийцүүлэх асуудлаар Германы үндсэн хуулийн 59 дүгээр заалтад тодорхой тусгаж өгсөн байна.

Франц улсын хувьд олон улсын гэрээг соёрхон батлалгүйгээр зөвхөн тодорхой хууль гарган үндэснийхээ хууль тогтоомжийн нэгэн адил хэрэглэдэг бөгөөд Үндсэн хуулийнхаа 56 дугаар зүйлд зарим нэгэн олон улсын гэрээний тодорхой заалтууд нь дотоодын хууль тогтоомжоос давуу эрхтэй байж болно гэж заасан байдаг.

ОХУ-ын 1993 онд батлан гаргасан Үндсэн хуулина /86 дугаар зүйл/ “Ерөнхийлөгч олон улсын гэрээг хэлэлцэх, түүнд гарын үсэг зурах, соёрхон батлах баримт бичигт гарын үсэг зурах эрхтэй” бөгөөд 106 дугаар зүйлийн дагуу Холбооны Зөвлөл нь Думын баталсан соёрхон батлах, эсхүл цуцлах ёстой олон улсын гэрээг заавал хянан үзэх

шаардлагатай байдаг. Үндсэн хуулийн шүүх нь мөн хүчин төгөлдөр болоогүй олон улсын гэрээг Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянах, хэрэв үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзвэл хүчин төгөлдөр болоход нь хориг тавих эрхтэй байдаг.

ОХУ-ын Үндсэн хуулийн 15 дугаар зүйлийн 4-т зааснаар "...олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд ба хэм хэмжээ болон ОХУ-ын олон улсын гэрээг түүний эрх зүйн системийн нэгэн хэсэг хэмээн үзнэ. Хэрэв ОХУ-ын олон улсын гэрээ нь хууль тогтоомжид зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг хэрэглэнэ" гэж заасан байна.

Зарим нэг улс орнуудын хувьд нэгдэн орсон олон улсын гэрээг хэрэглэх талаар тухайн улсын Дээд шүүх болон холбогдох байгууллагуудаас удирдамж гаргасан байдаг. Жишээлбэл ОХУ-ын Дээд шүүх 2003 оны 10 дугаар сарын 10-ны өдөр "Нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, ОХУ-ын олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх тухай" тогтоо батлан гаргасан байна. Үүнд: ОХУ-ын олон улсын гэрээний тухай Холбооны хуульд "... албан ёсоор хэвлэгдсэн ОХУ-ын олон улсын гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой дотоодын хэм хэмжээг батлан гаргах шаардлагагүй бол ОХУ-д шууд үйлчилнэ" гэжээ.

Манай улсын хувьд Үндсэн хуулийн заалт болон зарим нэг хуулиудад орсон заалтуудыг эс тооцвол тусгайлан гаргасан хуулийн тайлбар болон удирдамж огт байхгүй гэж хэлж болно. Цаг үеийн нөхцөл байдал, гарч байгаа хэрэг маргааны нийгмийн тодорхой хэсгийг хамарсан шийдвэрлэвэл зохих зарим нэгэн асуудал дээр дотоодын хууль тогтоомжид заагдсан тодорхой заалт байхгүйн улмаас хүний эрх ашиг хохирох явдал цөөнгүй гардаг.

Саяхан Хүний Эрхийн Үндэсний Комиссын төлөөлөн нэхэмжлэлтэй нэр бүхий 5 хүнд холбогдох төрөөс хохирол нөхөн төлүүлэх тухай иргэний хэргийг шүүх хянан хэлэлцэх явшад ч мөн ийм байдал ажиглагдсаныг хэлэх хэрэгтэй.

Хан-Үул дүүргийн шүүх шүүхийн практикт анх удаа Иргэний хуулийн 2-р зүйлийн 2.2 дахь хэсэгт зааснаар "Монгол улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө" гэж заасныг үндэслэн "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр

хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн” холбогдох заалтын дагуу хохирогчдод мөнгөн төлбөр гаргахаар шүүхийн шийдвэрт тусгасан байна. Энэ бол шүүх олон улсын гэрээний тодорхой заалтыг хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хэрэглэж эхэлж байгаагийн эхний тохиолдол гэдгийг дурдах хэрэгтэй.

Цаашид нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцийн заалтыг аль болох өргөнөөр хэрэглэж хэвших, практикт хэрхэн хэрэглэх талаар Дээд шүүхээс зөвлөмж, тайлбар, тогтоолуудыг гаргаж, хуулийн байгууллагуудад хүргүүлэх, сургалт семинар зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байна.

УСААР ХАНГАГДАХ ЭРХИЙН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ БА ХЭРЭГЖИЛТ

Г.Далайжамш Хуульч

◆ Эрт дээр үеэс эхлэн эрдэмтэн мэргэд маань усыг амьд байгалийг тэтгэгч рашаан хэмээн үзэж, түүнд хайр гамтай хандаж, хэмнэлттэй заршуулж байхыг сургаж байжээ.

◆ Ус бол байгалийн тэнцивэрт байдлын болон амьд байгалийн оршин байхын үндэс болж өгдөг.

◆ Ус нь далай тэнгис, нуур цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, мөнх цас, мөсөн гол, газрын доорх уснаас бүтдэг.

◆ Хүний төрөлхтний хөгжлийн явцад усыг унданы, ахуйн, үйлдвэрлэлийн, цэрэг дайны зориулалтаар их хэмжээгээр /зүй бусаар/ хэрэглэж ашиглах болсон. Үүнээс болж усны нөөц, хэвийн байдал алдагдаж, урсац хомсдож, улмаар үгүй болох, бохирдох явдал ихэссэн. Үүний уршгаар дэлхийн улс орнуудын зарим хэсэгт хүн ам усаар гачигдах, бохирдсон ус хэрэглэснээр элдэв халдварт өвчинд нэрвэгдэж, эрүүл мэндээр хохирох явдал улам бүр нэмэгдэх болсон.

Усаар хангагдах эрхийн олон улсын эрх зүйн зохицуулалт

Хүний эрхийн түгээмэл тунхаглал /1948 он/ 25 дугаар зүйлийн 1-д: Хүн бүр хоол хүнс . . . оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт /1966 он/ 11 дүгээр зүйлийн 1-д: Энэхүү пактад оролцогч улсууд хүн бүрийн болон түүний гэр бүлийн хүрэлцээтэй хоол хүнс . . . оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж амьдрах, амьдралынхаа нөхцлийг байнга сайжруулах эрхийг нь хүлээн зөвшөөрч, . . . эрхийг нь ханган хэрэгжүүлэх зохистой арга хэмжээг авна гэжээ.

Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хороо Монгол улсын "Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын хэрэгжилт"-ийн ээлжит 3 дахь илтгэлийг 2000 оны 8 дугаар сарын 17, 18-нд болсон 34, 35, 36 дугаар хуралдаануудаар авч хэлэлцээд, 2000 оны 8 дугаар сарын 28-ны өөрийн 49 дүгээр хуралдаанаар уг ерөнхий зөвлөмжийг гаргаж, түүнаа хүний эрхийн салбарт стандарт тогтоох үндсийг бүрдүүлэх хууль тогтоомжийг батлан гаргахын чухлыг тэмдэглэсэн байна.

2002 онд НҮБ-аас гаргасан ЭЗНСЭ-ийн Тунхаглааар дэмжигдсэн усны эрхийн Ерөнхий тайлбарт ус хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг хүний эрхийн үүднээс "Хүн бүр өөрсдийн хувийн болон ахуйн хэрэгцээнд хэрэглэх зорилгоор хангалттай, хүртээмжтэй, хүрэлцээтэй авахад дөхөмтэй, боломжийн үнэ бүхий цэвэр усаар хангагдсан байх эрхтэй" гэж тодорхойлжээ.

Дээрх шаардлагыг тус бүрд нь томьёолбол:

Хүрэлцэхүйц:

ОУ-ын заавар, зөвлөмжид ус нь хүний хэрэгцээг хангахуйц хэмжээтэй байна. Энэ нь 40-50 литр байх ба хамгийн доод хязгаар нь 20 литрээс багагүй байна.

Найдвартай болон хүлээн зөвшөөрөгдсөн :

Ус нь хэрэглээний төрөл болгонд найдвартай байх ёстой. Үндны ус нь маш өндөр стандартыг хангаж, хүлээн зөвшөөрөгдсөн өнгө, үнэр, амттай байх.

Авахад дөхөмтэй:

Ус нь айлын гэрт ойролцоо, авахад боломжтой байх.

Боломжийн:

Үс нь хүнд хэрэгцээнийхээ бусад зүйлийг худалдаж авахад хүндрэл үзүүлэхээргүй, боломжийн үнэтэй байх.

Усаар хангагдах эрхийн үндэсний эрх зүйн зохицуулалт

Монгол улсын Усны тухай хууль (2004 он)-ийн 22 дугаар зүйлийн 22.2-д “Ус хэрэглэгч нь чанарын шаардлага хангасан усаар хангагдах эрхтэй” гэжээ.

Монгол улсын Хүнсний тухай хуульд “Хүнс гэж хүний бие махбодийн өсөлт, хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах шим тэжээл бүхий хүнсний түүхий эд, бэлдэц, хоол, идээ, ундаа, унданы усыг” хэлнэ хэмээн заасан.

Үүнээс үзэхэд үндны ус бол хүний хүнсний бүрэлдэхүүн хэсэг болох нь тодорхой байна. Усыг зөвхөн хүсний зориулалтаар хэрэглээд зогсохгүй ахуйн зориулалтаар ашигладаг. Энэ талаар усны тухай хуульд: ус ашиглагч гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчинг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ гээд гэрээ байгуулж зөвшөөрөл авснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ гэжээ.

Мөн усаар хангагдах эрхийг баталгаажуулахад чиглэгдсэн дараах хууль болон хууль зүйн актууд зохицуулалтын үүргийг гүйцэтгэж байна. Үүнд:

а) Ариун цэврийн тухай хууль (1998 он)

Энэ хуулийн 5 дугаар зүйлд хүн амыг унд, ахуйн усаар хангахад тавих шаардлагыг доорх байдалаар томьёолжээ.

1. Хүн амын унд, ахуйд ашиглаж байгаа усны эх булаг, ус түгээгүүрийн шугам сүлжээ, ус нөөцлөх сан, шахуургын станц, ус түгээх байранд холбогдох дүрмийн дагуу хамгаалалтын бүс тогтоож, бохирдолтоос хамгаалах арга хэмжээг нутгийн захиргааны болон ус ашиглалтын байгууллага, аж ахуйн нэгж, иргэн авч хэрэгжүүлнэ.

2. Хүн амын унд, ахуйд түгээж байгаа усны чанарт ус ашиглалтын байгууллагаас стандарт, дүрмийн дагуу үйлдвэрлэлийн хяналт, шинжилгээ хийж, усны чанарыг сайжруулах арга хэмжээ авна.

б) Ойн тухай хууль (1995 он)

Энэ хуулийн 8 дугаар зүйлд онцгой бүсийн ойд цармын бүслүүрийн ой, дархан цаазтай газрын онгон бүс, хамгаалалтын бүс, байгалийн цогцолборт газрын онцгой бүсийн ой хамаарна гээд усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно" гэжээ.

в) Байгаль орчныг хамгаалах тухай хуульд:

Байгаль орчныг хамгаалах нийтлэг арга хэлбэрийн хүрээнд хүн амд экологийн боловсрол, хүмүүжил олгох;

Хот, тосгон, бусад суурин газрын орчинд болон гол, мөрөн, нуур, рашаан, булаг, шандын эх, ундаргын орчныг хамгаалах, эрүүл ахуйн бүс тогтоох;

г) Засгийн газрын 2003 оны 37 дугаар тогтоолоор баталсан "Улсын мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм"-д устай холбоотой энэхүү хяналтын чиглэлийг тодорхойлохдоо:

Газар, газрын хэвлэй, түүний баялаг, ус, ой ургамал ... тэдгээрийг зохицтой ашиглах нөхөн сэргээх ... хамгаалахтай ... стандарт, хэм хэмжээний биелэлтэд хяналт тавих;

Хот тосгон, бусад суурин газрын орчинд болон гол, мөрөн, нуур рашаан, булаг шандын эх, ундаргын орчныг хамгаалж эрүүл ахуйн бүс тогтоосон байдал хяналт тавих;

Хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын эрүүл ахуйн бүс тогтоолт, усны чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангуюж байгаа эсэхэд хяналт тавьж дүгнэлт гаргах;

д) Засгийн газрын 2001 оны 242 дугаар тогтоолоор баталсан "Хүнсний хангамжаюулгүй байдал, хоол тэжээл" үндэсний хөтөлбөрийн 7-р зорилтод: Хүний усаар хангагдах эрхийг хэрэгжүүлэх талаар дараах зорилтуудыг тусгажээ:

Хэрэглэгчдийг чанартай, хүрэлцээтэй усаар найдвартай хангахад чиглэгдсэн усны эх үүсвэрийн хайгуул, судалгааг хийж нөөцийг тогтоох;

Хүн амын унданы усны эх үүсвэрт хамгаалалтын бүс тогтоож паспортжуулах;

Усны нөөц нь ундны усны чанарын стандартын шаардлага хангагчийн сүм, суурин газруудад ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх арга хэмжээ авах;

Томоохон хотуудын ус хангамжийн эх үүсвэр- газрын доорхи усны горимын өөрчлөлт, бохирдлыг хянах хэмжилтийн сүлжээг тэдгээрийн ай савуудаар байгуулж эхлэх.

Дээрх хууль, эрх зүйн актууд нь хүний усаар хангагдах эрхийн эрх зүйн зохицуулалтын үүргийг гүйцэтгэж байна.

Хүний усаар хангагдах эрхийн зарчмууд

Дэлхийн аль ч улс орны хувьд усны хангамж болон ус сураг дахь хүний эрхийн дараах зарчмуудыг баримтлах ёстай.

Нэгдүгээрт:

Хүний усаар хангагдах эрхийг хэрэгжүүлэхдээ аль ч үед алагчлан үзэхгүй, буюу гадуурхахгүй байх зарчим.

Хоёрдугаарт:

Хүний усаар хангагдах эрхийг хэрэгжүүлэхдээ адил тэгш хандаж байх зарчим. Өөрөө хэлбэл хот, хөдөөгийн ямар ч нөхцөлд амьдарч буй иргэнийг усаар тэгш хангах зарчмыг баримтлах.

Гуравдугаарт:

Хүний усаар хангагдах эрхийн салшгүй байх зарчим. Энэ эрхийг хүнээс хэзээ ч салгаж, хязгаарлаж болохгүй учир уг зарчим үйлчлэх ёстай.

Дөрөвдүгээрт:

Хүний усаар хангагдах хариуцлагын зарчим нь хүний эрхийн тулгуур зарчмын нэг юм.

4. Хүний усаар хангагдах эрхийн хэрэгжилтийн байдал

A. Дэлхийн усны хангамж, хүртээмж, усны нөөц, зарим хүчин зүйлүүд.

- a) Дэлхийн усын нөөцийн тархалт (хувиар)
 - ◆ Гадаад далай -93.96%
 - ◆ Газрын доорх усны нөөц -4.12%
 - ◆ Мөстөлт-1.65%
 - ◆ Ил задгай орчинд-0.019%
 - ◆ Агаар мандалд- 0.001%

Өдөр бүр уух хангалттай устай, сайжруулсан ариун цэврийн байгууламжтай байх нь дэлхийн сая, сая хүний хувьд шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болж байна. Дэлхийн хэмжээнд ус хангамжийг сайжруулсан эх үүсвэрээр хангагдсан хүний тоо 1990 оноос хойш жил тутам 90 гаруй сая хүнээр нэмэгдэж байна. Гэвч хүн амын өсөлтөөс шалтгаалж, ус хангамжийн найдвартай хүртээмжгүй хүний тоо жилд 10 сая орчмоор буурч байгаа сөрөг тал байна.

б) Дэлхий дахинд усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмж ба эрүүл мэндийн байдал.

- ◆ 1.1 тэрбум хүн чанарын баталгаатай усаар;
- ◆ 2.6 тэрбум хүн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн хүртээмжээр гачигдаж байна.
- ◆ 2 213 000 хүн усан хангамж, ариун цэврийн байгууламжтай холбоотой өвчний улмаас нас барж байна.

(Эх үүсвэр. ДЭМБ 2005 он, Хүн амын усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмж)

в) Хөгжиж буй улс оронд усан хангамж ба эрүүл мэнд.

- ◆ Устай холбоотой өвчний улмаас жилд 6 сая хүн нас барж, 8 секунда тутамд нэг хүүхэд нас эцэслэж байна.

(Эх үүсвэр. Дэлхийн хөгжиж буй орны илтгэл 2003 оны 5 дугаар сарын 6. ХАУХ, АЦБ-ийн хүртээмж 2004 он)

Устай холбоотой үүсдэг зарим өвчлөлт, нас баралт.

Суулгалт өвчин:

- ◆ Дэлхийн түвшинда суулгалт өвчинүүд нийт нас баралтын шалтгааны 4%, өвчний улмаас амьдралын жил алдаалтын шалтгааны 4.3%-ийг эзэлж байна.

◆ 1.8 сая хүн суулгалт өвчний улмаас нас барж байгаагаас, (холерыг оруулаад) 90% нь 5-аас доош насны хүүхдүүдээс эзэлж байгаа бөгөөд ихэнхи нь ХБО-нд тохиолдох байна.

(Эх үүсвэр. ДЭМБ, 2002 он, 2004 он)

Нарийн гэдэсний хорхой өвчин:

- ◆ 133 сая хүн нарийн гэдэсний хорхойн өвчинүүдээр өвлөж байгаагаас оюуны хомдол, хүнд суулгалт, цус багадалтандаа өртөж байна.

- ◆ Эдгээр өвчний улмаас жил бүр 9400 хүн нас барж байна.
- ◆ Аюулгүй усан хангамж, ариун цэврийн үйлчилгээ болон эрүүл ахуйн сайн дадал нь аскариазисын өвчлөлийг 29%-иар бууруулна.

(Эх үүсвэр. ДЭМБ, 2004 он)

Гепатит А:

- ◆ Жил бүр 1.5 сая гепатит А-ийн клиникийн тохиолдол бүртгэгддэг

(Эх үүсвэр. ДЭМБ 2004 он)

Трахома:

- ◆ 500 сая хүн трахомагийн эрсдэл байна.
- ◆ 146 сая хүн сохорч байна.
- ◆ 6 сая хүн хараа муудаж байна.

Эдгээр нь ахуйн усны дутагдалтай буюу усны эх үүсвэрээс хол байдаг газарт тохиолдох нь элбэг.

Усны хангамжийг болон эрүүл ахуйн дадлыг сайжруулбал трахомагийн өвчлөл 27.0%-иар буурна.

(Эх үүсвэр. ДЭМБ. 2004 он)

Б. Монгол улсад усны хангамж, хүртээмж, усны нөөц, зэрэг, сөрөг хүчин зүйлүүд, төлөв байдал.

Монгол улс усны багавтар нөөцтэй оронд тооцогддог. Манай оронд нийт 599 шоо км/ус байдгаас нууруудад 500 шоо/км, мөстөлд 62.9 шоо км, гол, мөрөн, тэдгээрийн газрын доорхи усны тэжээл 34.6 шоо км ус байна.

(Эх үүсвэр. БОЯ, Монгол орны гадаргын усны тоо бүртгэлийн тайлан. 2003 он)

Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 2/3 –ийг эзэлдэг тал хээр,.gov.uds усны нөөцийн 36.7% нь ноогддог.

1995 онд явуулсан судалгаа, усны тоологоор 5565 гол горхи бүртгэгдсэний 683 нь, 9600 булаг шанд бүртгэгдсэний 1484 нь, 4196 нуур бүртгэгдсэний 760 нь ширгэн алга болсон бол 2003 онд явуулсан усны тоологоор 5097 гол горхи, 9582 булаг шанд бүртгэгдсэнээс 372 гол горхи, 1158 булаг шанд ширгэсэн, 1530 уст цэг устаж үгүй болсон гэсэн тооцоо гарчээ.

/Эх үүсвэр. Усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмж, тайлан 2004 он. Үндэсний чуулганда тавьсан илтгэл, 2005 он/

Уул уурхайн үйл ажиллагаа болон түүнда хэрэглэж буй технологи нь усыг бохирдуулах гол шалтгаан болж, байгаль орчны хамгийн хөнөөлт хүчин зүйл хэмээн тодорхойлогдсон байна.

◆ Жишээ нь: Архангай аймгийн Шэнхэр сумын Нарийн хамар, Ширдэгийн голын сав нутагт хайгуулын болон ашиглалтын олон тооны лиценз олгож, алт олборлолт явуулнаас зөвхөн энэ сумын нутагт байдаг Тамирын гол, Орхон голыг тэжээдэг Харгуйт, Өл, Могойт, Шийрт гүүтийн голын усуудын урсац 40% хүртэл багасч, Монгойт зэрэг зарим гол ширгэсэн байна.

◆ Эдгээр алт олборлож буй газрыг “Усны эх буюу усны хагалбар газар” учир нутгийн иргэд шантаршгүй тэмцэл юм байна. Энэ орчны алт олборлох лицензийг цушлах шаардлагатай гэжээ.

“Шэнхэр сумын голуудын сав нутгийн орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэл” сэдэвт ШУА-ийн Гео-экологийн хүрээлэнгийн судалгааны тайлан 2004 он/

◆ Ус-Хот, хөдөөгийн ялгааг үүсгэгч хүчин зүйл

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон үндны хэрэгцээнд ашиглах усан хангамж монгол орны хот, хөдөөгийн аюулгүй байдлын асуудлын нэг юм. Эдүгээ Монголчуудын нэлээд хувь нь найдвартгүй эх үүсвэрээс усны хэрэгцээгээ хангаж байна. үндны усны хангамж нь газар зүйн байршил, орлоготой нягт уялдаатай. Тухайлбал, 2000 онд хөдөөгийн хүн амын 66.0%, хотын иргэдийн 9.0% хамгаалалтгүй эх үүсвэрээс үндны ус хэрэглэж байжээ.

◆ Хотод ядуу хүн амын зөвхөн дөрөвний нэг нь, харин ядуу бус иргэдийн тэн хагас нь усан хангамжийн төвлөрсөн системд холбогдсон байв. Хотын гэр хорооллын оршин суугчид гол төлөв ойролцоо эх үүсвэрүүдээс усаа зөөж хэрэглэдэг бөгөөд үүний тулд нийслэлийн зарим хорооны иргэд ихээхэн хол замыг туулахад хүрч байна.

◆ Гэр хороололын оршин суугчдаас илүү их мөнгийг усны хэрэглээндээ заршуулж, тэндээс бага ус хэрэглэгдэж байна. Хотын оршин суугчдын усны хэрэглээ нь хөдөөгийн иргэдийнхээс бараг гурав дахин их бөгөөд 100 гаруй сүм мөнх цэвдгийн бүсэд байрлаж, говийн аймгуудад хэрэглэж буй үндны ус нь эрдэсжилт ихтэй, флуорил багатай байдгийн улмаас бөөр, шээний замын өвчин, бамбайн бахлуур, шүд цоорох өвчнөөр өвдөж байна.

◆ Сүүлийн жилүүдэд ган болж, цаг агаар өөрчлөгдөж байгаа тул хэрвээ усжуулалтын барилга байгууламжинд хөрөнгө оруулалт

хийхгүй бол хөдөө аж ахуйн салбарт ажиллан амьжиргаагаа залгуулдаг хөдөөгийн иргэд эдийн засгийн хувьд эмзэг байдалд ороход хүрч байна. Социализмын үед барьж байгуулсан 35000 механикжуулсан болон гүний худгийн 60.0 хувь нь шилжилтийн жилүүдэд ашиглах боломжгүй болжээ.

◆ Үүний улмаас хур тундас ороогүй эсвэл бага үед малын тоо толгой хорогдох магадлал ихээр нэмэгдэж, усны эх үүсвэрт ойрхон бэлчээр нутаг тахлагдах болжээ. Сүүлийн жилүүдэд гүний усны түвшин дошилж, усны зарим хуучин эх үүсвэрүүд ширгэх боллоо.

/Эх сурвалж: Хүүхэд ба хөгжил судалгаа, 2000 он, ҮСГ. Хүний хөгжлийн илтгэл 2003 он/

- ◆ Унданы усны хүртээмж, хувиар, 1998-2000 он
- ◆ Усны баталгаат эх үүсвэр ашиглаж буй хүн ам

	1998	1999	2000
✓ Хот	89,9	89,9	90,8
✓ Хөдөө	46,1	46,1	34,4
◆ Усны баталгаат эх үүсвэргүй хүн ам			
✓ Хот	10,1	10,1	9,2
✓ Хөдөө	53,9	53,9	65,6
◆ Бүгд	32,0	32,0	37,4

Сайжруулсан усан хангамжийн эх үүсвэрүүд.

Үүнд:

- ◆ ТҮХ-ийн системийн холболт
- ◆ ТҮХ-ийн шугаманд холбогдсон ус түгээх байр
- ◆ Өрөмдмөл гүний худаг
- ◆ Хамгаалалттай худаг
- ◆ Хамгаалалттай булаг
- ◆ Борооны ус /Монголд хэрэглэдэггүй/

Манай улсад үнданы усны 30,8 хувийг ус түгээгүүрийн төвлөрсөн системээр, 24,4 хувийг зөөврийн усаар, 35,7 хувийг ус түгээх цэг болон худгаас, 9,1 хувийг булаг шанд, гол горхи, цас мөсний усаар хангагдлаг байна.

◆ Улаанбаатар хотын ундын усны төвийн эх үүсвэр нь Оргил рашаан сувиллын зүүн урьд хэсэгт Их тэнгэрийн гүүрний хойд хэсгээс Гачууртын хар усан тохой хүртэлх нийт 15 км орчим газар үргэлжилдэг. Гэтэл усны эх үүсвэрийг хамгаалах асуудал сул бөгөөд хоногт 114,0 мянган шоо метр ус олборлох хүчин чадалтайгаас одоо 70,0 мянган шоо метр ус олборлож байгаа нь хотын усны хэрэглээний 50 гаруй хувь, хүн амын усны хэрэглээний 70-80 хувийг хангаж байна.

Усаар дамжин халдварт өвчин үүсгэгчдийн бие махбодид орох зам

- ◆ Хоол боловсруулах замын эрхтэн
- ◆ Амьсгалын замын эрхтэн
- ◆ Арьс салст

Усаар дамжих халдварт өвчний ангилал

- ◆ Бохирлогдсон усаар шууд үүсгэгдэх-гепатит А, холер, балнаад, лепостири
- ◆ Ус дутагдалтай үүсэх-хамуу, дизентерий
- ◆ Ялгадас эсвэл усан дээр хорхойн өндөг суурьшсанаас үүсэх-аскаридов
- ◆ Усны ойролцоо амьдардаг шавьжаар үүсэх-маляри, шар чичиргэнэ
- ◆ Усаар цацагдан үүсэх-легинеллээз, шистосомазис

Усны чанар, бохирдол, бохирдлын индекс

Бохирдлын индекс	Усны чанар	
	Зэрэг	Ангилал
<0.3	I	Маш цэвэр
0.31-0.89	II	Цэвэр
0.90-2.49	III	Бага
2.50-3.99	IV	Бохирдолтой
4.00-5.99	V	Бохирдолтой бохир
6<	VI	Маш бохир

Усны чанар, индекс болох хүчин зүйлс:

- ◆ Бохирдуулах бодисын тархац
- ◆ Хор хөнөөлийн зэрэг
- ◆ Бохирдлын хүчин зүйл
- ◆ Ууссан хүчилтөрөгч
- ◆ Хялбар исэлдэх органик бодис
- ◆ Эрдэс, азот
- ◆ Фосфор
- ◆ Хром
- ◆ Зэс

◆ Төв орон нутгийн МХГ-ын лабораторит нийт 2442 усны дээжинда хими, физик, нян судаллын 10119 үзүүлэлтээр шинжилгээ хийсний 36.5 хувь нь ундны усны чанарын шаарлага хангаагүй гарчээ.

◆ Улаанбаатар хотын ундны усны төвийн эх үүсвэрийн хөрсөн бүрхэвч нь нянгийн бохирдолтоор дунд зэргийн хэмжээнд, ус нь нянгийн болон хүнд металлын бохирдолтой, тухайлбал Дунд голын урд хэсэг 36 дугаар худаг орчим, Нарантуул захын урд хэсэг, Улиастайн гүүрний баруун урд, төмөр замын урд гармын 27 дугаар худаг, баруун захын 43 дугаар худаг орчимд хүнд металлын бохирдолт харьцангуй ондөр гарсан.

◆ Ундны усны шим болон нян судаллын үзүүлэлтүүдийн халдварт өвчинд нөлөөлөх нөлөөллийг судлан үзэхэд нийт халдварт өвчний гаралтад ундны усны нянгийн бохирдолт гарсан байна гэсэн дүн гарчээ.

◆ Хөрс, орчин, агаарын бохирдлын байдалд хийсэн шалгалтын дүнгээс авч үзэхэд Улаанбаатар хотод амьдарч байгаа гэр хорооллын айл өрхүүдийн 67 хувь нь стандартын шаардлага хангаагүй бие засах газартай, 34,5 хувь нь бие засах газаргүй, бохир усны цооноггүй байна.

◆ 2004 онд хөрсний дээжинд хийсэн нян судаллын шинжилгээгээр 35,0 хувь нь 3 дугаар зэргийн, 65,0 хувь нь 4 дүгээр зэргийн бохирдолтой гарснаас харахад хөрсний бохирдолт жилээс жилд нэмэгдсээр байна.

/Хүний эрхийн байгууллагуудын үндэсний чуулганад тавьсан илтгэл 2005 он/

Суулгалт өвчин

♦ Монголд 1 хүртэлхи ба 0-5 насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгаан болдог. Суулгалт өвчний 88 хувь нь шаардлага хангагүй усан хангамж, ариун цэвэр ба эрүүл ахуйн нөхцөлтэй холбоотой байна.

/Эх үүсвэр ДЭМБ, 2004 он/

Суулгалт өвчнөөс урьдчилан сэргийлэх аргууд ба үр дүн

♦ Усан хангамжийг сайжруулбал суулгалт өвчнийг 6-25 хувиар, ариун цэврийн үйлчилгээг сайжруулбал суулгалт өвчнийг 32 хувиар,

♦ Эрүүл ахуйн боловсрол олгох болон гар угаах дадлыг дэмжих нь суулгалт өвчнийг 45 хувиар,

♦ Гэрийн нөхцөлд усыг сайжруулах арга тухайлбал хлоржуулах аргыг хэрэглэвэл суулгалт өвчнийг 35-39 хувиар бууруулна.

/Усан хангамж, түүнтэй холбоотой эрүүл мэндийн асуудалууд илтгэл 2005 он/

Монголын хүний хөгжлийн илтгэл: /2003 он/

♦ “Хот хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн байдалд үндны усны чанар ихээхэн нөлөөтэй. Хөдөөгийн оршин суугчдын гуравны хоёр нь хамгаалалтгүй худаг, гол мөрөн, цас борооны усыг ундандаа хэрэглэж байхад хотодэнэ үзүүлэлт 10.0 хувьд ч хүрэхгүй байна” гэж тэмдэглэгдсэн нь дараах баримтаар давхар нотлогдож байна.

♦ Монгол улсын нутаг дэвсгэр дэх булгийн усанда бүсчилсэн түүвэр судалгаа 2005 онда хийхэд дараахи байдалтай байжээ.

Ариун цэврийн байршил зүйн хяналтын үр дүн бүсчилдээр

Бүс Төв, баруун, хойд Зүүн ба говь Улаанбаатар Нийт									
Үзүүлэлтүүд	үнэлгээ	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Хамгаалалт Р=0.722	үгүй	53	79.1	24	74.9	22	79	99	78
	модон	2	2.9	2	6.3	-	-	4	3.1
	төмрөн	8	11.9	4	12.5	2	7.1	14	11
	чулуун	4	6.0	2	6.3	4	14	10	7.9
	Нийт	67	100	32	100	28	100	127	100

◆ Үүнээс үзэхэд судалгаанд хамрагдсан булгийн 99 нь буюу 78 хувь нь ямарч хамгаалалтгүй байгаа нь хуулийн заалт хэрэгжин биелгээгүйн улмаас хүний эрүүл мэнд хохирч болзошгүй байгаагийн бодит баримт мөн.

◆ Эдгээрийг эрүүл ахуйн талаас нь лабораторийн шинжилгээ хийхэд 45,4 хувь нь, үүнээс зүүн ба төвийн бүсийн 53,3-54,8 хувь нь, Улаанбаатар хот орчмынх нь 67,9 хувь нь унда, ахуйн усны эрүүл ахуйн шаардлагаа хангахгүй байжээ.

/Тайллангийн 13 дахь хуудас/

◆ Энэ нь хөдөөгийн болон нийслэлийн захын хороололд хүний усны хангамжийн эрхийг хамгаалах явдалд хайхрамжгүй хандаж буйн илэрэл юм.

◆ Монгол улсад говь тал хээрийн бүст амьдрагч иргэдийн дийлэнх нь усан хангамжийн эх үүсвэрээ худгаас хангуулдаг. Ихэнх аймаг орон нутагт худгийг малчин өрхийн дундын эзэмшилд өгч, хэрэглүүлж байдаг онцлогтой.

◆ Гэтэл зарим аймгийн сүмдад малчдын эзэмшиж буй худгийг албан ба албан бусаар гол төлөв алт олборлож буй хувь хүн, аж ахуйн нэгжүүд дур мэдэн ашиглаж байдгаараа эзэмшиж буй иргэдийг усаар гачигдуулдаг хандлага илэрч байна.

◆ Жишээ нь: Өмнөговь аймгийн Ханбогд, Хүрмэн, Баяндалай зэрэг сүмдын малчин өрхийн эзэмшиж буй худгийн дэргэд гар аргаар алт олборлож буй иргэд мөнгөн усыг алт олборлохдоо технологийн бус аргаар хэрэглэж ус бохирдуулж байгаа мэдээлэл байлаг.

◆ Ер нь уул уурхайн салбарт ихэнхдээ дэлхий дээрх хамгийн хортой хүхрийн хүчил, цианит, мөнгөн ус гэх мэтчилэн урт хугацаанд хадгалагдаг өргөн орон зайнд тархсан, байгаль орчин болон хүний удамшил сөргөөр нөлөөлж нөхөгдөшгүй хохирол учруулдаг элементийг ашигласаар байна.

Усны бохирдол

◆ Улсын хэмжээнд 120 сая шоо метр ус цэвэрлэх байгууламжаас 60 хувь нь ажиллахгүй. 200 сая шоо метр хаягдал бохир ус улсын хэмжээнд гарч байгаагаас 40 хувь нь механик биологийн аргаар цэвэршүүлж байна.

◆ Бороо голын ёроолын хурдсандаа мөнгөн усны агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс 19 дахин их байна.

◆ 8 аймгийн 29 гол горхины усны чанар алтны уурхайнүүдүн үйл ажиллагаанаас бохирдсон. "НИК" ХХК-ны Толгойтын Нефть бааз, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар депогийн асгасан нефтийн бүтээгдэхүүн газарт нэвчиж гүний усны давхаргал хүрч бохирдуулж байна.

◆ Гэр хорооллын хүн амын суулгатл өвчин, ундны усны хими, нянгийн бохирдлын хооронд шууд хамааралтай.

/ХЭҮК-ын захиалгат судалгааны тайлан 2005 он/

◆ Энэ бүхэн нь хүний усаар хангагдах эрхийг зөрчиж буй ноцтой илэрлүүд мөн. Монгол улсын хүн амын бараг тал илүү хувь нь оршин суудаг нийслэлд усны бохирдол их байгааг дээр дурьдсан билээ. Тухайлбал:

◆ Туул гол 5 дугаар зэргийн бохирдолтой гарч энэ нь зөвшөөрөгдөх хэмжээнээс 10 дахин их байна. Бохирдсон усны 47 хувийг үйлдвэрлэлийн хаягдал, 53 хувийг ахуйн болон орон сууцны хаягдал эзэлж байна.

◆ Улаанбаатар хотын хүн амыг ундны усаар хангах, усны эх үүсвэр түүний тэжээгдлийн мужийг хамгаалах эрхийг хэрэгжүүлэх үүрэг бүхий холбогдох байгууллага, нийслэлийн удирдлага дорвитой арга хэмжээ авахгүй байгаа талаар хяналт шалгалтын байгууллага болон олон нийт шүүмжилдэг нь үндэслэлтэй бөгөөд онцгой анхаарах шаг болсон асуудал юм.

◆ Энэ нь ус хэрэглэгч нь чанарын шаардлага хангасан усаар хангагдах эрхтэй гэсэн Усны тухай хуулийн 22.2 зүйлд заасан эрх нь зөрчигдэж буйн баримт мөн.

Эрх зүйн зохицуулалтын байдал

◆ Усны тухай болон түүнтэй холбоотой бусад хуулийн заалтууд зарим талаар хэт ерөнхий, өөр эрх зүйн актаар зохицуулахаар заах зэргээр шууд зохицуулахаас зайлс хийсэн шинжийг агуулсан байдаг. Одоогийн дагаж мөрдөж буй Усны тухай хуулийн 23,24 дүгээр зүйлүүдэд ус ашиглагч байгууллага, албан тушаалтыг ус ашиглах, түүний үр дагаварын талаарх хүлээх үүрэг хариушлагыг нарийвчлан тодорхойлоогүй байна.

Сул тал

◆ Ус ашиглах гэрээнд заасан үүргээ гүйцэт биелүүлээгүй, хууль тоогтоомж зөрчсөн, усны эх үүсвэрийг бохирдуулсан тохиолдолд гэрээг шулах тухай зааснаас биш хохирол төлөх, нөхөн сэргээх болон бусад талаар хүлээх хариушлагыг заагаагүй.

◆ Түүнчлэн усны нөөц, чанарыг хамгаалах талаар хориглосон заалтыг зөрчвөл дээд тал нь 200000-250000 төгрөг, зөвхөн онцгой болон энгийн хамгаалалтын бусийн газрыг нөхөн сэргээхтэй холбогдсон зардлыг нөхөн төлүүлэхээр заажээ.

◆ Энэхүү хуульд усны нөөц, усны эх үүсвэр, усны хагалбарыг хамгаалах талаарх аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын эрх хэмжээ доогуур түвшинд байна.

◆ Ойн тухай хуульд: “Усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно” гэж заасан байхад уул заалтыг биелүүлэх явдал хангалтгүй байна.

◆ Мөн хуулийн 9.2 дугаар зүйлд: “Онцгой бүсийн цармын бүслүүрийн ойд унанги, гишүүг бэлтгэх, төрийн захиргааны байгууллагын баталсан жагсаалтын дагуу тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасан байdag.

◆ Гэтэл зарим бүслүүрийн ойд болон усны голрилд уул уурхай үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч байгаагаас гол горхи, булаг шанд ширгэх, бохирдох, урсац нь багасахад хүрч байна.

◆ Энэ нь усны нөөц багасч хүн ам ундны болон ахуйн хэрэгцээний усаар гачигдаж, усаар хангагдах эрх нь зөрчигдөхөд хүрч байна.

Бодлогын түвшинд авах арга хэмжээ

◆ Усан хангамж, ариун цэврийг сайжруулах асуудлыг төвлөрүүлж, төрийн оновчтой бодлого явуулж, чанарын шаардлага хангасан усаар тасралтгүй хангагдах хүний эрхийг хэрэгжүүлэх явдалтай уялдуулан зохицуулах.

◆ Дээрх асуудлыг 2002 онд Тогтвортой хөгжлийн дэлхийн чуулга уулзалтаар баталсан Йоханесбургийн хэрэгжилтийн төлөвлөгөө, НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2005-2015 оныг “Ус-амьдрал” олон улсын үйл ажиллагааны 10 жил тунхаглалын үзэл баримтлал, хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулах.

◆ Усны нөөц, хүртээмж, хангамж, эх үүсвэрийг хамгаалахтай холбоотой хуулийн хэрэгжилтийг судлан цаашид боловсрогуй болгох замаар эрх зүйн орчинг бүрдүүлэх

◆ НҮБ-ын мянганы хөгжлийн зорилтын хүрээнд дараахь асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

◆ Усны хангамж ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг сайжруулах замаар бохир устай холбоотой өвчлөлийг багасгах, урьдчилан сэргийлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах цогцолбор арга хэмжээг авах, бохир усыг зохих ёсоор ариутгаж зайлцуулах замаар экологийн системийг хамгаалах, цэвэр усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг бууруулах.

◆ Усны чанарыг энэ тэргүүнд тавьж, ус зөөлрүүлэгч, шүүгч болон ус цэвэршүүлэгч төхөөрөмжийг усны чанар шаардлага хангахгүй байгаа эх үүсвэрүүд тавих.

◆ Гадаргын усны нөөцийг зохистой хамгаалах, ашиглалтын горимыг боловсронгуй болгож, уул уурхайн салбарт ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд ус бохирдуулах буюу бохирдуулсан нөхцөлд дутуу цэвэрлэж усны нөөцөд сөрөг нөлөөлөл үзүүлдэг техник, технологийг нэвтрүүлэхгүй байх цогцолбор арга хэмжээг авах.

◆ Төв суурин газрын болон үйлдвэр, уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аль ч хэсэгт хөрс, ус агаарын бохирдлын зөвшөөрөгдөх нормын стандартыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж гаргах, үндны усны эх үүсвэрийн эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийг тогтоож, нөөцийг нэмэгдүүлэх асуудлыг бодлогын хэмжээнд цогцол нь шийдвэрлэх.

◆ Усны тухай болон байгаль орчны тухай хуулийн болон хүний усаар хангагдах эрхийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг бүх түвшинд зохион байгуулж, энэ талаарх хүмүүсийн ухамсарыг төлөвшүүлэх.

◆ Эдгээрийг нэн даруй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ДАЯАРШИЛ БА ХҮНИЙ ЭРХ

Г.Нарантуяа ХЭҮК-ын өргөдөл гомдол хариуцсан референт

Хүний эрх ба төрийн бүрэн эрхэт байдал хэмээх ойлголтын харилсан хамаарлыг хөндөх онолын цуврал өгүүмлүүдийн хоёр дахь хэсгийг та бүхний мэргэн оюунд толиуулж байна.

Өгүүлийн эхний хэсгийг “Хүний эрх” сэтгүүлийн 2006 оны 2 дахь дугаараас үзнэ үү.

Abstract:

There is now common illustration of people all around the world, who slipping on Nike sport shoes and Levis jeans, having lunch at the McDonalds and drinking Coke Cola. In any case, music that is listened to, information which are obtained or European alike environment which surrounds modern people are almost the same in all part of the world. This can be said as imitation of globalization in our life. Is there any possibility for the States to control the borderless globalization? Interests of the States and the theory of sovereignty which was affirmed by the United Nations are now changing. How the globalization affects in the implementation of human rights? That multidimensional process influences in the implementation of human rights in positive and negative way. Thus, this is a question how we could benefit more from the globalization process with least loss? In this article, I would aim to answer this question from the human rights perspective.

.....

“Леваис” жинс, “Найкэ” пүүзээр гоёж, “Мак Доналдс”-д үлдэн, “Кока кола”-гаар цангаагаа тайлагчид бол өнөө үеийн нийтлэг дүр төрх. Ядаж сонсдог дуу хөгжим, хүлээж авдаг мэдээ, мэдээлэл, хүрээлэн байгаа хотжин европжсон орчин хүртэл дэлхийн аль ч өнцөг буландаа бараг л ялгаагүй. Энэ бол даяаршлийн бидний амьдралд бууж буй дүр төрх билээ.

Хил хязгааргүй ижилсэх процесст төр хяналтаа тогтоох боломжтой юу? Дэлхийн улс орнуудын ашиг сонирхол, НҮБ-ын тунхагласан төрийн бүрэн эрхэт байдлын зарчмын онол өөрчлөгдэж байна.

Даяаршил хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэнд хэрхэн нөлөөлж байна вэ? Хүний эрхийн үүднээс өнөөг хүртэл тайлбарлаагүй, олон хэмжээст энэ үзэгдэл хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэнд сайнаар

ч, саараар ч нөлөөлж байна. Гагшүү иргэдийнхээ ашиг сонирхлыг дээд хэмжээнд хамгаалсан хэвээр төр бүрэн эрхээ хадгалах, хүний язгуур эрх, эрхэм зэргийг хангасан байдлаар даяарших нь хүн төрөлхтний өмнө тулгарч буй сорилт юм.

Даяаршил ба төрийн бүрэн эрхэт байдал:

НҮБ-ын Дүрмийн 2 дугаар зүйлийн 1-д “НҮБ нь бүх гишүүдийнхээ адил тэгш бүрэн эрхийн зарчим дээр үндэслэн” гэж заасан нь төрийн бүрэн эрхэт байдлыг баталгаажуулсан эрх зүйн үндэслэл юм. Өөрөөр хэлбэл энэхүү заалтын шаана улс гүрэн бүр өөрийн нутаг дэвсгэртээ хөнөлөнгийн ямар нэг оролцоогүйгээр засаглах, үндэсний хөгжлийн бодлогоо тодорхойлж, хэрэгжүүлэх бүрэн эрхтэй гэсэн агуулга бий. Харин өнгөрсөн зууны дунд үеэс хүний эрх, байгаль орчин, чөлөөт худалдаа зэрэг дэлхий нийтийг хамарсан асуудал олширч, тэдгээр асуудлуудыг олон улсын хамтын ажиллагааны үндсэн дээр шийдвэрлэх шаардлага бий болсны улмаас улс орнууд бүрэн эрхэт байдлынхаа зарим хэсгийг гэррээ, хэлэлцээрийн дагуу олон улсын байгууллагуудад шилжүүлэх болсон билээ. Тухайлбал, Дэлхийн Худалдааны Байгууллагын хөнгөлөлт, дэмжлэгийг хүртэхийн тулд чөлөөт худалдааг дэмжих, Олон Улсын Валютын Санглаас хөгжлийн зээл, тусламж авахын өмнө үндэсний валюын ханшийг тогтоох зэрэг арга хэмжээ авч, тэдгээр байгууллагуудын тогтоосон дүрэм журмыг улс орнууд зайлшгүй биелүүлж байна. Тодорхой асуудлаар бие даан шийдвэр гаргах төрийн эрх мэдлийг хязгаарлаж буй энэ мэт байдал нь даяарших үйл явцын хөрс суурийг бий болгож байгаа юм. Нөгөө талаас даяаршлын хөрсөн дээр ургасан үндэстэн дамнасан корпорациудын санхүүгийн чадавхи зарим улс орнуудын эдийн засгийн байдлаас хол илүүтэй болсон нь төрийн үйл ажиллагаанд бизнесийн байгууллагын зүгээс нөлөөлөх нөлөөллийг нэмэгдүүлж, төдий хэмжээгээр төрийн бүрэн эрхэт байдлыг хязгаарлахад хүргэж байна.

Төрийнбүрэнэрхэтбайдал, даяаршил, хүнийэрххэмээхойлголтуудын уулзвар цэг бол дэлхийн улс орнуудын интеграцилалд аливаа улс нэгдэхэл тавигдлаг хүний эрхийг хангаж, хамгаалах нөхчлийг бүрдүүлсэн байх тухай шаардлага юм¹. Төр өөрийн бүрэн эрхийн тодорхой хэсгийг

¹ Улс төр судлаач Ц.Мөнхцэцгийн “Даяаршил ба хөгжил дэвшлийн эсрэг үйл явц: Бутан, Турк, Монгол” өгүүлэлийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.

олон улсын байгууллагад шилжүүлэх, улмаар даяаршилд нэгдэхээр гэрээ хэлцэл хийхийн өмнө хүний эрхийн шаардлагыг биелүүлэх ёстой учир холбогалыг судлаачид янз бүрээр тайлбарладаг. Нэг хэсэг нь ийм байдлыг эдийн засгийн хөгжлөөр боомиж, “хүний эрх, эрх чөлөө” гэх барууны үзэл баримтлалыг тулган хүлээлгэж буй хэлбэр гэж үздэг байхад нөгөө хэсэг нь хөгжлийн үндэс нь хүний эрхэд нийцсэн байх явдалд учраас зүй ёсны шаардлага гэжээ. Аливаа бодлого, чиглэл, үйлдэл хүний сайн сайханд чиглэгдэхгүй, ийм шаардлагад нийшэхгүй байх аваас амьдрах чадваргүй, шударга бус болж хувирдааг учраас дэлхийн интеграцчилалын энэхүү болзол нөхцлийг хувьдаа талархан дэмжиж байдгаа илэрхийлье.

“Даяаршлын хууль”-ийг шинжлэхүй:

Хагас зуун илүү жилийн өмнө Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал батлагдаж “хүн бүр энэхүү тунхаглалд заасан эрх, эрх чөлөөт бүрэн эдлэж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй”² болохыг олон улсын хамтын нийгэмлэг хүлээн зөвшөөрсөн юм. Хүний эрхийн олон улсын стандартуудад заасанчлан нийгмийн болон олон улсын дэг журам нь хүний салшгүй эрхэм зэргийг хөхигүйн дэмжиж, улс түмний өөртөө засан тохинох эрхийг хүндэтгэн, үл алагчлал болон оролцоонд тулгуурласан нийгмийн хөгжил дэвшилд хүрэхэд чиглэгдсэн байх ёстой. Тийм учраас даяаршил нийгмийн болон олон улсын нийтлэг дэг журам тогтоодог гэх утгаараа хүний эрхийн олон улсын хэм хэмжээний үндсэн зарчимд сууриссан байх учиртай. Нөгөө талаас, Тариф, Худалдааны Ерөнхий Хэлэлшээр (GATT) болон Дэлхийн Худалдааны Байгууллагын (WTO) тогтоосон дүрэм журам, Олон Улсын Валютын Сангийн (IMF) макро эдийн засгийн бодлогууд ч мөн өнөөгийн даяарших үйл явцыг удирдан чиглүүлэхэд чухал үүрэгтэй. Иймээс оролцоо, үл алагчлал, эрх мэдэл олголт, хариушлага гэсэн зарчмуудад үндэслэсэн хүний эрхийн олон улсын эрх зүйн хэм хэмжээг чөлөөт худалдаа, эдийн засгийн өсөлт, хөдөлмөр эрхлэлт, тулхтай хөгжилд тэмүүлэх дэлхийн эдийн засгийн зорилтуудтай хэрхэн уялдуулснаас хүн бүр эрх, эрх чөлөөгөө бүрэн элэж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журмыг бий болгох асуудал шууд хамаарах болно.

² Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал 28-р зүйл

Дэлхийн Худалдааны Байгууллагын хэлэлцээрүүдийн зорилго нь гишүүн улсуудын аж ахуйн нэгж, байгууллагуудад шударгаар өрсөлдөх боломжтой, чөлөөтэй бөгөөд хуульд нийцсэн олон талт худалдааны тогтолцоог бий болгох явдал юм. Энэхүү зорилгын хүрээнд тус байгууллага нь амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эрэлтийг ихэсгэх болон байгалийн баялгийг аль болох зөв зохистой ашиглах замаар бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, худалдааг дэмжих зорилтуудыг дэвшүүлсэн тавьсан байна. Түүнчлэн Дэлхийн Худалдааны Байгууллагын хэлэлцээрүүдэд улс орнуудыг үл алагчлах зарчмыг хүндэтгэн сахиж, худалдааны саал тогторыг арилгахад чиглэгдсэн дүрэм журмыг бий болгох замаар дээрх зорилтуудад хүрэхээр тодорхойлжээ. Мөн эдгээр хэлэлцээрүүдэд буурай хөгжилтэй болон хөгжиж байгаа улс орнуудад туслалцаа үзүүлэх, урт хугацааны зээллэг олгох зэрэг тааламжтай нөхцлүүдийг бий болгохоор заасан байдаг. Үүнээс Дэлхийн Худалдааны Байгууллагын дэвшүүлэн тавьсан зорилго, зорилтууд хүний эрхийн олон улсын зарчим, хэм хэмжээтэй ихээхэн төсөөтэй болох нь харагдаж байна. Тухайлбал, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, эрэлтийг ихэсгэх болон байгалийн баялгийг аль болох зөв зохистой ашиглах замаар бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, худалдааг хөгжүүлэх асуудал нь хөгжих эрхийн үндсэн агуулга юм. Түүнчлэн шударга өрсөлдөөн, худалдааны эрх зүйн хүрээнд үл алагчлах зорилт нь хүний эрхийн алагчлахгүй байх зарчимтай нийцэж байна. Мөн шаардлагатай улс орнуудад хөгжлийн туслалцаа үзүүлж байх тухай заалтууд нь хүний эрхийн онолд тодорхойлсон “эерэг үйлдэл”³ мөн.

Олон улсын худалдааны дүрэм журмуудыг хэм хэмжээ талаас нь авч үзэхэд хүний эрхийн олон улсын зарчимтай нийцэж байгаа мэт боловч эдгээр нь практикт бүрэн хэрэгжих бололцоотой юу? гэсэн асуулт дээрх дүгнэлтээс зүй ёсоор урган гарах нь дамжиггүй. Харамсалтай нь даяарших үйл явцын хурласгуур болсон эдийн засгийн байгууллагуудын дүрэм журам тэр бүр хэрэгжих бололцоогүй байна. Тухайлбал, Дэлхийн Худалдааны Байгууллагын хүрээнд байгуулагдсан Оюуны өмчийн эрхийн худалдаанд холбогдох зүйлийн талаарх хэлэлцээр (TRIPS Agree-

³ Affirmative actions хэмээх ойлголтыг Виктор Кондегийн “Хүний эрхийн нэр томъёоны гарын авлага”-д ийнхүү оруулизжээ. Түүхийн өнгөрсөн хугацаанд эмэгтэйчүүд, зарим үндэстэн ястан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт бүлгүүдийн зарим эрхийн хэрэгжилтэнд төрийн зүгээс ялагвартай хандаж байсны хор уршигийг арилгах үүднээс тэдгээр хүмүүст тусгайлан давуу тал олгож байгаа үйлдлийг ийнхүү нэрлэдэг.

мент)-ийн хэрэгжилтээр жишээ татья. Энэхүү баримт бичигт хэдийгээр нутгийн уугуул болон алслагдсан хөдөөх иргэдийн оюуны өмчийн эрхийг хамгаалах тухай заалт байдаг боловч эдгээр хүмүүсийн шинжлэх ухааны салбарт хувь нэмрээ оруулсан туршлага, мэдлэг шударгаар үнэлэгдэхгүй, үнэлэгдэх бололцоогүй байна⁴. Ялангуяа биотехнологи, анагаах ухаан, байгаль орчны салбарт эртний уламжлалт мэдлэг, туршлагыг үндэслэн бий болгосон оолт, дэвшил олон бий боловч үүнээс олсон орлогоос жинхэнэ зохиогчид нь хувь хүртэж чадахгүй байгаа юм. Хүний эрхийн үүднээс анхаарал татаж буй өөр нэг асуудал бол Дэлхийн Худалгааны Байгууллагын гэрээ, хэлэлцээрүүдэд үндэстэн, ястан өөрсдийн соёл уламжлалаа хадгалж үлдэх эрхийг хангахтай холбоотой эрх зүйн хэм хэмжээ байхгүй байгаа явдал юм⁵. Даяар эдийн засгийн гэрээ, хэлэлцээрүүдийг зөвхөн дээр дурдсан талаас нь авч үзэхэд эдгээрийг хүний эрхийг хамгийн дээд хэмжээгээр хангах байдлаар өөрчлөн хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилт 21 дүгээр зууны даяаршилд:

Даяаршил бол цоо шинэ үзэгдэл биш. Филиппины нийгмийн зүтгэлтэн Роберто Верзола нэгэнтээ “өнөө үеийн даяаршил бол хоёр зуун жилийн өмнөх колоничлолын үргэлжлэл”⁶ гэжээ. Колонийн эрх мэдэл бүхий үндэстэн дамнасан корпорациудын үйлдэл, түүний үр дагавраас ажиглахад энэ үг үнэний хувьтай байж болох. Ямартаа ч энэ эрин үеийн даяаршил мэдээлэл харилцаа холбооны шинэ технологи, хямд өртөгтэй, хурдан шуурхай тээвэр, чөлөөт худалдаа, санхүүгийн урсгалын хурдаа, тэгээд мэдээж хүчирхэг үндэстэн дамнасан корпорациудын тооны өсөлт зэргээрээ урьд өмнийн ижилсэх үйл явцаас маш том ялгаатай. Энэ ч утгаараа даяаршил бидний өмнө цоо шинэ басхүү тулгам асуудлуудыг бий болгож байгаа юм. Харин гэрлийн хурдаар өрнөх энэ нөхцөл байдал хүний эрхийн хэрэгжилтэнд хэрхэн нөлөөлж байна вэ? Асуултанд даяарших үйл явцын мөн чанарыг харуулах доорх цөөн хэдэн салбарын хүрээнд хариулахыг оролдьё.

⁴ TRIPS хэлэлцээрт уугуул болон хөдөөх иргэдийн оюуны өмчийн эрхийг хамгаалах талаар харьяалах улсын төр, засгийн зүгээс арга хэмжээ авах тухай заалт байхгүй.

⁵ Өгүүллийг бэлтгэх зорилгоор зөвхөн Дэлхийн Худалдааны Байгууллагын гэрээ, хэлэлцээрүүдэд соёлын эрхийн холбогдолтой зүйл заалт байгаа эсэхийг авч үзсэн болно.

⁶ Verzola Robert, Asia-APEC internet message, August 16, 1996.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил бол яахын аргагүй даяаршлын мөн чанар мөн. Дэлхийн хаанаас ч маш хямд ёртгөөр, хоромын дотор холбогдох, мэдээллийн их урсгалд нэвтрэх боломжийг интернэт хүн төрөлхтөнд авчирсан билээ. Хямд, шуурхай харилцаа холбооны энэхүү технологийг хэрэглэгчдийн тоо маш хурдастайгаар өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, 1998 онд интернэт хэрэглэгчдийн тоо 140 сая байсан бол 3 жилийн дотор энэ тоо 700 сая болтлоо өсөх тухай тооцоог НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр 1999 онд хийжээ⁷. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил нь боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн салбарт ихээхэн ахиц дэвшлийг бий болгож байгаа бөгөөд энэ ч утгаараа хүний эрхийн хэрэгжилтэд сайнаар нөлөөлж байна. Нөгөө талаас интернэтын ачаар хүний эрхийг хамгаалагчдын сүлжээ урьд өмнө байгаагүй ихээр нягтарч, дэлхийн улс орнуудын хүний эрхийн байгууллагуудын хамтын ажиллагаа өргөжин тэлэх болжээ. Гэсэн хэдий боловч мэдээллийн технологийн энэхүү дэвшил дэлхийн улс орнуудад тэгш байж чадахгүй байгаагаас нь улс орнуудын дунд ялгавартай байдал үүсч байна. Дэлхийн Банкны хийсэн судалгаагаар өндөр хөгжилтэй орнуудын 10000 хүн тутамд 607 интернэтын үйлчилгээ түгээгч оногдож байхад Сахар орчмын Африк, Зүүн Азийн орнуудын 10000 хүн тутамд 2 буюу 0.17 интернэтын үйлчилгээ түгээгч оногдож байна⁸. Энэ байдлыг НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр “мэдээллийн технологи хөгжил хэдийгээр хүний хөгжилд зерэг нөлөө үзүүлж байгаа боловч зарим бүлгүүдийн хувьд ялаатай байдлыг үүсгэж байна” гэж дүгнэжээ. Түүнчлэн интернэтийг хүний эрхэм зэрэг, эрх, эрх чөлөөнд харш байдлаар ашиглах явдал түгээмэл байна. Тухайлбал, интернэтээр порнограф, арьс үндсээр алагчлах үзэл, шашны эсрэг ухуулга сурталчилгаа, хүний нэр төрл халдаж, өдөөн хатгасан агуулга бүхий мэдээлэл дамжуулагдаж байгаа нь хүний эрхийн зарчимд нийцэхгүй байна. Интернэтээр дамжуулан түгээх мэдээллийн агуулгад хяналт тавих техникийн боломжгүй байдал нь хүний эрхийг хангах төр, засгийн үүрэгт хүндрэл, бэрхшээлийг бий болгож байгаа юм.

Худалдаа, санхүүгийн урсгалын чөлөөт байдал нь даяаршлын хөрс суурь болох тухай дээр дурдсан билээ. Дэлхийн улс орнуудын

⁷ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Хүний Хөгжлийн Илтгэл 1999, Оксфордын Их Сургуулийн Хэвлэл, Нью Йорк, 1999 хүү 5

⁸ Дэлхийн Банк, Дэлхийн Хөгжлийн Индикатор 2000, Вашингтон ДС, 2000 хүснэгт 5.12

бүтээгдэхүүн, үйлчилгээний экспортын хэмжээ асар хурдан нэмэгдэж байна. 1990 онд дэлхийн нийт экспортын бүтээгдэхүүний хэмжээ 4.7 триллион ам.доллар байсан бол 1998 онд 7.5 триллион болсон тухай НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн илтгэл дурдагдсан байна. Худалдааны чөлөөт байдал нь улс орнуудад ядуурлаас ангижрах, ядуурлын үндсэн дээр бий болдог хүний эрхийн зөрчилтэй асуудлуудыг шийдвэрлэх таатай боломж олгодог нь мэдээжийн хэрэг. Гэвч худалдааны саад тогторыг арилгах, олон улсын худалдааг хөгжүүлэх үйл явц хүний эрхийн хэрэгжилтэд бүхэлдээ зөрөөг нөлөөллийг авчрахгүй байна. Тухайлбал, олон улсын чөлөөт худалдаанаас улс орнууд тэгш үр ашиг хүртэж чадахгүй байгаа юм. 1998 онд дэлхийн хүн амын 10% нь оршин суудаг буурай хөгжилтэй улс орнуудын экспортосон бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дэлхийн нийт экспортын хувийг 0.4%-ийг эзлэж байсан статистик үзүүлэлт гарчээ. Энэ нь эдгээр улс орнууд 1980-аад онд дэлхийн нийт экспортын бараа, үйлчилгээний 0.6%-ийг, 1990-ээд онд 0.5%-ийг тус тус гаргаж байсантай харьцуулахад буурчээ.⁹ Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалттай холбоотой статистик үзүүлэлтээс бил үүнтэй ижил төстэй дүр зургийг харж болно. 1998 онд дэлхийн эхний аравт багтах өндөр хөгжилтэй орнууд нийт гадаадын хөрөнгө оруулалтын 70%-ийг хүлээн авсан байна. Эдгээр тоон үзүүлэлтүүд чөлөөт худалдаанаас улс орнууд тэгш ашиг хүртэж чадахгүй байгааг харуулж байна. Нөгөө талаас олон улсын худалдааг саад тогторгүй болгох үйл явцын цаана хүний эрх, эрх чөлөөнд харш үйлдлүүд гарсаар байна. Тухайлбал, хууль бус зэвсэг хэрэгсэл, хар тамхины наймаа болон хүн худалдаалах гэмт хэргүүд өсөн нэмэгдэж байгаа нь хүний эрх ноцтой зөрчигдөхөд хүргэж байна. Түүнчлэн худалдааны чөлөөт байдлын далбаан дор орлого багатай, буурай хөгжилтэй далайн улс орнуудын эрэг орчимд химиин хортой хаягдал хаях, үүний үр дагавар нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө учруулах гэмт үйлдэл гарсаар байна.

Үндэстэн дамнасан корпорациуд урьд өмнө байгаагүй ихээр хөгжсөн нь энэ эрин үеийн даяаршлын онцлог юм. Ажиллах хүчний хямд өртөг, байгалийн нөөц баялаг, хөрөнгө оруулалт татах зорилгоор бий болгосон хууль эрх зүй, бүтэц, зохион байгуулалтын таатай нөхцөл зэргээс нь болж үндэстэн дамнасан корпорациуд үйлдвэрлэлийн баазаа хөгжих байгаа орнуудад байршуулах болжээ. НҮБ-ын Нийгмийн Хөгжлийн

⁹ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Хүний Хөгжлийн Илтгэл 2000

Судалгааны Хүрээлэнгийн хийсэн судалгаанаас харахад үндэстэн дамнасан нэг корпорацийн жилд үйлдвэрлэдэг нийт бүтээгдэхүүний хэмжээ Чили, Коста Рико, Эквадор зэрэг гурван улсын үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээнээс илт давуу байна¹⁰. Эдийн засгийн хувьд хүчирхэг үндэстэн дамнасан корпорациуд өөрт ашигтай шийдвэр гаргуулахаар төрийн үйл хэрэгт хөндрөнгөөс нөлөөлөхийг оролдох хандлага түгээмэл ажиглагдаж байна. Ялангуяа ашгийн байгууллагууд байгалийн нөөц, баялгийг ашиглах талаар давуу эрх эдлэх, нутгийн уугуул иргэд болон мал аж ахуй, газар тариалан эрхлэгчдийг ус нутгаас нь нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргуулах зэргээр хүний эрх, эрх чөлөөг хөндсөн үйл ажиллагаа явуулсан тохиолдол цөөнгүй гарчээ. Түүнчлэн аливаа улс орны зах зээлд үндэстэн дамнасан корпорациуд үйлдвэрлэл явуулж, бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргах болсон нь өрсөлдөх чадвар дорой тухайн улсын үндэсний жижиг аж ахуйн нэгж, тэдгээрийн ажилтнуудын хувьд томоохон цохильт болж байна. Гэхдээ корпорациудын өсөлт хөгжил үргэлж таагүй нөлөө дагуулж байна гэвэл худлаа. Ажлын байрыг нэмэгдүүлэх, цалин хөлсний түвшинг ахиулах, технологи нэвтрүүлэх болон үндэсний эдийн засгийн өсөлтөд корпорациудын өсөлт сайнаар нөлөөлж байна. Үүна гагчүү корпорациудын үйл ажиллагаанд хүний эрхийн зарчмыг баримтлан ажиллах явдлыг хэвшүүлэх, үндэстэн дамнасан корпорацид тавих хүний эрхийн шаардлагыг өндөржүүлэх, энэ шаардлагыг хэрхэн хангаж ажиллаж байгаад тавих төрийн хяналтыг сайжруулах явдал түйlyn чухал байна. Сүүлийн жилүүдэд олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс бизнесын байгууллагууд хүний эрхийн зарчимда суурилсан үйл ажиллагаа явуулж байх нийтлэг дэг журмыг бий болгох талаар нэлээдгүй хүчин чармайлт гаргаж байгаа билээ. 1999 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын санаачлагаар эдийн засаг, санхүү, бизнесийн үйл ажиллагаанд мөрдөх есөн зарчмыг Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон хүний эрхийн бусад стандарт хэм хэмжээ, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гэрээ, конвенцийн зарчимда нийцүүлэн тодорхойлсон нь чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон юм. 2000 оны 7-р сард НҮБ-аас дэлхийн эдийн засгийн удирдагчдын оролцоотойгоор “Глобал Компакт” хэмээн нэрлэгдэх энэхүү санаачлагыг албан ёсоор эхлүүлэх арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээний үеэр бизнесийн тэргүүлэх корпорациуд есөн зарчмыг дагаж мөрдөхөө нэгэн дуугаар илэрхийлсэн юм.

¹⁰ United nations Research Institute for Social Development, States of Disarray: The Social Effects of Globalization, report on the World Summit for Social Development, Geneva, March 1995 p.153.

Дэлхий ертөнц хүссэн ч, хүсээгүй ч даяаршиж, хил хязгааргүй ижилсэх энэ үйл явц төрийн хүсэл зоригийг тэр бүр асуухгүй байна. Гэвч төр бүрэн эрхээ зохист харьцаагаар хадгалан, иргэдийнхээ эрх ашгийг дээд хэмжээгээр хангасан байдлаар даяаршлаас ашиг хүртэх нь улс орны эрхэм дээд сонирхол байх ёстай. Эдийн засгийн интеграцилалт төрийн саналыг сонгох ганц л цэг бий гэвэл та зөвшөөрөх үү? Үүнийг би олон улсын гэрээ байгуулах үйл явц гэж хэлмээр байна. Энэ цэг дээр л төр, засгийн байгууллагууд “ухаалаг байж”, хэдий чинээ өөрт ашигтай шийдвэрлэл хүрч чадна төдий чинээгээр даяаршлаас эерэг үр дүн хүртэх боломжтой гэж миний бие үзэж байна. Нөгөө талаас даяаршлын дагаар ирэх олон үр дагавараас аль болох хүний сайн сайхан байдалд нийцэхийг хүлээн авч, сөрөг нөлөөллийг багасгахын тулд дэлхийн эдийн засгийн дэг журмыг хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэх болон бизнесийн байгууллагуудад хүний эрхийн соёлыг түгээн дэлгэрүүлэх нэр их ажилд бил хүчин зүтгэх ёстай.

Номзүй:

1. М.Дүгэrsүрэн, О.Хосбаяр “Олон улсын эрх зүй” Улаанбаатар, 1999 он
2. Хенри Ж.Стайнер, Филип Элстон “Хүний эрх: эрх зүй, улс төр, ёс сууринхууны асуудлууд” 1-р дэвтэр
3. Эмнэсти Интернэшнл, “Бизнесийн үйл ажиллагаан дахь НҮБ-ын хүний эрхийн хэм хэмжээ: Хууль зүйн хариуцлага тооцохын төлөө”
4. Х.Виктор Конде, Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага, 1999 он
5. Gene M.Lyon, James Mayal, “International human rights in the 21st century” 2003
6. Paul Gordon Lauren “The evolution of international human rights” 2003
7. UN General Assembly “Globalization and its impact on the full enjoyment of all human rights” 2000
8. “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн тусгай дугаар, 1-р боть, 2004 он
9. www.wto.org
10. www.forum.mn

ХҮНИЙ ЭРХ БА БОЛОВСРОЛ

ХЭҮК-ын Боловсрол хариуцсан референт Ч.Алтангэрэл

Хураангуй:

Хүний эрх нь хүн төрөлхтөний нийтлэг үнэт зүйлс болон хүлээн зөвшөөрөгдөж, улмаар хөгжлийн бодлогын гол чиг баримжаа болж байна. Гэвч хүний эрхийн үзэл санаа, эрхэм сайхан амалтууд бодит харилцаанд хэрэгжихэд зохих саад бэрхшээлүүд байсаар байна. Тиймээс хүний эрхийг хангах, хамгаалах үйлсэд “боловсрол” чухал ач холбогдолтой болохыг сүүлийн ихээхэн анхаарч байгаа билээ. Үүний хамт “боловсрол”-ыг авч үзэх үзэл баримтлал ихээхэн өөрчлөгдөж, түүний зорилго, үр дүнг “эрхэд сууриссан” байхаар харж, хүлээж байгаа билээ. Зохиогч энэхүү өгүүллийн хүрээнд “хүний эрх” ба “боловсрол” хоёрын уялдаа хамаарал, тэдгээрийг нэгтгэгч ойлголтын тухай авч үзэн, та бүхэнтэй санал солилшохыг зорьсон болно.

-
- ◆ Хүний эрхийн боловсрол гэж юу вэ?
 - ◆ Эрхэд сууриссан боловсрол олгох уу? Эсвэл
 - ◆ Боловсролоор хүний эрхийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх үү?

Өдгөөдэлхийнийтэд хүний эрхийг хангах, хамгаалах, хэрэгжүүлэхийн төлөө хөдөлгөөн өрнөж байна. Энэхүү хөдөлгөөн нь нийгэмд шударга ёс, тэгш байдал, ардчиллыг тогтоох, хөгжлийн бүтээмж, үр ашгийг хүртээмжтэй, харилсан тэнцвэртэй хуваарилах, хүрээлэн буй байгаль орчноо хамгаалах, түүх соёлын дурсгал, үндэсний хэл бичиг, нэг зүйлээ хадгалах, дайны аюул заналыг устгах, эмэгтэйчүүд хүүхдийн эрхийг хамгаалах, хүн бүрт боловсролыг жигд тэгшээр хүртээх зэрэг олон талт зорилго бүхий цогц үйл явц болон өрнөж байна. Энэ бүх зорилго, үйл явц нь “ХҮНИЙ ЭРХ” хэмээх нэгтгэгч ойлголтонд тулгуурладаг бөгөөд энэ утгаараа ч хүний эрх нь нийтлэг үнэт зүйлс болсон юм. Тийнхүү хүний эрхийг чухалчлан үзэхийн зэрэгцээ “хүний эрхийн боловсрол” хэмээн хамтатган авч үзэх, хэлэлцэх нь түгээмэл боллоо.

Тиймээс “хүний эрхийн боловсрол гэж юу болох, түүний хэрэгцээ шаардлага, ойлголт үзэл баримтлал, энэ талаар дэвшигдэн гарч буй олон улсын бодлого, санаачлагууд зэргийг багшлан авч үзэх шаардлагатай байна.

Юуны өмнө сурч боловсрох явдал нь хүний үндсэн эрх, эрх чөлөөгээж үздэг. Энэ тухайд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 26-р зүйлд “Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болгоход чиглэх ёстай. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биенээ ойлгох, хүлшэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахин хамгаалах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстай.” хэмээн заасан. Түүнчлэн Хүүхдийн эрхийн конвенцид дээрхи үзэл санааг улам бүр өргөтгөн, бага дунд болон мэргэжлийн боловсролыг эзэмших, хөгжих ижил тэгш бололшоотой байхыг (Зүйл 28) баталгаажуулсан байдаг.

Элгээрээс үзвэл дэлхий нийтээр боловсролын үүрэг, ач холбогдол, зорилгыг өөрөөр авч үзэх болсон нь илэрхий байна. Тухайлбал, “аливаа сургалт нь тухайн шинжлэх ухааны суурь мэдлэгийг олгоход чиглэх ёстай” хэмэхээс татгалзаж, боловсролын зорилго нь хүний хөгжлийг хангах, тухайн хүнд нийгмийн зэрэг, үнэт чанаруудыг төлөвшүүлэх, нийгмийн харилцаанд бие даан, идэвхи санаачлагатай оролцох боломжийг бүрдүүлэхэд чиглэх явдал хэмээн тодорхойлж байна. Үүний үр дүнд боловсролын зорилго нь өөрчлөлт шинэчлэлтэд дасан зохицох, ардчилсан нийгэмд амьдрах, оролцох, шийдвэр гаргах чадвар бүхий, эрх үүргээ ухамсарласан иргэнийг төлөвшүүлэхэд чиглэх болжээ.

Дэлхийн Банкны Ерөнхийлөгч асан Жеймс Д. Волфенсон “Боловсрол ба Хөгжил” хэмээх илтгэлдээ “Боловсрол бол Мянганы Хөгжлийн Зорилтона хүрэх хөшүүрэг мөн”¹¹ гэж дүгнэсэн байдаг. Боловсрол бол энэхүү зорилтуудыг хангах үндсэн хөшүүрэг мөн бөгөөд улмаар дэлхий нийтийг хамарсан глобаль асуудлуудыг шийдвэрлэх үндэс суурь болно хэмээн тэрээр үзжээ. Нийгэм дэх өөрчлөлтүүд нь нэгэн талаас боловсролын үр дүн, нөгөө талаас мөн боловсролын хөгжлийн чиг

¹¹ James D. Wolfensohn “Education and Development” <http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/TOPICS/EXTCY>

баримжaa нь болох ёстай. Учир нь нийгэм дэх аливаа хөгжил дэвшлийн уг үндэс суурь нь тухайн үеийн боловсролын тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлттэй шууд уялан холбогдох нь тодорхой.

Бидний авч үзэж буй “хүний эрхийн боловсрол” хэмээх нэр томъёо нь “хүний эрх” ба “боловсрол” хэмээх хоёр ойлголтоос бүрдэж байна. Тиймээс энэхүү нэгтгэгч ойлголтыг нэр томъёоны хувьд болон ойлголтын агуулгын түвшинд тайлбарлахыг оролдвол:

“Хүний эрх” ба “боловсрол” хоёрын хоорондын харилцааг дараахи 3 хандлагаар дамжуулан судлаачид тодорхойлдог ажээ. Үүнд:

1. “Хүний эрхийн боловсрол” (Human Rights Education)
2. “Боловсролоор хүний эрхийг” (Human Rights through Education)
3. “Боловсрол дахь хүний эрх” (Human Rights in Education)

Эдгээр хандлагууд нь өөр хоорондоо ялгаатай, бие даасан ойлголт боловч мөнхүү хоорондоо харилсан хамааралтай байдаг. Эдгээр хандлагуудыг тус бүрд нь хийгээд нийтлэг байдааr авч үзье.

I. “Хүний эрхийн боловсрол” (Human Rights Education)

“Хүний эрхийн боловсрол” хэмээх нь хүн өөрийн эрх, эрх чөлөөний тухай танин мэдэх, ойлгон ухаарах, эрхээ эдлэх, хэрэгжүүлэх чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн суралцахуйн болон сургахуйн үйл явц хэмээн тодорхойлдог. Хүний эрхийн боловсрол нь аливаа хүн өөрийн “хүн” хэмээх эрхэм чанараа ойлгон ухаарах, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэн харилцах, асуудлыг хүчирхийлийн бус аргаар шийдвэрлэх, хүний эрхийн бүх хэлбэрийн зөрчил, эрслээс урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн боловсролын нэгэн салбар гэж үзэх болсон юм.

НҮБ-ын баримт бичгүүдээд “Хүний эрхийн боловсрол нь мэдлэг олгох, хандлага төлөвшүүлэх замаар хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, түүний бие даасан байдал, найрамдал нөхөрлөл, харилсан итгэлцэл, тэгш эрх зэргийг хүндэтгэн, чөлөөт нийгэмд хүн бүр оршин амьдрах бололшоотой байхад чиглэсэн боловсролын салбар” хэмээн тодорхойлдог. Энэ утгаараа хүний эрхийн боловсрол нь “хүний эрхийн

соёл” хэмээх ойлголттой шууд холбогддог. Хүн бүрийн “хүн” хэмээх эрхэм чанарыг хүндэтгэн харилцах, хүлшэн тэвчих, эвсэн найрамдах, хамтран ажиллах, аливаа зөрчилдөөн маргааныг хүчирхийлийн бус аргаар шийдвэрлэх зэрэг нь эдгээр соёлын үндсэн агуулга юм.

II. “Боловсролоор хүний эрхийг” (Human Rights through Education)

Энэ нь хүний эрхийн тухай мэдлэг, ойлголт, үзэл санааг боловсролын арга хэлбэрээр дамжуулан нийгэмд түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий үйл явцыг тэмдэглэсэн ойлголт юм. Өөрөөр хэлбэл аливаа сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээ зэрэг бүхий л бүрэлдэхүүн хэсгүүд нь хүний эрхийн тухай мэдлэг, ойлголт, түүнийг эрхэмлэн мөрдөх, дээдлэх хандлагыг тухайн шатны суралцагчадад бий болгоход эрмэлзэх явдал юм.

Өнөөдрийн суралцагчид нь маргаашийн шийдвэр гаргагчид учраас тэдний эзэмшиж буй боловсрол нь цаашдын хөгжлийн хандлагыг тодорхойлох билээ. Тэлгээр суралцагчид оролцоот ардчилсан нийгэмд амьдарч, шударга ёс, эрх чөлөө, хууль ёсыг эрхэмлэн, хүний нэр төр, амьдралын ялгаа, хэв маягийг хүлээн зөвшөөрч, олон соёлт орчинд амьдарч сурх нь хожмоо тийм зүй ёсны нийгмийг бүтээн байгуулах үндэс болно. Иймээс суралцагчид одоогийнхоос илүү өргөн хүрээтэй, амьдралаас урган гарсан хүний эрхийн боловсролыг эзэмших нь чухал. Өөрөөр хэлбэл, тэдний үзэж буй хичээлийн агуулга, сургалт зохион байгуулж буй арга зүй, ном хэрэглэгдэхүүн зэрэг нь хүний эрх, эрх чөлөө ардчилал, шударга ёс зэргийн тухай зөв ойлголт өгч, чадваржуулахад чиглэх шаардлагатай. Гэхдээ хамгийн гол нь суралцагчид “хүний эрх, ардчилал, шударга ёс” зэрэг нь ямар нэгэн хийсвэр нэр томьёо биш, анги танхим, гэр орон, найз нөхөд, хамт олон зэрэгтэй нь холбогдох бодит амьдралын асуудал гэдгийг ойлгон ухаарах ёстой.

Хэдийгээр хүний эрхийг зааж сургах, нийгэмд төлөвшүүлэх арга хэмжээ нь олон хэлбэртэй байдаг боловч олонхи мэргэжилтнүүд “хүний эрхийг тусгай нэмэлт хичээлээр бус харин одоогийн мөрдөж буй сургалтын агуулга, хөтөлбөрүүдэд нягт уялдуулан шингээж өгөх нь илүү үр дүнтэй” хэмээх дүгнэлтэнд санал нийлдэг ажээ. Хүний эрхийн

боловсролыг ерөнхий боловсролын агуулгатай нэгтгэн интеграцичлах оролдлого зарим улсуудад амжилттай хэрэгжиж буй боловч олон улсын түвшинд авч үзвэл эхлэлийн байдалтай байна гэж үздэг.

III. “Боловсрол дахь хүний эрх” (Human Rights in Education)

Боловсролын үйл ажиллагаа нь тухайн харилцаанд оролцогчдын эрх, эрх чөлөөг хүндэтгэх, эрхээ эдлэх баталгааг хангах ёстай. Ялангуяа сургалтын үйл явцад боловсролын харилцааны гол субъектууд болох сургач хүүхэд, өсвөр үеийнхэн өөрийн эрх, эрх чөлөөгөө бүрэн эдэлж, аливаа зөрчил, халдлага, дарамт, ялгаварлан гадуурхалт зэргээс ангидаа байх ёстай.

Нөгөө талаас сургалт, боловсролын үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн хүндэтгэх, аливаа алагчлах хэлбэрүүдээс татгалзах, эв нэгдэл, найрамдал нөхөрлөлийг дэмжих зэрэг хүний эрхийн үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэхэд чиглэх ёстай гэж үздэг.

Хүүхэд насны ихэнх цаг хугацаа гэр бүл, сургууль хэмээх нийгмийн институтын хүрээнд өнгөрч байдаг. Гэтэл гэр бүл, сургууль зэрэг нь хүүхдийн хөгжлийг хангах, нийгмийн харилцаанд бэлтгэх, эрхийг нь хүндэтгэх, хамгаалах гол байгууллага, орчин хэдийч сургуулийн орчин нь хүүхдийн эрхийн зөрчилд хүргэх гол шалтгаан болсоор байна. Ялангуяа багш нар болон бусад үе тэнгийнхэн нь хүүхдийн эрхийг зөрчих үзэгдэл олон оронд хүний эрхийн түгээмэл зөрчил хэмээн тооцогддог ажээ. Манай улсад ч боловсрол дахь хүүхдийн эрхийн зөрчилтэй холбогдсон нэлээд тооны судалгааны ажил хийгдэж, эдгээр зөрчлүүд их байгааг тогтоосон байна.

Харин өнөөгийн үзэл баримтлалын хувьд “Боловсрол дахь хүний эрх” болон “Боловсролоор хүний эрхийг олгох” гэсэн дээрх хандлагууд нь нэгдэн “Хүний эрхийн боловсрол” хэмээх үзэл баримтлалыг илэрхийлнэ хэмээн ойлгож болох юм. Учир нь хүний эрхийн боловсрол нь өөрийн болон бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэн харилцах, үүрэг хариуцлагаа ухамсарлах, зөв, шударга үйлдэх зэрэг үнэт зүйлсийг боловсролын арга хэлбэрээр дамжуулан нийгмийн гишүүдэд түгээж байдаг билээ. Уг хандлагыг мөн “Эрхэд сууриссан чанартай боловсрол” хэмээн томьёолсон байдал ч ажиглагдаж байна.

Ерөөс дэлхий нийт өөрсдийн хөгжлийн бодлого, чиглэлийг “хүний эрхэд суурilan хөгжих хандлага”¹² хэмээн тодорхойлох болсон. Иймд боловсролыг авч үзэх үзэл баримтлал ихээхэн өөрчлөгдөж, бидний хэлэлцэн буй “хүний эрхийн боловсрол” зэрэг шинэ шинэ утга агуулгаар баяжик хөгжиж байна.

Тухайлбал, дээрх зорилгыг хэрэгжүүлэх нэгэн тулгуур үндэс нь “Эрхэд суурисан чанартай боловсрол” олгох байдлаар хүний хөгжлийг дэмжих, чөлөөт ардчилсан нийгмийг байгуулах явдал хэмээн үзэж байна. “Эрхэд суурисан чанартай боловсрол” гэдэг нь боловсролын тогтолцоо болон сургалтын бүхий л орчинд хүний эрхийг дээдлэн хүндэтгэх, нөгөө талаас сургалт боловсрол нь хүн бүрийг хүндэтгэх, энх тайван, нийгмийн зөвшшиллийг дэмжих үнэлэмжийг баримжаалах явдал хэмээн тодорхойлдог. Энэ утгаараа “хүний эрхийн боловсрол нь чанартай боловсролын гол цөм байна”¹³ хэмээн тодорхойлжээ.

Яагаад хүний эрхийн боловсрол хэрэгцээтэй вэ?

Яагаад хүний эрхийг тусгай сургалт, боловсролоор дамжуулан сурч мэдэх ёстой вэ? Мэдээлэл харилаа технологи өндөр хөгжиж, хүн бүхэн цаг нартай уралдан ажиллаж байгаа үед цаг зав, хичээл чармайлт гаргахын шаардлага юу байна вэ? хэмээн магадгүй хэн нэгэн асууж болох юм. Гэвч үүний хариултыг бидний орчин, амьдралын үйл явц өөрөө аянаа хариулах болно. Өөрөөр хэлбэл, өдөр тутам гарч буй үймээн самуун, хulgай дээрэм, хүчирхийлэл зэрэг ёс суртахуунлиг бус, зүй бус үйлдлүүд энэ бүгдийн хариулт болно. Өдөр тутам шинэчлэгдэж буй хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр хүний эрхийн зөрчил, догоодол гарсаар байгаа тухай мэдээ тасралтгүй шарагдаж давтагдаа байдаг. Дэлхийн өнцөг булан бүрд дайн тулаан, экологийн сүйрэл, ядуурал, болон нийгэм улстөрийн дэглэм, төр засгийн бодлого зэргээс шалтгаалан өдөр тутам олон сая хүмүүсийн эрх, эрх чөлөө зөрчигдсөөр байна.

Улс төрийн болоод хууль эрх зүйн мэргэжилтэй зарим хүмүүсийг эс тооцвол олонхи хүмүүс хүний эрхийн талаар тодорхой мэдлэг боловсрол олж авч чадаагүй байдаг. Хүмүүс өөрийн эрхийн талаар тодорхой

¹² Энэ талаар зохиогчийн “Эрхэд суурilan хөгжих хандлага” өгүүллийг мөн “Хүний эрх” сэтгүүлийн 2006 оны 3-р дугаараас дэлгэрүүлэн уншиж болно.

¹³ Human Rights Education at the Heart of Quality Education <http://portal.unesco.org/education/en/ev.php-201.html>

мэдлэг, чадвар байдаггүйгээс өөрийгөө өмгөөлөх чадвар ихээхэн сул бөгөөд үр дүнгүй болдог байна. Олонхи хүмүүс өөрсдийн өдөр тутмын амьдрал дахь хүний эрхийн зөрчил, асуудлуудыг яланг хардаггүй, мөн хүний эрхийн баримт бичгүүд, хуулиуд нь хүнд хэллэгтэй, мэргэжлийн шинжтэй байдгаас ойлгох, хүлээн авахад бэрхшээлтэй байдал.

Тухайлбал “Монгол улс бол ардчилсан улс” хэмээн бил өөрсдийгөө тодорхойлж ирсэн билээ. Гэвч өдгөө энэ нь хэлбэрийн төдий өнгөц байгаа тухай шүүмжлэн яригдах болмоо. Өөрөөр хэлбэл манай улсын иргэд нийгмийн болит харилцаанд орох буюу ялангуяа төрийн албаны үйлчилгээ хүртэхэд хүнд сурталтай тулгардаг. Энэ нь хүнийг үл ойшоох, ялгаварлан үзэх, асуудлыг хуулийн дагуу шийдэхгүй байх зэргээр нийтлэг илэрнэ. Мөн аливаа асуудалтай холбоотой мэдээлэл ихээхэн нууц, хаалттай байсаар байна. Энэ бол хүний эрхийн наад захын, түгээмэл зөрчлүүд билээ. Гэтэл иргэдийн зүгээс тухайн асуудлаар ямар байр суурьтай байх, өөрийн эрх, эрх чөлөөгөө эдлэх мөн бусдын эрхийг хүндэтгэх талаар тодорхой ойлголтгүй байдал. Гэтэл зарим улс орнуудад хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин бага байдгаас ерөөс нийгмийн амьдралд оролцох, үзэл бодлоо илэрхийлэх, эрх эрх чөлөөгөө эдлэх байдал орхигдоход хүрдэг ажээ.

Хөгжлийн хэмнэл хурдсахын хэрээр нийгмийн амьдрал улам бүр нарийсан хөгжиж байна. Нийгэм хөгжинө гэдэг нь сайн сайхны хамт саар муу зүйлс улам бүр боловсронгуй болох цогц үйл явц ажээ. Энэ талаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннан 2000 оны Олон улсын хүний эрхийн өдрөөр “Хүний эрхийн боловсрол яагаад чухал вэ?” хэмээх асуултанда “аливаа хүчирхийлэл, дайн тулаан хүмүүсийн оюун ухаанд л эхэлдэг. Тиймээс энх тайван байдлыг хамгаалах нь мөн л хүний ухаанд байх ёстой” хэмээжээ. Энэ ээдрээт нийгмийн харилцааг зохицуулах, хүмүүсийг аливаа гэм хор, саар муугаас хамгаалах, зохицуулахын тулд хууль зүй, дүрэм журам үүсэж улам бүр хөгжсөөр байна. Гэтэл олонх маань байнга өөрчлөгдөн буй тэдгээр хууль журмыг мэдэхгүйгээр өөрийн нэр хүнд, бие эрхтэн, ажил үйлсээрээ хохирч байдал.

Тэдгээр хууль тогтоомжууд нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж, дарамт болох бус харин билэнд үйлчилж, эрх ашгийг маань хамгаалахад чиглэдэг. Үүнийг л ойлгон ухаарч, хуулийг өөртөө үйлчлүүлэхэд хүний эрхийн боловсролын ач холбогдол оршино.

Хүний эрхийн боловсрол гэж юу вэ?

1993 онд Австрийн Вена хотноо Хүний Эрхийн Дэлхийн Чуулга уулзалтаар бүхий л улс орнуудад хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад алдаа дутагдал оршсоор байгааг хүлээн зөвшөөрч, хүмүүс эрх, эрх чөлөөгөө бодит утгаараа эдлэхэд “БОЛОВСРОЛ” чухал ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрчээ. Үүний үр дүнд хүний эрхийн боловсролын ач холбогдлыг дэлхий нийт чухалчлан үзэж, олон улсын түвшний боллого, үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж байна.

НҮБ-ын Ерөнхий ассемблейгаас баталсан “Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр”-т¹⁴ “Хүний эрхийн боловсрол гэдэг нь дараах зорилгол баримжаалсан мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх, хуваалцах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, боловсролын үйл ажиллагаа” хэмээн тодорхойлжээ. Үүнд:

- ◆ Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх явдлыг өргөжүүлэх;
- ◆ Хүний хувийн зан чанар, түүний эрхэм зэргийг хүндэтгэх;
- ◆ Бүх үндэстэн ястан, угуул хүн ам, арьстан, угсаатан, шашны ба хэлний бүлгүүдийн дунд харилсан ойлголцол, хүлцэн тэвчил, жендерийн тэгш байдал, найрамдал нөхөрлөлийг дэмжих;
- ◆ Хүн бүрт хуульт ёс бүхий чөлөөт ардчилсан нийгэмд үр ашигтай оролцох бололцоог хангаж өгөх;
- ◆ Энх тайван байдлыг бий болгох, хадгалан үлдэх;
- ◆ Хүн төвт тулхтай хөгжил, нийгмийн зүй ёсыг дэмжих зэрэг болно.

Хүний эрхийн боловсрол нь нийгэм дэх шударга бус зүйлийн эсрэг тэмцэх, түүнээс үрьдчилан сэргийлэх хэрэгсэл болохынхoo хувьд чөлөөт, ардчилсан, хариуцлагатай, зүй ёсны нийгмийг бүтээн байгуулах нэгэн үндэс болдог. Тийм ч учраас “хүний эрхийн боловсрол бол бүх хүнда зайлшгүй хүртэх ёстой суурь боловсрол” хэмээн үзэх хандлага дэлхий нийтэд тогтох байна.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд нийгмийн бүхий л байгууллага, бүрэлдэхүүн хэсгүүд өөр өөрийн үйл ажиллагаа, санаа зорилгоороо нэгдэн ажиллах нь чухал юм. Тухайлбал, бүх шатны боловсролын байгуулагууд нь сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан өсвөр насны хүүхэд залуучуудад хүний эрхийн хариуцлагатай, ухамсартай зан

¹⁴ United Nations, General Assembly ; The World Programme of Human Rights Education (A/59/525/Rev.1); 2004

үйл, хандлага төлөвшүүлэх, шашин, спорт, урлагийн зэрэг залуучууд олноор цугладаг байгууллагуудад хүний эрхийн зөрчил, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах бололцоог эрж хайх шаардлагатай байна. Өнөөдрийн нийгэмд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр цацагдаж буй мэдээлэл залуучуудад хүчтэй нөлөө үзүүлж байна. Тиймээс тэдгээр хэрэгслүүдээр хүний эрхийн тухай мэдээллийг олон нийтэд тогтмол түгээж байх нь хүний эрхийг хангах, хамгаалах үйлсэд хувь хүн бүрийн оролцоо, ойлголтыг дээшлүүлэх ач холбогдолтой.

Ийнхүү энэ талаар билэнд тодорхой ойлголцол бий болсон боловч хүний эрхийн тухай нийтлэг домгууд буюу буруу ойлголт төсөөлөл байсаар байна. Тухайлбал Миннесотагийн их сургуулийн Хүний эрхийн нөөцийн төвийн захирал Кристи Рудельс Палмер дараах “домгуудыг” ялган тодорхойлсон байна.¹⁵ Үүнд:

- Хүний эрх ба иргэний эрх нь аидл зүйл
- Хүний эрхийн зөрчлийг гагшгүү ядуу улс орнуудад л байдаг.
- Эрх зөрчигдсөн тохиолдолд л хүний эрхийг авч үзэх нь зөв.
- Хүний эрх нь зөвхөн хуульч зэрэг цөөн мэргэжлийн хүмүүст л хамаатай.
- Хүний эрх нь зөвхөн хууль эрх зүйн ойлголт хэмээн үзэх байдлууд орно.

Эдгээр “домгууд” нь хүний эрхийн мөн чанарыг гажуудуулах, явцууруулах, буруу ойлголт төсөөлөл өгөх, үүрэг хариуцлагаас зайлсхийх зэрэг алдаанд хүргэдэг байна.

Хүний эрхийн боловсролын талаар дэлхий нийт ямар санаачлагыг өрнүүлж байна вэ?

Дэлхий дахин дахь хүний эрхийн гол институт, бүтэц бол Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), түүний тогтолцоо билээ. НҮБ нь байгуулагсан цагаас эхлэн хүний эрхийн хэм хэмжээг тогтоох, байгуулага тогтолцоог бүрдүүлж институтчлэх үйл явцыг өрнүүлж, улмаар дэлхий нийтийг хамарсан хөдөлгөөн болон өргөжсөн. Гэсэн хэдий боловч энэхүү хөдөлгөөний урсгалд саяхныг хүртэл хүний эрхийн боловсролын орон зай байгаагүй байна.

¹⁵ Kristi Rudelius-Palmer, “Human Rights Education and Curriculum Integration” Presentation in MSUE, Ulaanbaatar, 2005

НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО), Хүүхдийн сан (ЮНИСЕФ) зэрэг нь даян дэлхийн хэмжээнд хүний эрхийн боловсрол, соёлыг түгээн дэлгэрүүлэхэд голлох байр суурьтай оролцдог байгууллагууд юм.

ЮНЕСКО, ЮНИСЕФ нь өөрийн үйл ажиллагаа, хөтөлбөрүүдэл хүний эрхийн боловсролд холбогдох дараах үнэт зүйлсийг баримталдаг байна.

◆ Хүний эрхийн боловсрол нь хүн ардын гэгээрэл, оролцоо, хариушлагатай, нээлттэй байдал, зөрчлөөс сэргийлэх ба хүч үл хэрэглэн шийдвэрлэх, энхийг бүтээх ба хамгаалах зэрэг зарчмуудыг хэрэгжүүлдгийн хувьд бүх хүнд эрх, эрх чөлөөг өдлүүлэх хамгийн зөв стратеги хэмээн тодорхойлдог байна.

◆ Хүний эрхийн боловсрол, сургалт мэдээлэл нь нийгэм, бүлэг нийтлэгүүдийн дуна тогтвортой, шударга харилцааг тогтоож, харилцан ойлголцол, энх тайван, хүлцэн тэвчил бүхий байдлыг дэмжинэ.

◆ Хүний эрхийн боловсрол нь хүний эрх эрх чөлөөг нийгэм, нийтлэг бүрд хангах үйлсэд хүн бүрийн үүрэг хариушлагыг ойлгуулахад чиглэдэг.

◆ Хүний эрхийн боловсрол нь хүн бүрт өөрийн болон бусдын эрхийг хүндэтгэх итгэл үнэмшил, хандлага, үнэт зүйлсийг төлөвшүүлж байдаг. Энэ байдал нь хүний эрхийн зөрчил, аливаа хүчирхийллийг үгүй болгож, тэгш байдал, ардчилсан нийгэм дэх шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог дэмжиж байдгийн хувьд тулхтай хөгжлийн үндэс суурь болдог.

◆ Хүний эрх нь хүмүүсийн өөрсдийгөө хамгаалах хэрэгцээ, мэдээлэлжсэн байдааар хэрэгждэг.

◆ Хүний эрхийн боловсрол нь хүний бүхий л эрх чөлөө эрхэмлэн хүндрэгдэж, аливаа зөрчил, эрслээс хамгаалж байдгийн хувьд зөв, шударга нийгмийг зохион байгуулах хамгийн чухал хөрөнгө оруулалт болно.

Эдгээрээс гадна олон улсын, бүс нутгийн, үндэсний хэмжээнд уулзарт, хурал чуулганууд зохион байгуулагдаж, энэ чиглэлээр олон тунхаглал, зөвлөмж, хөтөлбөрүүдийг боловсруулсан. Хүний эрхийн боловсролын чиглэлээр баталсан дараахи баримт бичгүүд түүнийг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны удирдамж болдог.

◆ 1993 онд Монреал хотноо зохион байгуулагдсан Олон улсын их хурлаас баталсан “Хүний эрх ба Ардчилалын тухай боловсролын дэлхийн хөтөлбөр”,

- ◆ 1994 оны Боловсролын олон улсын бага хурлаас гаргасан “Энх тайван, Хүний эрх ба Ардчилалын талаарх Тунхаглал ба Интеграшлагдсан үйл ажиллагааны үндэс суурь” баримт бичиг,
- ◆ 1995 оны ЮНЕСКО-ийн Ерөнхий бага хурлаар баталсан хүлээнтэй хандах тухай Тунхаглал
- ◆ 1995 оны “Боловсрол бүх нийтэд” Дакарын тунхаглал

Мөн хүний эрхийн боловсролын тухай зүйл заалтууд хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд, тухайлбал Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (26 зүйл), Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн тухай Олон Улсын Конвенци (13 зүйл), Хүүхдийн Эрхийн Конвенци (29 зүйл), Эмэгтэйчүүдийг алагчлан үзэх бүх хэлбэрийг устгах тухай Олон Улсын Конвенци (10 зүйл), Арьс үндсээр алагчлан үзэх бүх хэлбэрийг устгах тухай Олон Улсын Конвенци (7 зүйл), Венийн Тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөр (I хэсгийн 33-34 ба II хэсгийн 78-82 зүйлүүд) болон 2001 онд Өмнөд Африкийн Дурбан хотноо хуралдсан Арьсны үзэл, Арьс өнгөөр ялгаварлан гадуурхах ксенофоби болон холбогдох бусад үзлийн эсрэг Дэлхийн чуулга уулзалтын Тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөр (Тунхаглалын 95-97 зүйл, хөтөлбөрийн 129-139 зүйлүүд) тусгалаа олсон байдал.

Хүний эрхийн боловсролын үйл хэргийг дэмжих зорилгоор гишүүн улсуудаас хүний эрхэд холбогдох мэдээллийг боловсруулах, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн “Хүний эрхийн олон нийтийн мэдээллийн Дэлхийн кампанит ажил”, үндэсний түвшинд хүний эрхийн боловсролын үр ашигтай, зохистой, тогтвортой стратегиудыг боловсруулж, хэрэгжүүлэх “НҮБ-ын Хүний эрхийн боловсролын 10 жил” 1995-2004, түүний “Үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Даян дэлхийн хүүхдийн төлөө, хүчирхийлэлгүй, энхийн соёлын Олон улсын 10 жил зэрэг үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлж байна.

1993 онд буюу одоогоос 10 гаруй жилийн өмнө Вена хотноо Хүний эрхийн дэлхийн чуулга уулзалтаар “хүний эрхийн боловсрол, сургалт, олон нийтийн үйл ажиллагаа нь хүн төрөлхтөний тогтвортой, зүй зохист харилцаа, тэдгээрийн хоорондын харилцан ойлголцол, энх тайван, хүлцэн тэвчих байдлыг дэмжин хэрэгжүүлэх үндэс суурь болно.”¹⁶ Хэмээн

¹⁶ Хүний эрхийн Дэлхийн чуулга уулзалт, Венийн тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөр, II хэсэг. 78 зүйл

тунхаглаж, улмаар хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг зохих бодлогын дагуу түгээн дэлгэрүүлэх хэрэгцээ шаардлагын дагуу дэлхий нийтийн хэмжээнд дорвitoй томоохон арга хэмжээ авах саналыг боловсруулж, нийт хүн төрөлхтөнд хандан уриалга гаргажээ.

Энэ уриалгын дагуу Нэгдсэн үндэстний байгууллагаас 1995-2004 оныг “Хүний эрхийн боловсролын 10 жил” хэмээн зарласан бөгөөд дэлхий нийтээр энэхүү ажлыг дэмжин хүлээн авсан.

Ийнхүү олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хүний эрхийг бодит үйл хэрэг болгох явдалд хүний эрхийн боловсрол чухал хувь нэмэр үзүүлж байгааг дахин илэрхийлэх болжээ. НҮБ-н Хүний Эрхийн Боловсролын 10 жил нь дэлхий нийт, бус нутаг, улс орон бүрт тодорхой ололт амжилтанд хүрсэн хэдий ч хүний эрхийн эрхэм зорилго, амлалт, хариушлагыг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харгалзан “Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлэх шаардлагатай байна хэмээн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн Хуралдааны тэмдэглэлд бичсэн байна.

Үүний үр дүн, НҮБ-ын Хүний Эрхийн Комиссын 2004/71 шийдвэрт заасанчлан, энэхүү боловсрол нь хүний эрхийн аливаа зөрчил, эрслээс сэргийлэх, тэгш байдал, тулхтай хөгжлийг дэмжих, ардчилсан тогтолцооны шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэгт хувь нэмэр оруулж байгааг цохон тэмдэглэж, Хүний эрхийн боловсролын Дэлхийн Хөтөлбөр, түүний үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлах ажлыг санаачилсан байна. Улмаар үүний үр дүн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 59 дэх удаагийн чуулганы хуралдаанаар Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр, түүний Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

Хүний Эрхийн Комиссын дээрх шийдвэрийн дагуу Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөрийн нэгдүгээр шат (2005-2007) -ны үйл ажиллагаа нь бага болон дунд боловсролын тогтолцоонаа чиглэх болно.

Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөрийн зорилгууд:

- ◆ Хүний эрхийн соёлыг бүтээх, дэмжих;
- ◆ Хүний эрхийн боловсролын суурь зарчмууд, арга зүй, олон улсын баримт бичгүүдэд тулгуурлан нийтлэг ойлголт бий болгох;

- ◆ Хүний эрхийн боловсролыг үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд хэрэгжүүлэх баталгааг хангах;
- ◆ Холбогдох талуудын хамтын үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлох;
- ◆ Бүх түвшний хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих;
- ◆ Оршин буй хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүдэл дэмжлэг үзүүлэх, үр ашигтай практикуудыг тодруулах болон тэдгээрийг өргөжүүлэх, эрчимжүүлэх болон шинийг санаачлах зэрэг болно.

Харин Монгол Улсын хувьд НҮБ-ын Хүний эрхийн боловсролын арван жил, Дэлхийн хөтөлбөр зэргийн хүрээнд Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийг баталж, улмаар 2001 оны 1-р сард “Хүний эрхийн үндэсний комисс”-г байгуулсан, 2003 онд “Монгол улсад хүний эрхийн хэрэгжилтийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулан ажилласан, бага, дунд боловсролын стандартыг шинэчлэн, “хүний эрх, үүрэг” айг боловсролын босоо тогтолцоонд гүнзгийрүүлэн судлах болсон зэрэг олон үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлж байна.

Монгол улс дахь хүний эрхийн мэргэшсэн байгууллага болохын хувьд Хүний Эрхийн Үндэсний Комисс нь жил тутам Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын талаар судалгаа хийж, Улсын Их Хуралд тайлагнадаг. Тус Комиссын 2007 оны ээлжит илтгэлд Монгол улсаас хүний эрхийн боловсролын талаар хэрэгжүүлж буй болдого, үйл ажиллагаанууд болон тэдгээрийн үр дүн, ололт амжилтын талаар тусгаж буй тул дараагийн удаад дэлгэрүүлэн танилцах боломжтой болно.

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ШИНЭЭР ОРСОН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ БА ХҮҮХДИЙН ЭРХ

Ц.Түвшинтөгс Монгол Улсын гавьяат багш
“Улаанбаатар” дээд сургуулийн хүүхэд, гэр бүл
судлаач багш,

Abstract: New Amendments to the Education Law and Children's Rights

In 2006, the Parliament of Mongolia made amendments to the education law in an effort to create a safe and friendly school environment, and to deliver educational services to all children. Mongolia signed the 'World fit for Children' Declaration, and since then, has initiated new frontiers for child-friendly schools through new education policies. Last year, to link education services with child protection activities, the school social workers began working in schools 'as education social worker'. Therefore, the chart indicates that the legal environment has been created to make changes in the education sector, and now, with the changes to our laws, links education with child protection.

Олон улс гүрний төр засгийн тэргүүн нар 1990 онд хуран чуулж, хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах нөхцлийг хангах тухай шүүн хэлэлцсэн нь эрдэнэт хүмүүний эрхэм дээд эрхүүдийг хүүхэд нааснаас нь хангах асуудлыг дэлхий дахинаа дэвшигчлэсэн цоо шинэ хандлага, онцгой үзэгдэл байв. Нийгмийн хурц асуудал дээр ийнхүү анх удаа 76 орны төр засгийн тэргүүн, 100 гаруй орны төр засгийн тэргүүний бие төлөөлөгч санал нэгтгэй зөвшин тохиролцсон нь мөн л түүхэн тэмдэглэлт үйл явдал бөгөөд эндээс гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх нь НҮБ-ын гишүүн орон бүрийн үндэснийхээ болон дэлхий дахины өмнө хүлээсэн хүндэтэй үүрэг хариуцлагага, хүмүүнийг дээдэлсэн ариун үйл хэргийн эхлэл болсон юм.

Хүний эрх, эрх чөлөө, ардчилал, олон ургальч үзлийг дээдэлсэн НҮБ, түүний Ерөнхий Ассамблейн Чуулган 2002 онд Хүүхдийн асуудлыг нухацтай хэлэлцэж "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" Тунхаглал, үйл

ажиллагааны зорилтыг дэвшүүлсэн нь шинэ зууны дэлхийн иргэдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлж байна.

Дэлхийн хамтын нийгэмлэгийн алхаанд хөлөө нийлүүлсэн Монгол Улс дээрх эрхэм зорилгоо хөрхэн биелүүлж байна вэ?

- ◆ Монгол орон маань “Хүүхдэл ээлтэй улс” болох замдаа юу бүтээж байна вэ?
- ◆ Монгол хүүхэд бүр ээлтэй орчинд амьдарч чадаж байна уу?
- ◆ Олон хүүхдийн хувь заяатай холбоотой сургуулийн орчин хийгээд боловсролын үйлчилгээ хүүхдэл хэр ээлтэй байна вэ? гэх зэрэг олон асуулт ар араасаа хөвөрсөөр байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын асуулгын мөрөөр явуулсан судалгаанаас үзвэл бүх түвшинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл өргөн хүрээтэй байгаагийн дотор сургуулийн орчинд хүүхдийн эрхийг зөрчих явдал түгээмэл байна. Их Британы хүүхдийг ивээх сангаас хэвлүүлсэн Хүүхэд бил заавал бие махбод, сэтгэл санааны шийтгэл амсах ёстой гэж үү?хэмээх номд орсон зарим баримтаас дурдая.

- ◆ Хүүхэд зодлоггүй багштай сургууль гэж байхгүй. Наад зах нь нэг багш хүүхэд зодлог.
- ◆ Сургууль дээр хүүхэд хүүхдээ дээрэмдэг.
- ◆ Багш нар их мөнгө нэхдэг. Мөнгөгүй хүүхдийг дарамталдаг.
- ◆ Багшийгаа зодлоо гээд заргалдвал эргээд дүнгээр дарамталдаг.
- ◆ Манай сургуулийн багш нар буруу зүйл хийсэн хүүхдүүдийг цүнхийг нь өргүүлж зогсоодог.
- ◆ Бид багш нарынхаа хэлсэн үгээр нь хүлцэнгүй байж эвийг нь олох хэрэгтэй.
- ◆ Зарим багш дух руу нясалдаг, архи тамхинд явуулдаг, олон удаа суншилгадаг.
- ◆ Албан бус боловсролын хүүхдүүдийг багш нар, бас цэвэрлэгч, хувцасны өлгүүрийн хүн загнадаг, царай муутай охид гэж хочилдог.

Монгол Улсын Засгийн Газар НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн үндсэн дээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны

сайдын 2005 оны 190 тоот тушаалаар “Хүүхдэд ээлтэй сургууль”-ийн бодлогыг батлан мөрдүүлж байгаа ч боловсролын байгууллага нь хүүхэд хүчирхийлэлд өртөх, хүчирхийлэлд суралцах газар хэвээр байсаар л байна. Их Британий Хүүхдийг ивээх Сангаас явуулсан судалгаанд хамрагдсан бүх хүүхдийн 40 хувь нь багшийг хамгийн ойр дотны хүн атлаа хүчирхийлэгч хэмээн үзжээ.

Насан туршил хүүхэдтэй ажилладаг, мэргэжлийн сургууль дүүргэсэн, төр түмний хариуцлагатай ажил үүргийг биелүүлдэг багш л хүүхдийг хүчирхийлдэг, дарангуйлдаг, тэдний эрхийг зөрчдөг бол цаана нь байгаа бусад хүмүүсийн тухайл бүр ч хэцүү төсөөлөл байх нь ойлгомжтой.

Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлал нь 2006 онд хүүхдийн эрх ашгийг гэн тэргүүнд тавих зарчмаас урган гарсан бөгөөд хүүхдийг эрхэм хэрэглэгч, аливаа хүчирхийлэл дарамтаас ангилаа бие хүн хэмээн үзсэнд оршино. Тийм ч учраас хөгжлийн бэрхшээлтэй ч боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах, суралшагч нь хуульд заагаагүй төлбөр хураамжаас ангилаа үйлчилгээ авах, бие махбодь, сэтгэл санааны халдашгүй байдал, нууцаа бат хадгалах, албан бус хэлбэрээр боловсрол эзэмшиж тохиолдолд төрөөс өдийн засгийн дэмжлэг авах зэрэг зарчмын ач холбогдолтой олон заалт шинээр оржээ.

Энэ хуулийн 44 дүгээр зүйлд багшийн үүргийг заахдаа суралшагчийн үзэл бодол, нэр төрийг хүндэтгэх, онцлог байдлыг хүлээн зөвшөөрч ялгаваргүй хандах, бие даасан байр суурь, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, ялангуяа ёс зүйн дүрмээ баримталж ажиллахыг баталгаажуулжээ. Багшийн ёс зүйн дүрэм нь төр засгийн төв байгууллагаас батлагдсан эрх зүйн акт байж болохгүй нь мэдээж. Нийслэлийн нэг хувийн сургуульд багш нарынхаа ёс зүйн дүрмийг захирлынхаа тушаалаар баталгаажуулсан ба бүх заалт нь багшийн аливаа үйл ажиллагаанд нь хяналт тогтоохоор боловсрогдсон байлаа. Юуны тулд “Ёс зүйн” гэж тодотгосныг ухаарах ёстой. Ёс зүйн дүрэм нь нэг талаар дагаж мөрдөгдөх, нөгөө талаар багш нарыг гэгээрүүлэх тэдний үүргээ биелүүлэхдээ суралшагчид, эшэг эхчүүд, олон нийттэй болон өөр хоорондоо харьцахдаа баритлах зарим зан суртхууны хэмжээг тодорхойлох давхар үүрэгтэй байвал зохино.

Боловсролын тухай хуулийн 2006 оны энэхүү өөрчлөлтөөр сургууль, боловсролын байгууллагын материаллаг бааз, хангамж нөхцлөөс гадна багш суралшгчийн хоорондох сурх, сургах харилцааг шинээр оруулсан нь зарчмын чухал ач холбогдолтой болсон юм.

Энэ нь сургууль дээрх хүчирхийлийг багасгах эрх зүйн төдийгүй хүүхдэл зориулсан боловсролын үйлчилгээнд нийгмийн болон харилцааны сэтгэл зүйг өргөн хүрээтэй нэвтрүүлэх төрийн бодлогын үндсийг ч бүрдүүлж байна. Боловсролын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, шинэ заалтууд нь сургалтын байгууллагуудын удирдлага, зохион байгуулалт, менежмент, хөндлөгийн хяналтыг сайжруулах, багш суралшгчийн хариуцлагыг дээшлүүлэх, боловсролын үйлчилгээнд сургуулиас гадна нийгмийн бусад институц, ялангуяа иргэд олон нийт тодорхой үүрэг зорилготой оролцох зэргийг тусгаснаараа бас нэг давуу талтай юм. Уг хуулийн 42 дугаар зүйлийн 42.6-р заалтаад сургалтын байгууллага нь барилга, хот төлөвлөлтийн норм, нормативыг баримтлан тогтоосон, сургалтад зориулсан эзэмшил газартай байх тухай заасан нь өнөө цагт сургууль цэцэрлэгийн ойролцоо хүүхдэл зохижмжүй ажил үйлчилгээ явуулан / зочид буудал, баар, цэнгээний газар гэх мэт байрлуулан / хүүхдийн сурч хөгжих эрхийг хэрэгжүүлэхэд муугаар нөлөөлж байгаа дутагдлыг арилгахад тус дөхөм үзүүлэх болно. Мөн энэхүү хуулийн 30.1.12-д үндэсний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, ёс заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцлийг бүрдүүлэх тухай заасан нь хүүхдийг үндэс угсаа үл ялгаварлах таатай орчныг сургууль дээр бүрдүүлэх зарчмын ач холбогдолтой болсон юм.

Багш нь суралшгчийн бие махбодид халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг нь задруулах, хүүхдэл дээр дурьдсан хүчирхийлийн бусад хэлбэрүүдийг үзүүлсэн тохиолдолд тorgуулийн арга хэмжээ оногдуулахаар 48.2-д заасан нь хүүхдэл сэтгэл санааны ээлтэй орчин бүрдүүлэхэд нөлөөтэй болжээ. Энэ мэтчилийн Боловсролын хуульд шинээр орсон олон нэмэлт өөрчлөлт, зүйл заалт нь “Хүүхдэл ээлтэй сургууль”-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд том алхам боллоо.

Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал зөвхөн төр засгийн удирдах түвшинд яриглаагүй, анхан шатны нэгж,

олон нийтийн саналд тулгуурласныг тэмдэглэвэл зохино. Хүүхэдтэй ажилладаг , тэдний эрхийг хамгаалдаг төрийн ба төрийн бус 20 гаруй байгууллагын сүлжээ байгуулагдаж, анхны саналыг боловсруулж, улмаар түүнийг Улаанбаатар хот, Төв аймгийн ерөнхий боловсролын сургуулийн багш, захирал, менежер , нийгмийн ажилтны төрөлжсөн ярилцлагуудаар ултай хэлэлцсэн нь хамтын оюуны бүтээл болж чадлаа. ҮИХ-ын дэргэд бүх нам, улс төрийн хүчний төлөөлөл бүхий “Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих лобби бүлэг” шинээр байгуулагдаж, уг хуулийн боловсруулалт дээр нухацтай ажилласан нь хүүхдийн эрх ашигт нийтлэй ажил болсон юм.

“Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын хууль /2006.12.08/ боловсролын салбарынханд төдийгүй нийт иргэдийн хөгжилд дорвитой нөлөөлөх ба хүүхдийн эрхийг хангах цогц үйл ажиллагаа болж хэрэгжинэ гэдэгт итгэж байна.Хүүхдийн эрх ашигт нийцсэн орчин үеийн боловсролын үйлчилгээний талаархи энэхүү боллого, хуулийн заалтууд нь амьдралд хэрэгжихдээ ерөнхий боловсролын сургууль түүний удирдах зөвлөл, захирал, менежер, боловсролын нийгмийн ажилтан, багш нарын үйл ажиллагаа, үзэл хандлагад шуурхай, эрчимтэй, тогтвортой шинэчлэлт хийгдсэнээр хүүхдийн хөгжил, хамгаалалд чанарын өөрчлөлд гарах болно.

ХҮҮХДИЙН СУРЧ БОЛОВСРОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

**Б.Баяршээг МУБИС, Нийгмийн ухааны тэнхмийн
туслах ажилтан**

Хураангуй

Монгол дахь хүүхдийн эрхийн хэрэгжилтийн талаарх судалгааны дүнгүүд хүүхдүүд сургууль дээрээ хүчирхийлэлд өртөх, ялгаварлан гадуурхагдах, боловсролын үйлчилгээгтэгш бусаар хүртэх, эдийн засгийн албан болон албан бус салбарт хөдөлмөр эрхлэх зэргээр боловсролын салбарт хүүхдийн эрх зөрчигдсөөр байгааг харуулж байна.

Ийм учраас хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт болон түүний баталгааг хангах асуудлуудыг судлах хэрэгцээ шаардлага зүй ёсоор гарсан юм. Энэхүү илтгэлд хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн талаар социологийн судалгаануудын дүнд тулгуурлан тусгайлан авч үзэж, эрх зүйн зохицуулалттай холбон үзсэн болно.

.....

Хүний эрх, тэр дундаа хүүхдийн эрхийг хангахгүйгээр хүн төрөлхтөн хөгжил, дэвшилд хүрч чадахгүй. Учир нь хүүхэд бол хүн төрөлхтөний ирээдүйн үндэс билээ. Гэтэл Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн байдалд хийсэн судалгаа, түүний тайлан болон хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын хийсэн судалгааны дүнгүүд хүүхдүүд сургууль дээрээ хүчирхийлэлд өртөх, ялгаварлан гадуурхагдах, боловсролын үйлчилгээг тэгш бусаар хүртэх, эдийн засгийн албан болон бус салбарт хөдөлмөр эрхлэх зэргээр боловсролын салбарт хүүхдийн эрх зөрчигдсөөр байгааг харуулж байна. Ийм учраас хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний баталгааг хангах асуудлуудыг судлах хэрэгцээ шаардлага зүй ёсоор гарсан юм. Энэхүү өгүүлэлд хүүхдийн сурч боловсрох эрхийг тусгайлан, социологийн судалгаануудын дүнд тулгуурлан эрх зүйн зохицуулалттай холбон авч үзсэн юм.

Сурч боловсрох эрх нь хүүхдийн эрхийн бүрэлдэхүүн мөн

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүн бүр төрж мэндлэхдээ эрх чөлөөтэй, адилхан нэр төртэй, ижил эрхтэй бөгөөд энэхүү тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг ямар ч ялгаваргүйгээр эдлэх ёстай гэсэн байдал. Үүнээс хүний эрхийн тэгш, түгээмэл, салшгүй, ялгаваргүй, хуваагдашгүй байх ёстай гэсэн зарчмууд урган гарч ирдэг. Нөгөө талаас мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэгдэх ёстай” гэж заасан байдал нь хүүхдийн эрхийн хэрэгжилтэд боловсрол, боловсролын институт нэн чухал үүрэгтэй болохыг тодорхойлсон байна. Ийм учраас сурч боловсрох эрх бол хүний эрхийн салшгүй хэсэг бөгөөд бүх хүн ямар нэг ялгаварлалгүйгээр энэхүү эрхээ өдлэх, мөн хамгаалуулах эрхтэй.

Харин Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх олон улсын пактын (1966) 13-р зүйлд хүний боловсролын эрхийн талаарх асуудлыг өргөн цар хүрээтэйгээр авч үзсэн байдал бөгөөд тухайлбал, хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжих нөхцөл, зарчмыг “Боловсрол нь ямар ч түвшиндээ дараах үндсэн шинжийг хадгалж байх хэрэгтэй. Үнда - Боломжтой байх, - Хүртээмжтэй байх (ялгаварлан гадуурхах байдал гаргахгүй байх, бие махбодийн хувьд хүрч болохуйц байх, эдийн засгийн хувьд боломжийн байх), Хүлээж авахуйц байх, Амьдралд тохирохуйц байх” гэж тодорхойлсон байна.

Монгол дахь хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн байдлын талаар дараах хэд хэдэн түгээмэл бөгөөд тулгамсан асуудлуудыг судалгааны тайлангууд болон бусад эх сурвалжуудад тулгуурлан авч үзье.

Суурь боловсролын хүртээмж: Хүүхдийн Эрхийн Конвенцийн хэрэгжилтийн талаархи Засгийн газрын илтгэлээс үзвэл ЕБС-ийн хүртээмж хангалтгүй, ачаалал өндөр хэвээр байна. Анги дүүргэлт 45-50 болж ЕБС-ийн сургалт дунджаар 2.7 ээлжтэй, зарим сургууль 3 ээлжтэй байна. Монгол Улсын Үндэсний статистикийн газар, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын хамтран явуулсан Монголын Хүүхдийн Хөдөлмөрийн Судалгааны (2004) тайлангаас үзвэл 7-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин 79.1 хувьтай, энэ нь хот хөдөөд ялаатай буюу хотод 88.6 хувь, хөдөөд 67.6 хувьтай байгааг илэрхийлж байна.

Сургууль завсардалт: Монгол улсад сургууль завсардалт байсаар байна. Монгол дахь Сургууль завсардалтын судалгаа (МНХХ, БХАН. 2005) -ны тайлангаас үзвэл сургууль завсардалтын гол шалтгаануудыг дараах байдлаар авч үзсэн байна. Ядуурал буюу хичээлийн хэрэгсэл, хувцас хунар худалдан авч чадахгүй байдал, мал маллаж ар гэртээ нэмэр болох үүднээс гэж судалгаанд оролцсон хүүхдүүдийн 23.1 хувь нь, эшэг эхчүүдийн 50.5 хувь, дотуур байрны хангамж муюу, байрлах газрын хүндрэлтэй байдлаас 26.9 хувь, багш нарын ялгаварлан гадуурхалт, таагүй харилцаа 5.7 хувьд нөлөөлсөн байна (хавсралт 1-г үзнэ үү). Судалгааны тайлангаас үзвэл хөдөө орон нутагт амьдардаг тахир дутуу буюу оюуны хомсдолтой хүүхдүүд сургуульд суралцах, суурь боловсрол зэмших боломж түйlyn хязгаарлагамал байдаг учир ихэвчлэн сургууль завсардлаг бөгөөд эдгээр хүүхдүүдийг сургууль завсардалтын тоонд оруулдагүй байна. Их Британий Хүүхдийг Ивээх Сан болон бусад байгууллагуудын хамтран 2005 онд явуулсан "Шилжих хөдөлгөөн хүүхдийн амьдралд: Хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн ба хүүхдийн боловсролын хүртээмж" судалгаанд хамрагдсан шилжин суурьшсан нийт хүүхдийн 28.6 хувь нь орон нутгийн харьяалал, засаг захиргааны бүртгэл бүртгүүлээгүй, мөн бусад шалтгааны улмаас сургууль завсардсан байна.

Сургалтын төлбөр: Боловсрол нь эдийн засгийн хувьд боломжтой, бүх хүмүүс төлж чадахуйц хэмжээний төлбөртэй байх ёстой. Гэтэл хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын жилийн төлбөр нь их дээд сургуулиудын жилийн төлбөрөөс ч өндөр байна.

Хүүхдийн хөдөлмөр: Монгол Улсын Үндэсний статистикийн газар, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын хамтран явуулсан "Монголын Хүүхдийн Хөдөлмөрийн Судалгаа" (2004) нь хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар Монгол улсын хэмжээнд анх удаа өргөн хэмжээний мэдээлэл шуглуулж, хүүхдийн ажил, хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаархи мэдээллийн санг бүрдүүлж өгсөн юм. Судалгааны тайландаа эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлдэг 5-17 насны хүүхдийн тоон үзүүлэлтийг гаргасан байна. Судалгаанд хамрагдсан 5-17 насны 58580 хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 77% нь ХАА, ан агнуур, ойн аж ахуйд, 0.8 хувь нь уул, уурхай олборлох үйлдвэрт, 4.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа эрхэлж, үлдсэн хувь нь

боловсрулах аж үйлдвэр, барилга, зоогийн газар зочин буудал, тээвэр холбоо харилцаа, түрээс, төрийн захиргаа, нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ, өрхийн хувийн бизнес эрхлэх зэргээр эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна. Ажил эрхэлж буй хүүхдүүдийн 46.5 хувийг 15-17 насныхан эзэлж байгаа ба ажил эрхэлж буй хүүхдийн тоог сургуульд сурч буй хүүхдийн тоотой харьцуулснаас үзвэл хүүхдүүд бага, дунд ангид сургуульд дагнан суралшаж байгаад ахлах ангид сурах, ажиллах аль алиныг нь хослуулах хандлагатай болж байна. Мөн ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин үе тэнгийнхээсээ доогуур байна. 15-17 насны хүүхдүүдийн 47 хувь нь бага ангийн боловсролтой байна. Энэ бүхэн нь хүүхэд сурч боловсрох, сургуулиас гадуур үйл ажиллагаанд заршуулах шагийн ихэнхийг гэрийн ажил болон бусад ажилд заршуулж улмаар сурч хөгжих бололцоогоор хомс байгааг илэрхийлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд: Улсын хэмжээнд тахир дутуу буюу оюуны хомсдолтой 34000 гаруй хүүхэд байдаг судалгаа бий. Тусгай сургууль 5 байдаг бөгөөд 2000 орчим хүүхэд суралцдаг (Хүүхдийн эрхийн конвенцийн хэрэгжилтийн талаархи Засгийн газрын илтгэл). Мөн хөдөө орон нутагт тусгай хэрэгшээт боловсрол олгох ерөнхий боловсролын сургууль байдаггүй бөгөөд ердийн сургуулийн багш нар тусгай хэрэгшээт боловсролын талаар бүрэн дүүрэн мэдлэг, чадвар дутмаг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга барилд суралцаагүй байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурч боловсрох эрхээ эллэх боломжгүй байдалд хүргэж байна. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийн байдал” судалгааны (Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхийн Холбоо) урьчилисан тайланда дурьласанаар судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй 7-9 насны хүүхдүүдийн 88,5 хувь нь сургуульд огт сурч байгаагүй, 10-14 насны хүүхдүүдийн 33,3 хувь нь, 15-аас дээш насны хүүхдүүдийн 52,3 хувь нь сургуулиа орхисон байна.

Бие махбодийн болон сэтгэл санааны шийтгэл: Хүүхдийг бие махбод болон сэтгэл санааны хувьд шийтгэх нь хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийлэлийн хэлбэр бөгөөд хүний үндсэн эрхийн зөрчил юм (Харпер болон бусад. 2005). Зохистой Хөгжил Жендер Төв болон Их Британий Хүүхдийг Ивээх Сангаас 2005 онд “Хүүхдийн бие махбод болон сэтгэл санааны эсрэгшийтгэл: Хүүхдийн үзэлбодол” судалгааны тайлан хүүхдүүд сургууль, асран хүмүүжүүлэх байгууллагууд болон гэр бүлийн орчинд

байнга шийтгүүлдэг болохыг илэрхийлж байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 71 хувь нь зodoх, 41 хувь нь цэцэрлэг, сургуульдаа хэл амаар доромжлуулах, 16,3 хувь нь сандал өргөх, самбарын өмнө зогсох шийтгэлээр байнга шийтгүүлж байна. Судалгаанд оролцсон хүүхдүүдийн (давхардсан тоогоор) 60 хувь нь багш, 44.8 хувь нь ээж, 34.2 хувь нь аав шийтгэдэг гэж хариулсан бөгөөд 30.6 хувь нь даалгавар хийгээгүй, 23.1 хувь нь үгэндээ ороогүй, 15.7 хувь нь тоглосон гэсэн шалтгаануудаар шийтгүүлжээ (хавсралт 2-г үзнэ үү).

Ялгаварлан гадуурхалт, үл хайхрах: Багш нарын зүгээс хүүхдүүдийг амьдралын нөхцөл байдлын ялгаа болон сурлагын амжилтын үр дүнгээр нь ялгаварлах, зарим тохиолдолд боловсролын үйлчилгээнд адил тэгш оролцох боломж хүүхэд бүрийн хувьд хангалттайгаар хэрэгжихгүй байх, үл хайхрах хүчирхийлэлд хүүхдүүд багш сурган хүмүүжүүлэгчийн зүгээс өртдөг нь судалгаагаар харагдаж байна ("Хүний эрхийн боловсрол" ерөнхий боловсролын сургуульд. Судалгааны тайлан. ХЭҮК, УБ., 2005). Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 44.4 хувь нь багш нар гадаад өнгө үзэмж хардаг, 68.5 хувь нь зарим хүүхдүүдтэй харьцахгүй, хайхардаггүй гэж хариулсан байна.

Хүүхдийн оролцоог хангах: Хүүхдийн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох үйл явц сургуулийн дотоод үйл ажиллагаанд хэрхэн оролцож байгаагаас эхэлдэг. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллага нь тэднийг нийгмийн амьдралд оролцох, үзэл болдоо чөлөөтэй илэрхийлэх нэг хэлбэр байх ёстой. Гэтэл зарим тохиолдолд сурагчид, өөрийн удирдлагын байгууллага байгуулах, сонгуульт ажил хийх нь багш нарын зүгээс хүүхдийг ялгаварлан гадуурхах шалтаг болж байна.

Хүүхдийн сурч боловсрох эрхийн баталгааг хангах асуудалд

Боловсрол бол хүний үндсэн эрх, эрх чөлөө бөгөөд хүний эрхийг хангах баталгаа болдог учраас хүүхдийн сурч боловсрох эрхийг дээдлэн хүндэтгэх, хүүхдийн эрхийн талаарх олон улсын болон үндэсний баримт бичгүүдийн үзэл санааг нэвтрүүлэх, баримтлах нь бидний эх орондоо шогилуулан хөгжүүлэхээр зорьж буй иргэний нийгмийн нэгэн тулгуур зарчим мөн.

Төр үндсэн хуулиар хүний эрх, эрх чөлөөг зөвхөн тунхаглахаар хязгаарладаггүй шүүд хэрэгжүүлэх хамгийн дорвitoй хэрэгсэлүүдийг хуульчилж өгдөг21. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчижтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргэн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариушна гэж үнэсэн хуульд заасан байдаг. Ийм учраас хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг төр өөрийн хуулиар тунхаглаж, түүнийг хэрэгжүүлэх хэрэгслүүдийг бусад хууль, эрх зүйн актууддаа хуульчилж, түүний хэрэгжилтийг хянаж байдаг. Эдгээр бүгд нь хүүхдийн сурч боловсрох эрхийн боломжтой, хүртээмжтэй, хүлээж авахуйц, амьдралд тохирохуйц байх нөхцөлийг хангах учиртай. Монгол улс 1990 онд НҮБ-ийн Хүүхдийн эрхийн конвенцид нэглэн орсоноор конвенцийн заалтуудыг хэрэгжүүлэх үүргийг өөртөө хүлээж, энэ нь Монгол хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд чухал ач холбогдол өгч байна. Монгол дахь хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн байдлын талаар дээр дурьдсан түгээмэл бөгөөд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн баталгааг төр хангах үүрэгтэй. Хүүхдийн сурч боловсрох эрхийн хууль зүйн баталгааг хангах асуудалтай холбогдуулан дараах асуудлууд гарч ирж байна:

НҮБ-ийн Хүүхдийн эрхийн конвенцид “Оролцогч улсууд сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах” тухай, мөн Монгол улсын “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д “Хүүхэд сургууль завсардахаас арга хэмжээ авах, мөн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүүхдээ сургуулиас завсардуулсан эцэг, эх, асран хамгаалагчид хариуцлага хүлээлгэж байх” гэж заасан байгаа боловч үүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхой заалт алга байна. Ийм учраас хүүхдийн сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэх, хүүхдэд олгох боловсролыг хүртээмжтэй болгох үүднээс хүндэтгэх шалтгаангүйгээр хүүхдээ сургуулиас завсардуулсан эцэг эхэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой эрх зүйн актад тодорхой байдлаар тусгах нь зүйтэй.

Хүүхдийн эрхийн конвенцид “хүүхэд эрүүл мэндэд нь хор нөлөө учруулах, боловсрол олоход нь саад учруулах ажил эрхлэх явдалаас хамгаалагдах эрхтэй” гэж заасан байдаг боловч хүүхдүүд суралшаж чадахгүй хөлстэй болон хөлсгүй хөдөлмөр эрхэлж байна.

Ийм учраас Конвенцийн хэрэгжилтийг хангах талаар эрх зүйн тодорхой зохицуулалт шаардлагатай байна.

Монгол улсын БСШУЯ-наас “Боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтаны ёс зүйн дүрэм”, “Багшийн ёс зүйн дүрэм”-ийг батлан мөрдүүлж эхэлсэн нь хүүхдийн эрхийг хамгаалах хувь зүйн нэг чухал хэрэгсэл болж байна.

Сургуулийн зөвлөл нь “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 4.2-т зааснаар хуулийн этгээдийн эрх эдлэхгүй боловч сургачийн эрх ашгийг хамгаалах тухай эрх, үүргийг тодорхой байдлаар тусгах ёстой.

Дүгнэлт

Боловсрол нь хүний эрхийн аливаа зөрчил, эрсдлээс сэргийлэх үндсэн нөхцөл болдог. Хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт нь нэг талаас хүний эрхийн хэрэгжилтийн асуудал бөгөөд нөгөө талаас хүүхэд боловсрол олж авч байгаа явдал нь ирээдүйд хүний эрхийн хэрэгжилтийн баталгаа болдог байна. Ийм учраас боловсрол бол хүний үндсэн эрх, эрх чөлөө бөгөөд хүүхдийн сурч боловсрох эрх бол хүүхдийн эрхийн түүнчлэн хүний эрхийн зайлшгүй салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

Хүүхдийн эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх талаар сүүлийн жилүүдэд нэлээд анхаарал тавьж ажиллаж байгаа хэдий ч улсын хэмжээнд сургууль завсардалтын түвшин өссөн, ерөнхий боловсролын сургуулийн хүрэлцээ мүү, ачаалал өндөр, хүүхдүүд сурхын зэрэгцээ хөдөлмөр эрхэлж, хөдөөгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тусгай боловсролын сургуульд суралцаж чадахгүй байгаа, хүүхэд сургууль дээрээ бие махбодийн болон сэтгэл санааны шийтгэл, хүчирхийлэлд өртөх, ялгаралтан гадуурхагдах, үх хайхрагдах, өөрт нь холбоотой асуудлаар шийдвэр гаргахад оролцохгүй байх зэргээр хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилт хангальгүй байна.

Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн баталгааг төр өөрийн хуулиар тунхаглаж, түүнийг хэрэгжүүлэх хэрэгсэлүүдийг бусад хууль, эрх зүйн актууудаа хуульчилж, түүний хэрэгжилтийг хянаж байлаг. Монгол улс НҮБ-ийн Хүүхдийн эрхийн

конвенцид нэгдэн орсоноор түүнийг хэрэгжүүлэх үүрэг хүлээж, хэрэгжилтийн талаар тайлан гаргаж, Хүүхдийн хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа нь хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд чухал ач холбогдол өгч байна. Цаашид хүүхдийн сурч боловсрох эрхийн баталгааг хангахын тулд хүүхдээ сургууль завсардуулсан эшэг эхэд хариуслага тооцох, хүүхдийг зодож шийтгэхийг хориглох, хариуслага хүлээлгэх, хүүхдийн хөдөлмөрийг багасгах, хориглох, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг нь сургалт-хүмүүжлийн байгууллага байх, хүүхдийн сурч боловсрох эрхийн нийгэм, эдийн засгийн баталгааг хангах талаарх тодорхой актуудын хэрэгжилтийг хангах талаар анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Ном зүй

Монгол улсын хууль:

1. Монгол улсын үндсэн хууль. 1992
2. Хүүхдийн эрхийн тухай монгол улсын хууль. 1996
3. Боловсролын тухай хууль. 2002
4. Бага дунд боловсролын тухай хууль. 1998
5. МҮ-ын хөдөлмөрийн тухай хууль. 1999
6. Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалын тухай. 1995

Олон гэрээ, конвенци:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1948
2. Хүүхдийн эрхийн конвенц. 1989
3. Ажилд авах насны доод хязгаарын тухай конвенци. 1973
4. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай конвенци. Зөвлөмж. ОУХБ. 1999
5. Ажилд авах насны доод хязгаарын тухай 138-р конвенци. ОУХБ. 2002
6. Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай олон улсын пакт. 1966

Судалгааны ном, бүтээл

1. Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар. Монгол улсын үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2000
2. Г.Совд. Монгол улсын үндсэн хууль: хүний эрх (харьцуулсан эрх зүй). УБ., 1999
3. Олон улсын хүний эрх. Томас Буергентал. 2002
4. Менталитет. МУБИС. 2004, №2
5. Эрх зүй сэргүүл. МУИС. 2000, №1
6. Хүүхдийн эрх. ХТҮГ. УБ., 2005

Бодлогын баримт бичиг, эмхэтгэл, судалгааны тайлан:

1. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого. 1995
2. Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр. УБ., 2002.
3. Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр. 2003
4. Дэлхийн хүүхдийн байдал. ЮНИСЕФ. 2005
5. НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 39-р чуулганаас хүүхдийн эрхийн асуудлаар Монгол улсад өгсөн дүгнэлт, зөвлөмж. Хүүхдийг Ивээх сан. 2005
6. Мянганы хөгжлийн зорилтууд нь хүүхдүүдтэй холбоотой. ЮНИСЕФ. 2005
7. Монгол дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл. ХЭҮК. 2002, 2003
8. Хүүхэд -хөгжил 2000. Үндэсний тайлан. УСГ.
9. Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа. Монгол улс, 2002-2003. УБ., 2004
10. Хүний эрхийн конвенцийдийн хорооноос батлан гаргасан ерөнхий санал, зөвлөмжүүдийн эмхэтгэл. УБ., 2004
11. "Хүний эрхийн боловсрол" ерөнхий боловсролын сургуульд. Судалгааны тайлан. ХЭҮК, ЮНЕСКО, УБ., 2005
12. Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл: Хүүхдийн үзэл бодол. Судалгааны тайлан. ЗХЖТӨВ, ХИС. УБ., 2005
13. Монгол дахь Сургууль завсардалтын судалгаа. МННХ, УБ, 2005

Хавсралт 1.


Судалгаанд оролсон сургууль завсардагсад, эцэг эхчүүд, багш нарын хариултуудын харьцуулалт

СУРГУУЛЬ ШАЛТГААНУУД	ЗАВСАРДАЛТЫН	ХАРИУЛТУУД/олон сонголтот/					
		Хүүхдүүд		Эцэг эхчүүд		Багш нар	
		N	%	N	%	N	%
Ядуурал /бага орлого/ хичээлийн хэрэгсэл/ хувцас хунар худалдан авч чадахгүй байдал	49	23.1	57	50.5	20	37.0	
мал маллах/ажиллах/ аж ахуй эрхлэх /дүүгээ асрах	70	32.9	18	15.6	1	1.9	
дотуур байр/байрлах газрын хүндрэлтэй байдал/гэр оронгүй байдал/гэрээ санах	57	26.9	21	19.2	NR	NR	
Шилжих хөдөлгөөн	16	7.5	9	8.3	2	3.7	
бүрэг/харилцах чадвараар дутмаг/өвчин эмгэг	37	17.5	NR*	NR	5	9.3	
багш нарын ялгаварлан гадуурхалт/ багштайгаа таагүй харилцаатай байх	12	5.7	23	21.1			
биеийн/оюун ухааны хувьд хөгжлийн бэрхшээлтэй байдал			19	17.4	7	13.0	
сургуульд суралцах сонирхолгүй	40	18.9	13	11.9	6	11.1	
шалгалтаяа өгч чадаагүй/ сурлагаар тааруу	17	9.4	18	16.5			
эцэг эхийн анхаарал сул байдал, эцэг эхчүүдийн дарамт	3	1.4	NR	NR	9	16.7	
эцэг эхчүүд нь өвчтэй / архинд донтсон	22	10.4	9	8.1	NR	NR	
бусад: үе тэнгийнхний ялгаварлал; нийгмийн эсрэг үйл ажиллагаанд татагдан орсон, лам болох	2	1	1	1.9	1	1.9	

◆ NR – хариултгүй

Эх сурвалж: Монгол дахь Сургууль завсардалтын судалгаа. МННХ, УБ, 2005

Хавсралт 2.



◆ Хөдөө болон хотод хүүхдүүдийн үзэж байгаагаар гэрийн даалгавраа хийгээгүй, хичээлээ давтаагүй, хичээл хожимдсон, үгэндээ ороогүй буюу буруу хэрэг хийсэн гэсэн шалтгаанаар насанд хүрэгчид тэднийг шийтгэдэг байна.

◆ Ялангуяа хүүхэл цэцэрлэг, сургуульд үймүүлсэн, Гэрийн даалгавар хийгээгүй, хичээл хожимсаноос болж шийтгүүлдэг нь түгээмэл байна.

Эх сурвалж: Хүүхдийн бие махбод, сэтгэл санааны эсрэг шийтгэл: Хүүхдийн үзэл бодол. Судалгааны тайлан. ЗХХТӨВ, ХИС. УБ., 2005

МЭДЭЭЛЛИЙН ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ АСУУДАЛД

Ж. Соёмбо ХЭҮК-ын бодлого, дүн шинжилгээ хариуцсан референт

Хураангуй:

“Мэдээллийн эрх, эрх чөлөөг хангах асуудал” өгүүлэл нь оршил, мэдээллийн эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад нөлөөлөх дөрвөн орчны тухай зохиогчийн байр суурь, дүгнэлтээс бүрдэнэ. Оршлын хэсэгт мэдээллийн эрхийг хангах, хамгаалах гол зорилтын хүрээнд дөрвөн орчныг дэвшүүлсэн. Өгүүллийн нэг, хоёр, гурав, дөрөвдүгээр хэсэгт мэдээллийн эрх чөлөөний хэрэгжилтийг хангах эрх зүйн, эдийн засгийн, улс төрийн болон нийгмийн сэтгэл зүйн орчин бүрдүүлэх асуудлаар зохих судалгааны дүгнэлт, баримтад үндэслэн тодорхой саналуудыг дэвшүүлсэн. Дүгнэлтийн хэсэгт эдгээр саналуудыг хангаснаар хүрэх үр дүнг товч өгүүлсэн болно.

.....

Мэдээллийн энэ зүүнд ирээдүйтэй бодлого боловсруулж эрчимтэй хөгжилд хүрэхийн тулд түүнд тушаа болж байгаа алдаа дутагдлыг засч залруулахад үнэн бодит мэдээлэл зайлшгүй чухал бөгөөд мэдээлэл олж авах түгээн дэлгэрүүлэх эрхийн эрх зүйн үндэсийг тодорхой болгож өгөх шаардлага хурсаар тавигдаж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн арванзургадугаар зүйлд (17) төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нуущад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж заасан.

Мэдээллийн эрх, эрх чөлөө нь хүний суурь эрхүүдийн нэг бөгөөд мэдээллийг эрж хайх, түгээх үйл ажиллагаа нь төрийн байгууллага, олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн дэмжлэггүйгээр хэрэгжих ямарч боломжгүй байдаг. Тухайлбал нэг талд нь олон нийтийн

эрх ашгийг хөндсөн асуудалтай холбоотой мэдээллийг олж авахад зайлшгүй хэрэгцээ байхад нөгөө тал нь хаалттай орчинд үйл ажиллагаа явуулж бүх зүйлээ нүүцалж хориг саад хийхдэг бол мэдээллийн хомсдол үүсэж, түүнээс үүдэн авилгал, дур зоргоороо аашлах гэх мэт хууль бус үйлдлүүд газар авч нийгэмд бухимдал төрүүлж, төрийг хямралд оруулах үйлдэл үүсдэг билээ.

Мэдээллийн эрх, эрх чөлөөг хангахад доорхи орчинг бүрдүүлэх нь төрийн байгууллага, иргэний нийгмийн тулгамдсан зорилтууд болно.
Үүнд:

- ◆ Хууль, эрх зүйн орчин
- ◆ Эдийн засгийн орчин
- ◆ Улс төрийн орчин
- ◆ Нийгэм сэтгэлзүйн орчин

Хууль, эрх зүйн орчин. Мэдээллийн эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах хууль тогтоомжийг ардчилсан нийгмийн стандартад нийцүүлэн улам боловсронгуй болгох ёстой.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйл, Иргэний улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2, 3-т . Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэ эрхэд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалzan амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурласан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариушлага оногдуулна. Тийм учраас түүнийг зарим талаар хязгаарлаж болох боловч тэр нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараахь шаардлагаас үүдэн гарсан байх ёстой: a/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх: b/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах/ зааж олон улсын эрх зүйгээр батаалгаажуулсан байдаг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулиар тус эрхийг хангах үндсэн суурь тавигдсан билээ.

Гэвч манайд мэдээллийн эрх, эрх чөлөөг хангах, түүнийг хамгаалах хууль тогтоомж бараг байхгүй гэхэд хэлсдэхгүй бизээ. Одоогийн мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн ихэнх хэсэгт мэдээллийн эрх

чөлөөг хангахаасаа илүү түүнийг хязгаарласан, хяхан хавчсан заалт бүхий хууль олон байна. Тухайлбал Эрүүгийн хууль, Иргэний хууль, Нууцын тухай багц хууль гэх мэт үндсэн гол хуулиудад мэдээлэл олж авах, түүнийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд саад учруулах, эдгээр хуулиар төрийн болон хувийн байгууллага, хувь хүмүүс урвуулан ашиглан дарамтлах, улмаар шахан хавчих үйлдэлүүд өнөөгийн нийгэмд элбэг тохиолдож байгаа юм. Иймд одоогийн мөрдөгдөж байгаа хуулиудад мэдээллийн эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад чиглэсэн хууль тогтоомжийг тэргүүн ээлжинд бий болгох, бий болгосон хуулийн дагуу холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт хийх замаар засаж сайжруулах, мөн төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран тодорхой шатдааалсан хөтөлбөр зохиож, хэрэгжилтэд хяналт тавих шаардлага нь мэдээллийн эрх, эрх чөлөөг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээний нэн тэргүүнд тавигдаж байна.

Эдийн засгийн орчин. Мэдээлэл олж авах, түүнийг түгээн дэлгэрүүлэх үйл явц нь өөрөө олон талт харилцаанд суурисан байдаг тул нийгмийн болон техникийн хөгжлийн хурдацыг дагах зайлшгүй шаардлагатай тулгардаг бөгөөд мэдээллээр хангах үйл ажиллагааны зардал нь орчин үед их үнэ өртөгтэй болсонтой холбогдоно.

Мэдээллийн эх сурвалжийн төлбөрийг хямаа байлгахад төрийн байгууллага, олон нийтийн болон мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаа, уян хатан бодлого чухал нөлөөтэй юм.

Мэдээлэл олох, түгээх үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай өргөн хэрэгцээг зарим тоног төхөөрөмжийн гаалийн болон бусад татвар, хураамжийг тогтооходоо анхаарах, мөн банк, санхүүгийн байгууллагуудаас хөнгөлттэй зээл авах замаар техник, технологийн шинэчлэлийг явуулах боломжоор хангагдах нь мэдээлэл боловсруулах, түүнийг түгээх үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой.

Мэдээлэл олж авах, түгээх үйл ажиллагаанд оролцогчдын эдийн засгийн боломжийг хангахад төрийн болон олон нийтийн байгууллагууд, хувийн аж ахуйн нэгжүүд, иргэдийн дэмжлэг асар их үүрэгтэй байдаг. Захиалагт нэвтрүүлэг, өгүүлэл, зар сурталчилгаа гэх мэт олон үйл ажиллагаа хамаардаг.

Хэрэглэгч өөрийн хүссэн мэдээллийг чанартай, бодитой, хэрэгцээтэй төрөл хэлбэрээр сонгож, тохирсон хөлсийг төлөх сонирхолтой байдаг нь зах зээлийн өнөөгийн гол хуулийн зарчим билээ. Иймд мэдээллийн зах зээл өрсөлдөгч байгууллагууд шудрага нээлттэй өрсөлдөж, өөрийн байр суурийг зах зээлийн орчинд баталгаажуулах нь зайлшгүй шаардлага юм. Үүний тулд мэдээллийн эрэлтэд тулгуурлан бүх үйл ажиллагаагаа чадварлаг хүний нөөц, шинэлэг шийдэл, оновчтой бодлого, технологи, техникийн ололтод тулгуурлан хямд мэдээллийг өгөх нь мэдээллийн эдийн засгийн орчныг бэхжүүлэхэд асар их үүрэгтэй юм.

Улс төрийн орчин. Мэдээллийн эрх, эрх чөлөөний улс төрийн орчинг бүрдүүлэхэд төрийн болон олон нийтийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн гаргаж буй улс төрийн үнэлэлт, мэдрэмж чухал бөгөөд үүна мэдээллийн гүйцэтгэх үүргийг тодорхойлоход дараахи үйл ажиллагаа нэн хэрэгцээтэй байна.

- Төрийн болон олон нийтийн байгууллага, албан тушаалтан, аж ахуй нэгж, иргэдийн гаргаж буй улс төрийн шийдвэрт мэдээллийн эрхийг хангах талаар анхаарах асуудлыг хэвшил болгох.

- Төрийн болон олон нийтийн байгууллага, улс төрийн нам эвслийн албан тушаалтан, гишүүдэд мэдээллийн эрх, эрх чөлөөний талаархи мэдлэг, чадварыг дээшлүүлэх бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх.

- Нийгмийн улс төрийн байдлын талаархи үнэн бодит мэдээллийг мэдээллийн бүхийл хэрэгслээр мэдээлж байхыг хөхүүлэн дэмжиж байх.

- Төрийн болон тодорхой албан тушаалтан мэдээллийн хууль тогтоомжтой танилцаж, сургалтанд хамрагдан, мэдээллийн үйл ажиллагаанда оролцогчдыг хүндэтгэн харилцах үүргийг хэвшүүлэх хэрэгтэй байна.

- Иргэд, мэдээллийн байгууллагуудын улс төрийн соёлыг дээшлүүлэх, ухамсруулах байнгын мэдээллийг мэдээллийн бүхийл хэрэгслээр сурталчиж байх.

Нийгэм – сэтгэл зүйн орчин. Мэдээллийн эрхийн оролцогчдын үйл ажиллагаа нь нийгмийн сэтгэлзүйн орчныг бүрдүүлэхэд асар их нөлөө үзүүлдэг тул дараахи арга хэмжээг явуулах хэрэгтэй байна.

Олон нийтэд мэдээлэл өгөхөөс эмээх, идэвхигүй хандах, эх сурвалжныбаталгаагүй мэдээлтэараах, тодорхойхуулиархамгаалагдсан мэдээг түгээх, түүнийг эрж хайх нийгмийн ухамсыг арилгах нь чухал бөгөөд энэ талаар тодорхой үйл ажиллагааг төрийн болон олон нийтийн байгууллага, албан тушаалтан, аж ахуй нэгж, мэдээллийн байгууллага, иргэдтэй хамтран бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Байгуулага, хувь хүний нэр төрийг гутаах зорилготой гүжирдсэн, доромжилсон мэдээллийг тараасан үйл ажиллагаатай холбоотой маргааныг тухай бүр мэдээлж, холбогдох үр дүнг мэдээллийн хэрэгслүүдээр түгээж байх. Ингэснээр хууль зөрчсөн мэдээллийг нийгэмд түгээх хор уршигийн талаар нийгмийн ухамсарт суулгаж, жигшүүлэх үйл ажиллагаа явуулж байх нь нийгмийн сэтгэлзүйг бодитой, чанартай мэдээллээр хангах үйл ажиллагааг хэрэгжүүлхэд нөлөөтэй.

Дүгнэлт:

Дээр дурьдсан үндсэн орчнуудыг бүрдүүлэх үйл ажиллагаанд бүх шатны төрийн байгууллага, олон нийтийн байгууллага, иргэдийн хөдөлгөөн, аж ахуй нэгж, олон улсын байгууллага, иргэд, мэдээллийн бүх хэрэгслүүд хамтран оролцож, нэгдэж ажилласнаар Монгол Улсад мэдээллийн эрх, эрх чөлөө бүрэн цогцоор хангагдаж, мэдээллийн бүх төрлийн үйл ажиллагаа идэвхитэй болно. Эдгээр орчныг ямар нэг байдлаар бүрдүүлж чадахгүй бол мэдээллийн эрх, эрх чөлөө хангагдах талаар ярих нь учир дутагдалтай юм. Харин дээр дурьдсан орчнуудыг цогц байдлаар бүрдүүлснээр төрийн үйл ажиллагаа нээлттэй болж, иргэд, байгууллагын зүгээс мэдээллийг хайх, хүлээн авах, түүнийг түгээх үйл ажиллагаанд ахиц дэвшил гарч, арччиллын үндэс сурье болсон хүний эрх, эрх чөлөө хангагдахад чухал нөлөөтэй билээ.

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ “ИММУНИТЕТ-ИНДЕМНИТЕТ” ЭРХИЙН ТУХАЙД

А.Түвшинтулга. ХЭҮТ-ийн ТБХТС-ын ЭШДА

Abstract: About “immunity-indemnity” right of deputies

Deputies fulfill the obligations stated in Code of Parliament, Deputy status. In Mongolia members of State Great Khural enjoy rights and fulfill obligations provided in Constitution of Mongolia, Code of State Great Khural and the other related codes, but also have right to have guarantee given and recognized by international principals. There exist two basic concepts that express inviolability of deputies.

Indemnity -1. security against damage or loss. 2. compensation for damage or loss sustained. 3. costs of war 4. to exempt from charges. 5. expiration of period of limitation on charges¹⁷

Immunity 1. inviolability, special right, a right to inviolability, privilege, exemption, immunity – a term indicating an exemption of certain subjects from actions of norms public law. In broadly saying it is a unique condition of a subject that exempted from the effect of some domestic laws, a condition that arose from international norms and principles. According to constitutional law some public officials possess inviolability. These are mirrored in reality as presidential inviolability, judge's inviolability or immunity, inviolability of deputy etc.

2. privilege, benefit **parliamentary immunity** – means inviolability of deputy.

From these two concepts the “INDEMNITY” is used in two ways in the status of deputy. First: deputies in parliament except in case of insulting someone will not charged legally for actions such as speeches, proposals, draft initiations, proposals submitted to parliament within the period and after it. Second: a compensation for covering deputies' costs related to official works.¹⁸ To have a right of indemnity that reflects the guarantee of above mentioned inviolability deputy is an inseparable part of freedom of speech and a deputy who insults others, blackwashes abuses the right of speech, transgresses the limit of indemnity. Deputy has to be provided by guarantee of rights stipulated in codes and international principles; also deputy needs to be conformed to national acts. Because this is a prerequisite to human rights, rule of law and democratic humane society. These are the main problems to be touched in this paper.

¹⁷ Narangerel S. English-Mongolian Jurisprudence Dictionary. UB., 2005, 459 p.

¹⁸ Ulziisaikhan L. Parliamentary. UB., 2006, 321 p.

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ “ИММУНИТЕТ-ИНДЕМНИТЕТ” ЭРХИЙН ТУХАЙД

Парламентын гишүүн нь ард түмнээс сонгогддог, ард түмний төлөөлөл, төрийн эрхэм түшээ бөгөөд үйл ажиллагаагаа парламент, ард түмнийхээ өмнө хариуцлаг тийнээсээ бүрдээж байгаа.

Парламентын гишүүн бол Парламентын тухай хууль, Парламентын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндсэн үүргийг гүйцэтгэнэ. Монгол Улсын хувьд УИХ-ын гишүүн нь Монгол Улсын Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхийг эдэлж үүрэг хүлээхийн зэрэгцээ Олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмаар хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн эрхийн баталгаатай байдаг.

Парламент нь XVIII-XIX зуунд хэмжээгүй эрхт хаант засаглалыг сөрөн тэмцэж байх үедээ гишүүдийнхээ халдашгүй дархан эрхийг баталгаажуулсан билээ.¹⁹ Парламентын гишүүний халдашгүй эрхийн баталгааг илэрхийлэх үндсэн хоёр ойлголт байдаг. Эдгээр ойлголт нь нэр томъёоны хувьд:

Indemnity-1. гэм хор, хохирол алдагдал нөхөн төлөх баталгаа, 2. гэм хор, хохирол алдагдлын нөхөн төлөлт 3. дайны төлбөр, 4. ялаас чөлөөлөх, 5. хариуцлагын хөөн хэлэлцэх хугацаа дуусах,²⁰

Индемнити – этимологийн хувьд латини *indemnitas* буюу *indemnis* гэсэн үгний англи дуудлага буюу хэлбэр. Үгний хувьд нийлмэл буюу утгын хувьд “алдагдалгүй” гэсэн утгатай.

In + demnis /damnum – хохирол гэсэн нэр үгний тэмдэг нэр/+ ty гэсэн бүтэцтэй.

In - гэлдэг нь латин хэлэнд ямарваа нэгэн үгний өмнө орох угтвар бөгөөд үгүйсгэсэн утгыг заадаг.

- ty - энэ нь англи, франц хэлнээс зээлсэн үгнээс нэр үг үүсгэх нөхцөл.

Англи хэлтэй улс орнуудад индемнити нь хэд хэдэн утгатай. Үүнд:

1. хохирол буюу алдагдлаас хамгаалсан баталгаа
2. хохирол буюу алдагдлын нөхөн төлбөр
3. хууль бус үйлдлийн төлөө үзүүлэх шийтгэлээс чөлөөлөх явдал зэрэг утгаар хэрэглэгддэг.²¹

¹⁹ Т.Доохүү, Ч.Энхбаатар “Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй” УБ., 2006 он, 172 дахь тал

²⁰ С.Нарангэрэл “Хууль зүй судлалын Англи- Монгол тайлбар толь” УБ., 2005 он, 459 дэх тал

²¹ www.wikipedia.org, Random House Webster's Dictionary, 1992, орчуулсан: ХЗҮТ-ийн ЭШДА
3. Серик

Immunity 1. халдашгүй байдал, халдашгүй эрх, оншгой эрх, дархан эрх ямар нэгэн зүйлийн эрх зүйн чөлөөлөлт, иммунитет (лат. *immunitas*)- нийтийн эрх зүйн хэм хэмжээний үйлчилэлээс эрх зүйн тодорхой хүрээний субъектийг чөлөөлөх агуулга бүхий эрх зүйн ерөнхий нэр томьёо. Үндсэн хууль тогтоомжид заасан буюу олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмаас урган гарсан бөгөөд үндэсний хууль тогтоомжийн зарим ерөнхий хэм хэмжээг хэрэглэхийг хязгаарласан эрх зүйн субъектийн онцлог байдал. Үндсэн хуулийн эрх зүйгээр төрийн зарим албан тушаалтууд халдашгүй байдал бүхий дархан эрх эдэлдэг. Тэдгээр нь парламентын гишүүний халдашгүй байдал, ерөнхийлөгчийн халдашгүй байдал, шүүгчийн халдашгүй байдал гэх зэргээр тусгалаа олно.

2. эрх дарх, хөнгөлөлт **parliamentary immunity**- парламентийн гишүүний халдашгүй эрх.

Дээрх хоёр ойлголтыг нэр томьёоны хувьд ийнхүү тайлбарласан байна.²²

Эдгээр хоёр ойлголтыг тус бүрд нь авч үзвэл: Нэгдүгээрт: **“ИММУНИТЕТ”** буюу Парламентын гишүүний халдашгүй эрхийн батлагааг илэрхийлэх дээрх ойлголтын хувьд дэлхийн улс орон харьцангуй ялгамжтай хэлбэрээр зохицуулдаг байна.

Тухайлбал:

Гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийг нь нотлох баримттайгаар баривчилсаас бусад тохиолдлын иммунитет /42 улс байdag бөгөөд үүнд Монгол Улс ч бас орно./ Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйл 29.2-д “Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална”. , Монгол Улсын Их хурлын тухай /2006 он/ хуулийн 6.9.1-д “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчииж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан.” Мөн хуулийн 34.7-д “Энэ хуулийн 6.9.1-д зааснаас бусад тохиолдолд гишүүнийг албадан saatулах, цагдан хорих, түүнэ шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр, албан ёрөө, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.” Энэ тохиолдолд УИХ-ын гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудал яригдлаг бөгөөд бүрэн эрхийн баталгаа няцаагдлаг юм.

Парламентын гишүүний халдашгүй эрхийн хугацаа харилцан аидлгүй байна. Жишээ нь: ХБНГУ-д парламентын гишүүний халдашгүй эрх Бундестаг ба Бундесратын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох

²² С.Нарангэрэл “Хууль зүй судпалын Англи- Монгол тайлбар толь” УБ., 2005 он, 471- дэх тал

хүртэл үргэлжилж байхад Япон Улсад чуулганы үед, Норвеги Улсад парламентын өрөөнд байх үед гишүүний халдашгүй эрх хүчин төгөлдөр байх харилцан адилгүй зохицуулалттай байдаг.

Хоёрдугаарт: “ИНДЕМНИТЕТ” хэмээх олголтын хувьд энэнэртомьёо парламентын гишүүний эрх зүйн байдалд хоёр утгаар хэрэглэгдэнэ. Нэгдүгээрт: Парламентын гишүүн **бусдыг доромжлох гүтгэхээс бусад тохиолдолд** бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үг, дэвшүүлсэн санал, өөрийн санаачилсан хууль, парламентын бусад шийдвэрийн төсөл, парламентаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариушлага хүлээхгүй байх гэсэн утгаар хэрэглэгдэнэ.

Хоёрдугаарт: Парламентын гишүүний “шагналын сан” гэсэн утгаар хэрэглэнэ.²³

Зарим орон парламентын гишүүний энэ бүрэн эрхийн баталгааг Үндсэн хуульдаа хуульчлан тогтоосон байдаг.²⁴

Жишээ нь:

ХБНГУ-ын Үндсэн хуулийн 76 дугаар зүйлийн нэгд: “Парламентын гишүүн нь Бундестагийн чуулган болон аль нэгэн хорооны хуралдаан дээр хэлсэн үг, дэвшүүлсэн саналынхаа төлөө хуулийн болон захиргааны хариушлага хүлээхгүй.” “Бундестагийн гишүүн бусдыг доромжилсон, гүтгэсэн тохиолдолд энэ зарчим үйлчлэхгүй.”

Франц Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд: “Үндэсний ассамблейн гишүүн нь үзэл болдоо чөлөөтэй илэрхийлсэн болон бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үг дэвшүүлсэн саналын төлөө хуулийн хариушлага хүлээхгүй.”

БНСУ-ын Үндсэн хуулийн 45 дугаар зүйлд: “Үндэсний чуулганы гишүүн нь чуулганы хуралдаан дээр албан ёсоор хэлсэн үг, дэвшүүлсэн саналынхаа төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариушлага хүлээхгүй”.

Япон Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлд: “Парламентын гишүүн нь бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үгийнхээ төлөө парламентын гадна хариушлага хүлээхгүй”. гэж тус тус заасан.²⁵

Монгол Улсын хувьд Улсын Их Хурлын тухай /2006 он/ хуулийн 34.3-д “Гишүүн бусдыг гэмт хэрэгт холбогдуулан доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд бүрэн эрхийнхээ хүрээнд хэлсэн үг, дэвшүүлсэн

²³.Өлзийсайхан “Парламентят ёс” УБ., 2006 он. 321 дэх тал

²⁴ Т.Доохүү, Ч.Энхбаатар “Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй” УБ., 2006 он. 172 дахь тал

²⁵ Л.Өлзийсайхан “Парламент” УБ., 2001 он. 89, 90, 142 дахь тал

санал, өөрийн санаачилсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан асуудлын төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариушлага хүлээхгүй". Гэж тодорхой заасан байна. Эндээс харахад Парламентын гишүүний Индемнитет эрх нь бусдыг доромжлох, гүтгэхээс бусад тохиолдолд л хүлээн зөвшөөрөгддөг, нэгэнт тогтсон ойлголт болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл парламентын гишүүн улс төрийн байр суурь, үзэл баримтлал, сонгогчдын эрх ашиг, итгэл үнэмшил, улс орны хөгжил дэвшилийн төлөө өөрийн үзэл болдоо илэрхийлж уг хэлэх нь зүй ёсны хэрэг бөгөөд энэ тохиолдолд парламентын гишүүн хэлсэн уг, дэвшүүлсэн саналынхаа төлөө бүрэн эрхийнхээ хугацаанд болон түүний дараа хуулийн хариушлага хүлээхгүй байх тухай ойлголт буюу хуулийн хүрээнд хэрэгжих ёстой эрх юм.

Энэчлэн индемнитет эрх нь үзэл болдоо чөлөөтэй илэрхийлэх, уг хэлэх эрхтэй салшгүй холбогдоно. Өөрөөр хэлбэл УИХ-ын гишүүн УИХ-ын чуулган дээр болон бусад газар уг хэлж, үзэл болдоо илэрхийлэх нь үзэл болдоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн нэг хэлбэр юм.

Үзэл болдоо чөлөөтэй илэрхийлэх эрх хүний үндсэн эрх бөгөөд аливаа ардчилсан нийгэмд улс төрийн үзэл болдлын чухал илэрхийлийн элемент юм. Энэ эрх чөлөөний дагуу хүн бүр өөрийн санаа бодолтой байх, мэдээлэл болон бүх төрлийн үзэл санааг хайх, олж авах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээх эрхтэй. Энэхүү эрх чөлөөг эдлэх явдал нь үүрэг хариушлагатай хамтдаа хэрэгжих бөгөөд тиймээс үндэсний аюулгүй байдал, нийгмийн эрүүл байдал буюу ёс суртахуун, бусдын нэр төр болон эрхийг хамгаалах буюу нууц мэдээллийг задруулахаас сэргийлэх зэрэг зорилгоор гаргасан журам болон хязгаарлалтад захирагдана.²⁶ Өөрийн үзэл бололтой байх эрх чөлөөг зөвхөн хуулийн хүрээнд бөгөөд улсын аюулгүй байдал, нийгмийн хэв журам, эрүүл мэнд, ёс суртахуун, бусад хүний эрх нэр төрийг хамгаалах ашиг сонирхлын үүднээс хязгаарлаж болно.

Өөрөөр хэлбэл аливаа эрх бусдын эрхээр хязгаарлагддаг тул хэн ч үзэл болдоо чөлөөтэй илэрхийлэхээ бусдыг доромжлох, гүтгэх болон бусад хууль бус арга хэлбэрээр илэрхийлж болохгүй юм.

Үзэл болдоо чөлөөтэй илэрхийлэх, уг хэлэх эрх нь тодорхой хүчин зүйлсээр хязгаарлагддаг Тухайлбал:

²⁶"Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь". УБ., 2006, 128 дахь тал Нээлттэй нийгэм форум, UNDP Mongolia

◆ Бусдын нэр төр, алдар хүнд

Хүний нэр, нэр төр алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг Олон Улсын болон бүс нутгийн хэмжээнд Олон улсын Конвенцийн хэм хэмжээгээр, дотооддоо Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль, эрх зүйн актаар баталгаажуулж ирсэн билээ.

Тухайлбал: Хүний эрхийн түгээмэл тунхаглал: 1 дүгээр зүйл: “Хүн бүр төрж мэндлэхдээ эрх чөлөөтэй, адилхан нэр төртэй, ижил эрхтэй байдаг.” “Оюун ухаан, нандин чанар занасан хүн гэгч өөр хоорондоо ахан дүүгийн үзэл санаагаар харьцах учиртай.”

Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлд: 1. Хүн бүр өөрийн санал бодлыг чөлөөтэй баримтлах эрхтэй. 2. Хүн бүр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй ...

3. Энэхүү зүйлийн 2-т дурдсан эрхийг эдлэх нь онцгой үүрэг, хариушлагыг ногдуулна. Энэ нь гагшгүү хуулиар тогтоосон зарим хязгаарлалттай холбоотой бөгөөд тэлгээр нь:

а/ Бусдын эрх, алдар хүндийг хүндэтгэх

б/ Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв, журам, хүн амын эрүүл мэнд буюу ёс сууринчныг хамгаалахад зайлшгүй шаардлагатай байна.²⁷

Хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалсан Үндэсний эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл: Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд: Монгол улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ. Үүнд:

16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, уг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Үүний зэрэгшээ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлд: Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн дараах үндсэн үүргийг хүлээдэг. Үүнд:

1/ Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх,

2/ Хүний нэр төр, алдар хүнд, эрх хууль ёсны ашиг сонирхолыг хүндэтгэх

Мөн Арван есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт: “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” гэж заасан байдаг.

²⁷Иргэний болон Улс төрийн эрхийн Олон Улсын Пакт. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. УБ., 1993 он. 16 дахь тал

Эндээс харахад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө ба хувь хүний нэр төрийг хамгаалах хэрэгцээ хоёр нь зохистой тэнцвэрт байдлаар хангагддаг буюу нэг эрх нөгөө эрхээр хязгаарлагддаг байна. Хэрвээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, уг хэлэх эрхийг хэтрүүлэн хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох буюу гүтгэвэл хууль тогтоомжид заасан хариушлага хүлээх юм.

Энд дурдсан **доромжлох гэдэг нь хууль зүйн хувьд**: Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр доромжилсон үйлдэл, эс үйлдэхүй байна.²⁸ Бусдыг доромжлох нь уг хэлээр, тодорхой үйлдэлээр илрэдэг байна. Хэл зүйн хувьд: Доромжлох басамжлах, дээрэлхэх дарлах, гэсэн утгаар тайлбарлагддаг.²⁹

Гүтгэх гэдэг нь: Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирадлэг тараасан идэвхтэй үйлдэл байна.³⁰ “Оргүй хэргийг зохиомж муутгах унагах, худал хэрэг тулгах буюу гөрлөх, гүтгэх, гүжирадэх” гэсэн утгаар хэл зүйн хувь тайлбарласан байдаг.³¹

Түүнчлэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, уг хэлэх эрхийг эдлэхдээ бусдыг доромжлох буюу гүтгэх хэлбээрээр илэрхийлэх нь Эрүүгийн хууль³²-д заасан гэмт хэргийн шинжтэй үйлдэл болох юм.

Цаашилбал бусдын эдийн бус эрх ашигт гэм хор учруулсан этгээд түүнийгээ бодит байдалд нийцсэн эсэхийг нотлож чадаагүй тохиолдолд Иргэний хуульд заасан эд хөрөнгийн хариушлага хүлээх, учирсан хохирлыг арлигах үүрэг хүлээх механизм бий.³³

♦ Улсын, байгууллагын, хувь хүний нууц

Мөн үзэл бодлоо илэрхийлж, уг хэлэхдээ Улс, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулж, болохгүй юм. Энэ

²⁸ С.Жанцан “Монгол улсын эрүүгийн эрх зүй” /тусгай анги/ альбом схем УБ., 2003 он. 100 дахь талд

²⁹ Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 202 дахь талд

³⁰ С.Жанцан “Монгол улсын эрүүгийн эрх зүй” /тусгай анги/ альбом схем УБ., 2003 он. 100 дахь талд

³¹ Я.Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” 166 дахь талд

³² Монгол Улсын Эрүүгийн хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны №5, 110 дугаар зүйл. Доромжлох, 111 дүгээр зүйл. Гүтгэх

³³ Монгол Улсын Иргэний хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны №7, 21 дүгээр зүйл. Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, 511 дүгээр зүйл. Эдийн бус гэм хорыг арилгах

тохиолдод мөн хуулиар хязгаарлагдана. Тухайлбал: Эрүүгийн /2002 он/ хуулийн 87 дугаар зүйлийн 87.1-д “Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлс, объект үйл ажиллагааг итгэмжлэгдсэн хариусан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

Хувь хүний нууцын тухай /1995 он/ хуулийн 136 дугаар зүйл 136.1-д “Хуулиар хамгаалагсан хувь хүний нууцыг албаны болон мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа мэдсэн этгээд задруулсан бол хөдөлмөрийн хөлслний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.”

Өөрөөр хэлбэл үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийг эдлэхдээ дээрх хэлбэрээр улс, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагсан нууцыг задруулж, халдаж болохгүй бөгөөд энэ тохиолдолд дээрх эрх хязгаарлагдах ёстой юм.

♦ Ёс суртахуун

Үзэл бодлоо илэрхийлэх эрх нь мөн ёс суртахуунтай зайлшгүй холбогдож түүгээр мөн хязгаарлагдах юм.

Өөрөөр хэлбэл хувийн болон төрийн албан хаагчийн нийтлэг ёс зүйн болон бусад хэм хэмжээгээр хязгаарлагдана.

♦ Нийгмийн хэв журам, Улсын аюулгүй байдал

Түүнчлэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхдээ улс, нийгмийн аюулгүй байдлыг алдагдуулах нь хуулиар хоритой юм.

♦ Ялгаварлан гадуурхах

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйл 16.2-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” Хүн бүр эрх зүйн этгээд байна.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийн илрэл нь ялгаварлан гадуурхах аливаа хэлбэрийг агуулж болохгүй юм.

Иймд аливаа хүн тэр дундаа УИХ-ын гишүүн хүн тодорхой **ҮГ ХЭЛЛЭГ, ҮЙЛДЭЛЭЭР** бусдыг гүтгэх, доромжлох, гэмт хэрэгт холбогдуулан гүтгэх нь үзэл болдоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн, Парламентын гишүүний **ИНДЕМНИТЕТ** эрхийн хүрээ хязгаарыг хэтрүүлсэн үйлдэл болох юм.

Түүнчлэн УИХ-ын гишүүн нь халдашгүй бүрэн эрхийн баталгаатай байх боловч УИХ-ын гишүүний хууль тогтоомжид заасан үүрэг, хариуцлага гэж бий тухайлбал: УИХ-ын гишүүний эрх зүйн байдлын тухай /1997 оны/ хуулийн 8.8-д “Улсын Их Хурлын гишүүний хувьд үг хэлэх, санал гаргах, дүгнэлт хийхдээ асуудалд нотолгоотой, хариуцлагатай хандах;” 8.9-д “Төрийн зүтгэлтийн нийтлэг болон Улсын Их Хурлын гишүүний хувьд тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, төрийн нууц хадгалах; үүрэгтэй” болохыг тодорхой заасан байна.

Парламентын гишүүний халдашгүй байх эрхийн илэрхийлэл иммунитет, индемнитет гэх ойлголтыг хэл шинжлэлийн болоод утга агуулгын, хүний эрхийн, хууль зүйн талаас нь тодорхой хэмжээнд хөндөн авч үзлээ.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Парламентын гишүүн нь хууль тогтоомж болон олон улсын зарчмаар хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн эрхийн баталгааг эдлэх боловч үндсэн эрхийн тодорхой хэм хэмжээ хязгаарлалт, хууль тогтоомжид захирагдах нь хүний эрх, хууль дээдэлсэн, ардчилсан хүмүүнлэг иргэний нийгээний зүй ёсны шаардлага юм.

--ooOoo--

МОНГОЛ УЛС ДАХЬ ШАШИН ШҮТЭХ, ЭС ШҮТЭХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

**Б. Оюун-Эрдэнэ Улаанбаатар Дээд Сургуулийн
Гэр бүл судалын тэнхимийн багш**

Шүтэн бишрэх эрх чөлөөний асуудал нь төр сүм хийдийн харилцааны практик, эрх зүйн зохицуулалт, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилттэй нягт холбоотой чухал асуудал болно.

Монгол улсын үндсэн хуулийн 2-р бүлгийн 15-р зүйлд Монгол Улсын иргэн бүр шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэйг тунхагласан. Мөн “Төр сүм хийдийн харилцааны тухай хууль”, “Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-т үндсэн хуульд заагдсан шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хангах хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээ тодорхойлогдсон. Орчин үед шүтэн бишрэх эрх чөлөөг аль нэг шашныг шүтэх, шашны зан үйл үйлдэх, бусдад шашныг сурталчилж номлох, нөлөөлөх төдийгүй үүний эсрэгээр ямар ч шашныг эс шүтэх, шашны зан үйлийг эс үйлдэх, шашингүйн үзлийг сурталчлан номлох, бие хүн, бүлэг, нийгмийн секуляризацид нөлөөлөх эрх, эрх чөлөө гэсэн нарийн нийлмэл утга агуулгаар авч үзэж ойлгож байгаа юм.

Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль, Улсын Их Хурлын сонгуулийн хууль, аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль зэрэг иргэдийг сонгох, сонгогдох, ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох эрхтэй холбоотой олон хуулиудад үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлаж болохгүйг хуульчлан заасан билээ. Энэ бүгдээс үзэхэд Монгол улсад иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө хуулиар нэгэнт баталгаажжээ. Энэхүү тэгш эрх ба ялгаварлан гадуурхахгүй байх зарчим нь олон улсын хүний эрхийн хуулийн хамгийн чухал элемент юм. Иймээс улс орны дотор мөрдөгдөж байгаа хууль тогтоомжууд нь бүх төрлийн ялгаварлан гадуурхах явалыг хориглон, хүн бүрт тэгш хамгаалал үзүүлэх баталгаа болж байх ёстай.

Дээрх хуулиудын заалтуудын хэрэгжилт бодит амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгаа нь өнөөдөр хамгийн чухал асуудал юм.

Эрх чөлөө гэдэг нь бусдын хараа хяналтаас ангиid өөрийн гэсэн үзэл бодол, ёс суртахууны үүднээс бие даан сонголт хийх бололцоо нөхцөл юм. Монгол дахь шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөний өнөөгийн байдлын талаар МУИС, НҮБХХ-ийн хүний эрхийг хангах төслөөс хамтран 2004 онд социологийн судалгааг асуулгын аргаар хийсэн байна. Уг судалгаагаар оролцогчдын 85,3% аль нэг шашныг шүтэх эсэх нь хувь хүний сонголт, 7,2% нь хууль болон төрийн бодлогод нийцүүлэх хандлага, 4,9 % нь шашныг дураараар шүүмжлэх ба хамгаалах арга, 2,6 % нь бусад гэж хариулжээ. Мөн судалгаанд оролшогчдын 60 шахам % нь өөрсдийн эс шүтэх, шүтэх эрх чөлөөгөө хангалттай гэж дүгнэсэн нь иргэд шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэх эрх зүйн орчин бүрдсэнийг илтгэж байна гэж дүгнэжээ.¹ Харин судалгаанда хамрагдлагад шашин сүм хийдийн талаар явуулж байгаа бодлого арга хэмжээ, хуулийн заалтуудын талаар мэдлэг багатай нь ажиглагдсан байна. Тухайлбал 7,4% шашин сүм хийдийн талаарх хууль тогтоомжийн талаар хангалттай мэдээлэл авдаг гэж үзсэн бол 73,2 % нь энэ талаар мэдлэг тун бага гэж хариулжээ. Энэ нь шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө хуулиар хангагдсан ч амьдралд төдийлөн хэрэгжихгүй байгаа, энэ талаарх сургалт, сурталчилгаа бага байгаатай холбоотой юм.

Бидний 2006 онд явуулсан судалгаагаар иргэдийн шашин шүтлэгийн ерөнхий төлөв дараах байдалтай байв.


Сошиалист нийгмийн үед хүмүүсийн эс шүтэх эрх л хангагдах бололцоотой байсан бол орчин үед хүний шүтэх, эс шүтэх эрх хослон хангагдаж байна.

1.	Бурханы шашныг шүтдэг	Христосын шашныг шүтдэг	Исламын шашныг шүтдэг	Бусад
2	61.4%	30.6%	6.1%	1.9%

Дээрх дүнгээс үзэхэд Монголын сүсэгтнүүдийн дуна шашны плораль байдал нэгэнт бий болсон бөгөөд цаашид гүнзгийрэх хандлагатай байгаа нь тодорхой байна.

¹ Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө. УБ., 2004

Монгол дахь шашин сүм хийдмийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлж чадах нь?



Энэхүү үзүүлэлтээр иргэдийн шашин шүтлэгийн талаарх хууль тогтоомжийн мэдлэг маш бага байгаа нь харагдаж байна.

Ямар шалтгаанаар шашин шүтдэг болохыг тодруулахад :

1	Нийгэм, хямралтай, сэтгэл санаа тайван бусаас	17.4%
2	Амьдралд тохиолдсон зүйлдээ хүчин мөхөсдсөннөөс	38.1%
3	Уламжлал ёс заншлаа хадгалахын тулд	6.1%
4	Ирээдүйн сайн сайхан амьдралын төлөө	20.4%
5	Шашны үзэл номлогоор сэтгэлээ ариусгаж, өөрийгөө гэгээрүүлж, хүмүүжүүлэхийн тулд	18.0%

Шашин шүтэх болсон гол шалтгаанаа ямар нэг зүйлд хүчин мөхөсдөх гэж хариулсан хариулт өндөр, өөрийгөө гэгээрүүлж, хүмүүжүүлнэ, уламжлал ёс заншлаа хадгална гэдэг хариулт бага байгаа явдал нь сүсэгтнүүд ихэвчлэн мухар сүсгээр, нөгөө талаас өөрийн санасан зүйлээ гүйцэлдүүлэхийн тулд λ шашнаас тусlamж авах гэж хандлагийн илрэл юм.

Шашин шүтэхийн ач холбогдол юунд байdag вэ? гэсэн асуултанд:

1	Гэм нүүглээ арилгана	21.2%
2	Сэтгэл санаагаа тайвшруулна	44.6%
3	Мэдлэг боловсролоо дээшлүүнэ	13.1%
4	Ёс суртахууны доголдлоосоо ангижирна	10.0%
5	Муу, муухай зүйлийг холдуулна	24.7%
6	Энэрэнгүй үзэлтэй болно	6.4%

Хүснэгтээс харахад шашин шүтэгчид сэтгэл санааны тайвшралыг авахын тулд, мөн мүү муухай зүйлээс өөрсдийгөө авран хамгаалахын тулд шашин шүтдэг байна. Харин шашин шүтсэнээр мэдлэг боловсрол дээшилж, ёс суртахууны доголдлоос ангижирна гэж төдийлөн үзэхгүй байгаа нь шашны явуулж буй үйл ажиллагаа, сүсэгтэнд үйлчилж буй хандлага, нөгөө талаас иргэдийн шашны боловсрол бага байгаатай холбоотой гэж үзэж байна.

Шашин шүтлэгийн асуудал нь нийгэмд нөлөөлөгч бодит хүчин зүйл учир түүнийг анхааран судлах нь чухал юм. Хууль тогтоомжуудийн заалтын дагуу шашин шүтлэгийн талаар хүнийг ялгаварлан гадуурхаж болохгүй боловч Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүн ардын амар тайван аж төрөлд хохирол учруулж болох аливаа үзэгдэл, үйл явдлаас сэргийлэх нь монголын иргэн бүрийн үүрэг байх ёстай. Монгол улсын хэмжээнд явуулж байгаа аливаа шашны үйл ажиллагаа нь тухайн улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалдаа харшлах ёсгүй гэсэн үндэслэл бол манай орны хувьд шашин шүтэх эрх, эрх чөлөөний асуудал дээр баримтлах хамгийн чухал үндэслэл юм. Ийм ч учраас Монгол Улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 19-р зүйлийн 3-т Хүн эрх, эрх чөлөөгөө өдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй гэж заасан байдаг.

Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд ард түмний уламжлалт соёлыг хадгалах асуудал нэн чухал зорилт болдог. Глобалчалын энэ зуунд үндэстний язгуур онцлог шинжээ хадгалж үлдэх асуудал жижиг үндэстний хувьд манай чухал асуудлын нэг юм. Хүний эрхийн талаарх дэлхийн хэмжээний болон бус нутгийн баримт бичгүүд нь хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглохын зэрэгцээ цөөнхийн бүлгийн зан заншил, соёлыг хамгаалах онцгой нөхцлүүдийг заасан байдаг. Хүн бүр болож сэтгэх, шүтэх бишрэх эрхтэйн зэрэгцээ өөрийн шашнаа шүтэх, соёлоо дээдлэх эрхтэй байдаг бөгөөд хувь хүний эрх нь эргээд тухайн жижиг үндэсний хэсгүүдийн өөрийн хэл, соёл, шашнаа хамгаалан авч үлдэхээс шалтгаална хэмээн хүний эрхийн зөвлөмжид дурьдсан байна. Жижиг үндэстний өөрийн соёл, хэлээ хөгжүүлж, шашнаа шүтэх эрхийг хамгаалахын тулд тухайн улсаас үндэслэлтэй бөгөөд бодитой эерэг арга хэмжээ авах шаардлагатай байж болохыг

ч тэмдэглэсний зэрэгцээ хүний эрхийг хамгаалах нь жижиг үндэсний хэсгүүдийн соёл, шашин ба нийгмийн оншлогийг алдагдуулалгүй хөгжүүлэх, улмаар тухайн нийгмийн нийт бүтцийг сайжруулахад чиглэх юм гэж заасан байдаг.²

Монгол улсын хувьд үндэстний соёл, уламжлалаа хадгалж үлдэх асуудал өнөөгийн чухал асуудал болж дэвшигдэж байгаагийн хувьд иргэд шашин шүтэх, эс шүтэх эрхээ хэрхэн ямар замаар эдэлж байгаад анхаарал хандуулах шаардлагатай юм. Энэ асуудал нь зөвхөн хууль батлагдсанаар зохицуулагдах асуудал биш бөгөөд нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан ямраар ч эргэж болох нийгмийн эмзэг асуудал мөн. Иймд НҮБ-аас хүний эрх, тухайлбал шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөний талаар бодлого явуулдаг талаар бодитой мэдээллийг иргэдэл хүргэж, энэ талаарх хууль зүйн мэдлэгээр хангах асуудал чухал байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Шашин буюу сүсэг бишрэлээ илэрхийлэх эрх чөлөө нь тахин шүтэх, даган мөрдөх, зан үйлдэлхийх ба заан сургах гэсэн өргөн хүрээг хамардаг. Энэ байдал нь иргэдийн дунд хэрхэн өрнөж байгааг судалгаанаас харахад зарим талаар энэ эрх нь зөрчигдөг тал ажиглагдсан юм. Тухайлбал шашин суртал, үзэл бодлыг заан түгээхдээ зарим шашнууд хэт улайрсан сурталчилгаа хийдэг, бусад шашныг гутаан дормжилсон, сүсэгтнүүдийн сэтгэл санааг хямраасан, иргэдийн эдийн засгийн гачигдлтай байдлыг ашигласан, үндэстний ёс заншлыг үгүйсгэсэн зэрэг үйлдлүүд зарим үед гардаг нь ажиглагдлаа.

Иймд сүм хийд шашны байгууллагууд нь Монголын үндэсний уламжлал ёс заншлыг хүндэтгэсэн байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө хүн өөрөө сонгох боломжийг нь олгох зэрэг зайлшгүй чухал шаардлагуудыг хангуулах тал дээр анхаарах нь зүйтэй. Шашин сүсгийг шүтэн бишрэх буюу шинээр орохыг саатуулах, өөрийн шашны үнэмшилийг шүтлэгтэй, шүтлэггүй бусад хүмүүст тулган хүч хэрэглэхээр заналхийлэх буюу шийтгэх өөрийн шашнаас нь татгалзуулах буюу урвуулж авахыг хүчээр тулгахыг хориглосон байх шаардлагатай байна. Нөгөө талаас шашны сургаал номлолыг чөлөөтэй, ил тод сурталчлах, шашны байгууллага сүм хийдийн үйл ажиллагаа нь олон түмэнд нээлттэй байх зарчмыг төрөөс тавих нь зүйтэй.

² Шашин шүтэх, эс шүтэх, эрх, эрх чөлөө. 2004, x168

Хүний эрхийн зөвлөмжид “Засгийн газар өөрийн нийгмийн эмзэг бөгөөд ялгаварлан гадуурхагдсан бүлэг болон ядуу хүмүүсийг гадуурхахаас хамгаалсан дорвитой нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлбэл зохино” хэмээн заасан байдаг. Манайд ядуурал, ухамсар, боловсрол, соёлын түвшинд оогуур байгаа нь сонгох эрхгүйгээр өөртнүү өглөг, хандив туслашaa үзүүлсэн шашинд аргагүйн эрхээр орох хандлагыг төрүүлж байгааг анхаарч үндэсний соёл уламжлалаа хадгалах, шашин шүтэх эрх чөлөөг хамгаалах зайлшгүй шаардлагатай байна. Судалгаагаар амьдрал ахуйд тусалсан буюу сургалт дамжаанд хамруулсаны улмаас тухайн шашныг шүтдэг болсон гэж хариулсан хүний тоо нэлээд их байгаа нь үүнийг баталж байгаа юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 18-р зүйлд: “хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шүтэж бишрэх, сүсэглэх эрхтэй, энэ нь шашин шүтлэг буюу үзэл бодлоо өөрчлөх эрх, ганцаараа буюу бусадтай хамтран нийтийн болон хувийн журмаар шашин шүтлэг, үзэл бодлоо заан түгээх, мөргөл хийх, сургаал айлдах, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх эрхийг хамарна” гэж заажээ. Шашны ямар ч байгууллага сүм хийд, шашны зүтгэлтүүд, номлоочид шашны номлол сургаалыг сурталчлан түгээж болох боловч иргэдийн шүтэх шашнаа сонгох эрхийг нь зөрчиж болохгүй.

Сүүлийн үед манай улсад шинээр орж ирж байгаа шашнууд нь хүүхэд залуучуудын дунд шашны сурталчилгаа явуулах нь их байгааг “хүүхэд нь насанда хүрээгүй учир яс үндэс, арьс өнгө хүйсийн ялгаа, хэл, шашин шүтлэг харьяалал буюу нийгмийн гарал, үүсэл, өмчийн байдал, төрсөн болон бусад байдлаас үл хамааран гэр бүл, нийгэм ба төрийн хамгаалалтанд байх хэрэгтэй” гэсэн олон улсын хүний эрхийн заалт, “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 1-р бүлгийн 4-р зүйлийн 1-дэхь заалтуудтай тус тус хэрхэн холбогдож байгааг анхаарч үзэх хэрэгтэй байна. Уг хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлийн 4-д “хүүхдэд шашны үзэл номлолыг тулган хүлээлгэх, хүүхдийг хууран мэхлэх замаар шашны үйл ажиллагаанд татан оролцуулах шашны сургууль сүм хийдэл албадан суулгах”-ыг хориглосон байдаг. Иймээс хуулийн заалтуудын хэрэгжилтэнд хяналт тавих, хүүхэд залуучуудын шашин шүтлэгийн эрх, эрх чөлөөнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Эцэст нь дүгнэж тэмдэглэхэд Монгол улсад иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрх эрх чөлөө хуулийн хэмжээнд бүрэн тусгалаа олсон ч бодит амьдралд хэрэгжих тал дээр зарим нэгэн зөрчигдөж байгаа асуудал байгааг анхаарч үзэх шашин шүтлэг үзэл боллоо чөлөөтэй илэрхийлэх, чөлөөтэй сонгох эрхийг нь алдагдуулж, ямар нэгэн шашин суртыг хүчээр тулган хүлээлгэх, үзэгдэл үйл ажиллагаатай тэмцэх, иргэдийн шашны боловсролын асуудалд анхаарч ялангуяа шашны талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг өгөх ажлыг боловролын байгууллагаар дамжуулан төрөөс шийдвэрлэх шаардлагатай байна. Иргэдийн итгэл үнэмшлээрээ шашнаа сонгох эрх нь зөрчигдөж байгаа явдал нь иргэд, ялангуяа хүүхэд залуучуудын амь нас, эрүүл саруул ухаан, амьдралд нь сөргөөр ноштой нөлөөлж байгаагаар зогсохгүй, улс орны үндэсний язгуур эрх ашиг, соёл, оюун санаа, ёс заншил, уламжлалын тусгаар тогтнолд аажмаар аюул учруулж байгааг ч тэмдэглэх нь зүйтэй.

Ном зүй:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992
2. Монгол Улсын хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль
3. Монгол улс дахь шашны өнөөгийн нөхцөл байдал, УБ., 2006.
/ зохиогчийн судалгаа/
4. МУИС-ийн шашин судлалын тэнхимийн судалгаа. УБ., 2006
- 5: Монгол Улсад Хүний эрхийг хангах хөтөлбөр. УБ., 2003
6. Хүний эрхийн конвенцийдийн хорооноос гаргасан ерөнхий санал, зөвлөмжүүдийн эмхтгэл. УБ., 2004

ХДХВ/ДОХ ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГТ

Н.Дашдорж Хуульч

ХДХВ/ДОХ-той холбоотой асуудлууд хүний эрхийн зарчмын үүднээс үндэсний болон олон улсын баримт бичгүүдэд зохих тусгалаа олжээ. Эдгээр баримт бичгүүдийг бүхэлд нь авч үзвэл дараах 2 хэсэгт хувааж авч үзэж болно.

Үүнд:

1. Олон улсын баримт бичгүүд
2. Дотоодын хууль тогтоомж

Олон улсын:

-ХДХВ/ДОХ-ын асуудлаарх НҮБ-ын Ерөнхий ассамблейн тусгай чуулганы тунхаглал

- НҮБ-ын ХДХВ/ДОХ-ын талаарх нэгдсэн хөтөлбөр
- НҮБ-ын ХДХВ/ДОХ болон холбоо бүхий асуудлыг хууль зүйн үүднээс зохицуулах зөвлөмж
- ХДХВ/ДОХ-ын талаар олон улсын мөрдөх Женевийн зарчмууд / НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газар болон НҮБ-ын ХДХВ/ДОХ-ын талаарх нэгдсэн хөтөлбөртэй хамтран 2006 онд гаргасан/

Дотоодын:

- ХДХВ/ДОХ-оос сэргийлэх хууль
- Монгол улсад ХДХВ/ДОХ өвчинтэй тэмцэх үндэсний стратеги
- ХДХВ/ДОХ-оос сэргийлэх, тэмцэх дэд хөтөлбөр /2002-2010 он/
- Төрөлжсөн хуулиуд

Харилцааг зохицуулсан хуулиас бусад хууль тогтоомжид ХДХВ/ДОХ-ын асуудлыг шууд заагаагүй,

ХДХВ/ДОХ-ын асуудлыг шууд зохицуулж байгаа олон улсын болон үндэсний баримт бичгүүдийг хоорона нь харьцуулж авч үзэх нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Ийм баримт бичиг нь олон улсынхаас дээр заасан НҮБ-ын зөвлөмж, Женевийн зарчмууд, дотоодынхоос ХДХВ/ДОХ-оос сэргийлэх хууль, бусад холбогдох хуулиуд болно.

НҮБ-ын зөвлөмжийн үзэл санаанууд үндсэндээ Женевийн зарчима тусгалаа олсон байна. Иймд Женевийн зарчмуудын үзэл санаа Монгол Улсын хуулиудаал хэрхэн тусгалаа олсон, өөрөөр хэлбэл, ХДХВ/ДОХ-ын асуудлаарх Монгол Улсын хуулийн зохицуулалт олон улсын хүний эрхийн стандарт, зарчима хэрхэн нийцэж байгааг харьцуулж үзье:

1. Засгийн газруудын ХДХВ-тэй холбоотой үндэсний үйлажиллагаагаа үр дүнтэй болгох зорилгоор зохицуулалттай, оролцооны, ил тод, хариушлагын зарчим дээр тулгуурласан ХДХВ-ийн бодлого хөтөлбөрийг Засгийн газрын бүхий л салбарт нэвтрүүлэх шаардлагатай..

НҮБ-ын зөвлөмжид “Засгийн газрын байгууллагын үйл ажиллагааны бүх үе шатанд ХДХВ/ДОХ-л хандах бодлого ба хөтөлбөрийг нэгтгэсэн үр ашиг бүхий баазыг бий болгох” гэж заажээ

2. Засгийн газрууд нь ХДХВ-тэй холбоотой бодлого боловсруулах үйл явц, хөтөлбөрийн хэрэгжилт болон үйл ажиллагааг дүгнэх явцдаа олон нийттэй зөвлөлдөхийг санхүү, улс төрийн дэмжлэгээр хангах шаардлагатай. Үүнтэй холбоотой олон нийтийн үйл ажиллагаа явуулж буй байгуулагүүд, тэр дундаа ёс зүй, хууль, хүний эрхийн салбарт ажиллаж буй олон нийтийн байгууллагуудад ажиллах боломжийг төрийн зүгээс хангах шаардлагатай.

- Хууль, эрх зүй, бодлогын баримт бичгүүд, түүнчлэн орон нутгийн дэд хөтөлбөр/ 2002-2010/-т ХДХВ/ДОХ-ын талаар тусгагдсан зорилго, зорилтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар заасан байна. Харин бодлого, хөтөлбөрийг боловсруулах, дүгнэх үе шатанд хэрхэх талаар тодорхой заасангүй

3. Засгийн газрууд ХДХВ-тэй холбоотой үүсч буй олон нийтийн эрүүл мэндийн асуудлыг олон нийтийн эрүүл мэндийн хуульд тусгах зорилгоор эрүүл мэндийн хуулиудаа шинэчлэх, энгийн замаар халдварлах халдварт өвчтөнүүдийн талаарх заалтуудыг зүй бусаар ХДХВ-д хамаатуулахгүй байх, мөн эдгээр зүйлүүд нь Засгийн Газрын хүлээх олон улсын хүний эрхийн үүрэг хариушлагатай нийцэж байгааг хангах шаардлагатай.

- Эрүүл мэндийн тухай хууль 1998 онд батлагдан гарсан. ХДХВ/ДОХ-ын талаартусгайлсан заалт үгүй. Төрөөс төлбөрийг нь хариуцах эмчилгээ,

үйлчилгээнд ХДХВ/ДОХ ороогүй байна. НҮБ-ын зөвлөмжид “нийтийн эзүүл мэндийн салбар дахь хууль тогтоомжийг өөрчлөх, шинэчлэхдээ ХДХВ/ДОХ-тойхүүсийн эрүүл мэндийг хамгаалах асуудлыг цогцоор авч үзэх ба хүний эрхийн олон улсын стандартуудад нийцүүлэх”-ийг чиглэл болгожээ. Дээрх зарчим болон зөвлөмжид заасан чиглэлийн дагуу дурдсан хуульд нэмэлт оруулах шаардлагатай байна.

4. Засгийн Газрууд эрүүгийн хууль болон засан хүмүүжүүлэх тогтолцоо нь олон улсын хүний эрхийн талаар хүлээх үүрэг хариушлагатай нийцсэн, ХДХВ-тэй холбоотой нөхцөлд эдгээр хууль болон засан хүмүүжүүлэх тогтолцоо буруугаар ашиглагдахгүй байхыг, эмзэг бүлгүүдийн эсрэг чиглэгдээгүй байхыг хангах шаардлагатай.

- Цөөнгүй улсын эрүүгийн хууль тогтоомжид, түүний дотор Монгол Улсын Эрүүгийн хуууль/105.3-р зүйл/ “өөрийгөөХДХВ халдварт авсан болон ДОХ-оор өвчилснөө мэдсээр байж бэлгийн харьцаанд орох, болон тухайн өвчнийг түгээхэд эрүүгийн хариушлага хүлээнэ” гэж заасан байдаг. Энэ нь тухайн өвчинөөс урьдчилан сэргийлэх гэхээсээ илүүтэй хүний халдашгүй дархан байх, эрх чөлөөтэй байх эрхэд халдсан асуудал болно гэж мэргэжилтнүүд үздэг байна. Эрүүгийн хууль тогтоомж ба засан хүмүүжүүлэх байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан хуулийг олон улсын стандартуудад нийцүүлэх асуудал мөн НҮБ-ын зөвлөмжид тусгалаа олсон байна

5. Засгийн газрууд эмзэг бүлэг олон нийт, ХДХВ-тэй амьдарч буй хүмүүс, тахир дутуу хүмүүсийг хувийн хэвшлийн ба төрийн салбарт хамгаалдаг үл ялгаварлан гадуурхах болон бусад хамгаалалтын хууль гаргах, байгаа хуулиудаа батжуулах, шинжилгээ судалгааны субъект нь хүн байгаа тохиолдолд хувийн нууцлал болон ёс зүйг баримтлахыг шаардах, олон нийтийн боловсрол мэдээллийг түгээх, ямарваа ялгаварлан гадуурхалтай холбоотой зөрчил гарсан тохиолдолд шуурхай байдлаар хохирогчийн хохирлыг захиргааны болон иргэний шүүхээр барагдуулахыг хангах шаардлагатай.

- Боловсролын тухай хууль болон Хувь хүний нууцын тухай хуульд зохих нэмэлт өөрчлөлтийг оруулахын хамт Алагчлах, ялгаварлан гадуурхахын эсрэг хуулиудыг шинээр боловсруулж батлан гаргах

шаардлагатай байна. НҮБ-ын зөвлөмжид энэ асуудал туссан. Тэрчлэн ХДХВ/ДОХ-оос сэргийлэх тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.3-т ХДХВХ авсан буюу ДОХ-той хүмүүс эрхэлж болохгүй ажил үйлчилгээг ЭМАЭТЗТБ тогтоохоор заасан нь тэдгээр хүмүүсийг алагчилсан шинжтэй болжээ.

6. Засгийн газрууд ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх чанартай арга хэмжээ болон үйлчилгээний өргөнөөр хүртээлтэй байдлыг хангах, аюулгүй, сайн чанартай антиретровайрал эм ба эмийн бэлдмэлийг зохицтой үнээр борлуулахыг хангахын тулд ХДХВ-тэй холбоотой бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээллийг зохицуулсан хууль тогтоомж гаргах шаардлагатай. Засгийн газрууд нь эдгээр үйл ажиллагаа, арга хэмжээг дотоод болон олон улсын түвшинд авч хэрэжүүлэхдээ эмзэг хүмүүс болон эмзэг олон нийтэд түлхүү анхаарах шаардлагатай.

7. Засгийн газрууд ХДХВ амьдралд нь нөлөөлсөн хүмүүст эрхийнх нь талаар мэлдэг боловсрол өгөх, эдгээр эрхийг нь хэрэгжүүлэхийн тулд үнэ төлбөргүй хууль зүйн үйлчилгээ үзүүлэх, ХДХВ-тэй холбоотой хууль зүйн асуудлаар мэргэшсэн мэлдэг мэдээлэл бий болгох, шүүхээс гадна тогтолцоогоор буюу хууль зүйн яамны тусгай газар, омбудсман, эрүүл мэндийн гомдол шийдвэрлэх газар, хүний эрхийн хороонуудаар дамжуулан хүний эрхийг ханган хамгаалах шаардлагатай.

- ХДХВ-тэй амьдарч буй хүмүүст үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх талаар хуульд заагаагүй байна. Ийм шаардлагыг мөн НҮБ-ын зөвлөмжид заасан байгаа.

8. Засгийн газрууд эмзэг бүлгүүдийн эрх тэгш бус байдал, эмзэг бүлгүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг зогсоох зорилгоор эдгээр олон нийттэй хамтран, олон нийтээр дамжуулан эмэгтэйчүүд, хүүхдүүд болон бусад эмзэг бүлгүүдийг дэмжсэн, хамгаалсан нөхцөлийг бүрдүүлэхийг зорих, эдгээр олон нийтэд тусгайлан зориулсан нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Засгийн газрууд ХДХВ-тэй холбоотой ялгаварлан гадуурхалт, шоовдорлолын хандлагыг өөрчилж, зөв ойлголтыг төлөвшүүлэхдээ илт чиглэсэн шинэлэг боловсрол, сургалт танин мэдэхүй, хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн хөтөлбөрүүдийг байнга өргөнөөр тараах, сурталчлах, дэмжих шаардлагатай болдог.

- ХДХВ/ДОХ-оос сэргийлэх тухай хууль /12-р зүйл /-д хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн оролцооны тухай заалт байх боловч түүнийг дээрх зарчмын шаардлагатай нийцүүлж өөрчлөх нь зүйтэй байна.

9. Засгийн газрууд төрийн алба ба хувийн хэвшлийн салбарт хүний эрхийн зарчмуудад тулгуурласан мэргэжлийн хариуцлагатай үйл ажиллагаа бий болгох зорилгоор ХДХВ-тэй холбоотой биеэ авч явах зарчмуудыг бий болгох, эдгээр зарчмуудыг хэрэгжүүлж төлөвшүүлэхэд хэрэгцээтэй дагалдах тогтолцоонуудыг бүрдүүлэх үүрэгтэй.

10. Засгийн газрууд ХДХВ-тэй амьдарч буй хүмүүс, тэдний гэр бүл, олон нийтийн хүний эрхийг хангах хамгаалах мониторингийн болон хэрэгжилтийн тогтолцоонуудыг бүрдүүлэх үүрэг хүлээдэг.

- ХДХВ/ДОХ-оос сэргийлэх тухай хууль /11.1.7/-д ХДХВ/ДОХ-той нь тогтоогдсон бол энэ тухайгаа өөрийн эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчид нэн даруй мэдэгдэх талаар заажээ. Энэ заалт хувь хүний нууцыг задруулахтай ямар нэг байдлаар холбоотой байна

11. Засгийн газрууд ХДХВ-тэй холбоотой хүний эрхийн асуудлуудын талаар мэдлэг туршлагаа UNAIDS болон бусад НҮБ-ын агентлаг хөтөлбөрүүдтэй хуваалсан хамтран ажилласнаар олон улсын түвшинд ХДХВ-тэй холбоотой хүний эрхийг ханган хамгаалах тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

--ooOoo--

**ДОХ/ХДХВ-ЭЭС
ТУСЛНАА.**

СЭРГИЙЛЭХЭД

БОЛОВСРОЛ

Д.Баасансүрэн. ЭМШҮИС-ийн Гистологийн тэнхмийн багш

Одоогоос 20 гаруй жилийн өмнө эмнэлгийн практикт “хүний дархалын олдмол хомсдол” хэмээх өвчин анх бүртгэгдсэнээр хүн төрөлхтөний сэтгэл санаа, амь насанд халдан, улс орны эд баялагийг цөлмөн хороогч үршигт тахал нэгээр нэмэгджээ. Түүнээс хойш уг өвчинөөр 60 гаруй сая хүн өвчилж, улмаар дэлхийн хүн амын нас баралтын дөрөв дэх гол шалтгаан болоод байна. 2006 оны 11 сарын байдлаар ДЭМБ болон НҮБ-ын тооцоолсноор дэлхий дахинаа 37.2 сая насанд хүрэгчид, 2.3 сая хүүхдүүд энэ аюулт тахлын вирусыг тээж байна. Үүнээс эмэгтэйчүүд 17.7 сая халдварт тээгчид нь эмэгтэйчүүд ажээ. Энэ тоо нь 1991 онд ДЭМБ-ын дэвшүүлж байсан таамагалаас даруй хоёр дахин өссөн тоо ажээ. Зөвхөн 2006 онд 4.9 сая хүн шинээр ХДХВ-ийн халдвартыг авч, мөн 3.1 сая хүн түүний шууд үр дагавар болох ДОХ өвчинөөр хорвоог орхисон байна. Энэ аюулт вирусыг тээгчдийн тэн хагасаас илүү нь 25 нас хүрэхээс өмнө уг тахлын цалмандаа баригдаж, мөн төдий тооны хүмүүс 35 насныхаяа төрсөн өдрийн баяраа тэмдэглэж амжилгүй нас барж байна. Улмаар энэ тахал гинжин урвалаар тархаж, одоогоор 10 гаруй сая хүүхэд халдварт тээгч эцэг эхээсээ уг өвчнийг өвлөн авсан байна. Ийнхүү энэ тахлын тархалт жилээс жилд улам бүр залуужиж, энэ өвчний вирус тээж яваа нийт хүмүүсийн тэн хагас нь 15-24 насны хүүхэд залуучууд болоод байгаа бөгөөд тэдний тоо байнга өсөж, одоогоор өдөр тутам 6000 хүүхэд залуучууд уг халдвартын тархалтанд өртөж байна. Тухайлбал, уг өвчинд хамгийн их өртөөд байгаа Сахар орчмын Африкийн улс орнуудын хувьд нийт залуучуудын 3\2 нь буюу 6.2 сая залуучууд эл вирусыг тээж байгаа аж. Мөн Зүүн Европ болон Азийн бүс нутагт өсвөр насныхан, залуучуудын дунд энэхүү өвчний тархалт нэн хурдацтай өсөж байгааг олон улсын байгууллагууд сэргээж байна.

Энэ мэт тоо баримтуудыг бүс нутгаар, он сараар, үр дагавар, хор үршиг зэргээр нь олон янзын төрөл байдлаар тооцож, баримт цуглуулж, илэрхийлсээр байгаад магадгүй хүн бүрийн хувьд жирийн нэг статистик мэт дасал болж орхижээ.

ХДХВ\ДОХ өвчний тархалт нь нийгэм эдийн засгийн байдал, эрүүл мэндийн үйлчилгээний хүрэлшээ хангамж, ард түмний уламжлал, соёл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа боловч хөгжиж буй орнуудад хамгийн эрчимтэй дэлгэрч байгаа, хамгийн гол нь өсвөр үе, залуучууд, эмэгтэйчүүдийн хувьд нэн өртөмтгий, эрсдэлтэй бүлэг болоод байгаа нь аюулын харанга дэлдэж байна. Өөрөөр хэлбэл, нийт хүн амын 36.4% -ийг нь өсвөр насны хүүхэд залуучууд эзэлдэг, хүн амын дундаж нас нь 21 байгаа Монгол улсын хувьд энэ талаар зайлшгүй анхаарч ярилаах шаардлагатай болоод байна.

Ерөөс энэ талаар олонхи улс орны хувьд анхаарч буй нэгэн чухал асуудал бол энэ өвчинд хүүхэд залуучууд, өсвөр үеийнхэн хамгийн их эрсдэлтэй болоод байгаа явдал. Залуучуудын дунд дээрхи өвчин эрчимтэй дэлгэрч байгаад олон шалтгаан байгаа боловч хамгийн гол нь бэлгийн буруу зан үйл, хүмүүжил боловсрол хангалтгүй, үнэн зөв мэдээлэл дутагдалтай, аз сорих эрмэлзэл бүхий байдал хэмээн үздэг байна. Тухайлбал одоогоор олонхи залуучууд бага насандаа бэлгийн харилцаанд орж байгаа бөгөөд энэ нь дунджаар 15 нас болоод байгаа ажээ. Гэхдээ хамгийн гол нь бэлгийн замбараагүй амьдрал, олон хавьтагчтай байх, архи тамхи, мансууруулах бодис хэрэглэх зэрэг эрх чөлөөний гажууллууд нь уг тахалд өртөх гол үндэс суурь болдог ажээ. Үүний хамт хотжилтын үйл явц түргэссэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн буруу болдого, ядуурал зэрэг хүчин зүйлс нь өсвөр насныханы бэлгийн харилцааны талаархи буруу ойлголт, хандлагыг улам бүр өөгшүүлж байгаа нь үнэн билээ.

Энэ бүгдийн үрээр ДОХ-той өнөөгийн нийгэмд маш олон хүүхэд залуучуудын хүсэл мөрөөдөл талаар өнгөрч байгаа нь ихээхэн харамсалтай хэрэг билээ. Хүний эрхийн үзэл санаа, олон улсын хэм хэмжээ болон ХДХВ\ДОХ өвчний хооронд олон талт хамаарал, учир шалтгаан оршин байна. Эдгээрээс зөвхөн уг өвчинд өртсөнөөс учирч болох эрсдлүүд, мөн түүнээс сэргийлэх боломжийн талаархи асуудлыг бага зэрэг тодруулан үзье. ХДХВ хэмээх энэхүү вирусын тээгч болсоор тухайн хүн өөрийн бие махбодь, сэтгэл санааны хүндрэлээс гадна нийгмийн зүгээс үзүүлэх асар хүнд аюул занал, ялгаварлан гадуурхалтыг үүрэхэд хүрдэг байна. Тухайлбал, найз нөхөд, гэр бүлийнхэн болоод хамт ажиллагсдын зүгээс төрөл бүрийн ялгаварлан гадуурхах байдал,

чөлөөтэй нүүн суурьших, аялах, гэрлэх хийгээд гэр бүлээ хадгалан үлдэх, олон нийтийн үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох зэрэг эрх, эр чөлөө нь хязгаарлалтанд орж, нийгмийн зүгээс үл хүсүүштэй нэр, хаяг шошго зүүхэд хүрдэг байна. Тийм ч учраас ХДХВ\ДОХ өвчний тохиолдлуудтай хүний эрхэд тулгуурлан хандах талаар НҮБ, ДЭМБ болоод бусад байгууллага, хөдөлгөөнүүд уриалж байна. Тиймээс тухайн хүний амьд явах, хуулийн болоод нийгмийн бүхий л харилцаанд адиl тэгш хамгаалагдах, биеийн болоод сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах, хувийн нууцаа хадгалах, ажиллаж хөдөлмөрлөх, боловсролын үйл ажиллагаанд оролцох, төрөл бүрийн доромжлон харьцах, нэр төр гутаахаас хамгаалагдах зэрэг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үргийг төр олон улсын гэрээний эрх зүйн дагуу хүлээж байдаг. Үүнийг хэлэхийн гол утга нь уг өвчнийг тээгч хэн байсан ч бусадтай адиl хүн хэмээхээс илүү ийм байдлаар учирч болох аюул занал, биеийн болоод сэтгэлийн түгшүүрээс урьдчилан сэргийлэх, ухаантай хариуцлагатай байхыг өсвөр үеийхэндээ уриалж байгаа хэрэг билээ.

Өнөөдрийн энэ цаг үе нь хүн төрөлхтөний түүхэнд хүүхэд залуучуудын эзлэх хувь хэмжээ хамгийн их буюу 25-аас доош насны залуучууд дэлхийн нийт хүн амын тэн хагасыг бүрдүүлж байна хэмээн НҮБ-н Хүн амын Сангаас (UNFPA 2003) тооцоолжээ. Ийм учраас энэхүү өвчинтэй тэмцэх, эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээ нь энэ насны бүлгийнхний ойлголт хандлага, зан байдал, үйл ажиллагаанаас шууд шалтгаална хэмээх үзэл санаа түгэн дэлгэрч байна. Энэ чиглэлээр ч НҮБ болон түүний салбар байгууллагууд нэгдэн хүүхэд залуучуудтай ДОХ-той тэмцэх, түүнээс сэргийлэх талаар ажиллах болжээ.

НҮБ-ын хөтөлбөр, байгууллагуудын хамтарсан санаачлагын үр дүн болох UNAIDS хэмээх байгууллагаас 2002 онд зохион байгуулсан судалгаанд хамрагдсан 107 орноос 44 орны сургуулийн хөтөлбөр, сургалтанд нь ХДХВ\ДОХ-ын талаар ямар нэгэн сургалтын хөтөлбөр байхгүй байжээ. Мөн дээрхи судалгааны дүнгээс үзэхэд олонхи өсвөр үеийнхэн энэ өвчний талаар сонссон, зохих мэдээлэлтэй байдаг боловч түүнээс учирч болох аюул, эрсдэлийн тухай ойлголт хангалттай сайн биш, буруу төсөөлөл төдий байжээ. Иймээс ХДХВ\ДОХ-ын талаар дан ганц мэдээлэл өгөх нь хангалтгүй бөгөөд харин өсвөр үеийнхэн,

залуучуудын үйл байдлыг өөрчилж чадахуйц боловсролын цогц үйл ажиллагаа илүү үр дүнтэй болох нь харагдаж байна. Тухайлбал Хойд Америкт хэрэгжсэн 250 болон Африкийн орнууд дахь тусгай сургалтын хөтөлбөрүүдэд хамрагдсан залуучуудын дунд зохих эерэг үр дүн гарч, олонхи нь энэ талаар тодорхой мэдлэгтэй болж, өөрийгөө хамгаалах талаар санаа тавдаг болжээ.

Өнөөдрийн нийгэмд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр шарагдаж буй мэдээлэл залуучуудад хүчтэй нөлөө үзүүлж байна. Тиймээс олон оронд радио, телевиз, хэвлэлүүд ХДХВ\ДОХ-гоос урьдчилан сэргийлэх агуулга бүхий олон хөтөлбөрүүдийг тогтмол явуулдаг болжээ. Үүнээс тухайлбал ӨАБНУ-д хэрэгжиж байгаа “Амьдрал, хайр” хэмээх хөтөлбөр нь бэлгийн харицаанд орох байдлыг хойшлуулах, хариушлагатай байх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах зэрэг олон чиглэлээр бэлгийн боловсролыг мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран дамжуулж байгаа нь их үр дүнд хүрч байгааг онцолжээ. Энэ хөтөлбөрийн хүрээнд 900 орчим өсвөр үе, залуучуудын төвийг орон даяар ажиллуулж, залуучуудад сонирхолтой арга хэлбэрээр бэлгийн боловсрол олгож чадсан байна. Мөн MTV хэмээх олон улсын телевизийн сүлжээ UN-AIDS болон Дэлхийн банктай хамтран 171 орон 942 сая хэрэглэгчдээд хүрж чадсан кампанит ажлыг эхлүүлжээ. Энэ хөтөлбөрийн дагуу олон телевизийн хөтөлбөр, урлагийн тогтолтууд нь залуучуудад зөв ойлгоц, мэдлэг өгсөн байна. Судалгаануудаас үзэхэд боловсрол, сургалтын үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн кампанит ажилтай хослуулах нь их дүнтэй байдал байна.

Хүүхэд залуучууд ХДХВ-ын халдварт авах хамгийн эрсдэлтэй бүлэг боловч, тэдэнд энэхүү аймшигт тахлыг зогсоон хязгаарлах хүч, бололцоо байгаа гэдэгт хүн бүр итгэж байна. Харин эцэг эх, сургууль, нийгмийн зүгээс хүүхэд залуучуудад мэдлэг, боловсрол олгож, зөв төлөвшүүлж, дэмжин тусалж чадвал тэд өөрчлөлтийг хийж чадах юм.

Хүүхэд залуучуудад хандсан үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах санаачлагыг НҮБ-ээс санаачлан 2001 онд батлан хэрэгжүүлж эхэлжээ. Эл хөтөлбөр нь:

◆ ХДХВ-ын халдварт бүхий залуучууд, өсвөр үеийнхний эсрэг чиглэсэн бүх төрлийн ялгavarлан гадуурхах хэлбэрүүдийг устгахад чиглэсэн бодлого, хууль тогтоомж боловсруулах

- ◆ ΔΟХ болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаар зөв мэдээлэл, боловсролын үйлчилгээ авч чадахуйц орчин бүрдүүлэх
- ◆ Залуучуудад хариуцлагатай зөв сонголт хийх, аюулгүй орчныг бүрдүүлэхэд эцэг эх, багш нар, тэдний хүндэтгэн шүтдэг урлаг соёлын одод зэргийн оролцоог бий болгоход чиглэсэн сургалт, үйл ажиллагааг зохиох, тэдний дэмжлэг туслашааг авах
- ◆ Залуучуудад өөрчлөлтийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг ноогдуулах ба үүсгэл санаачлагыг нь дэмжин ажиллахад чиглэсэн цогц шинжтэй бодлого, үйл ажиллагаа байх ажээ.

Энэхүү зорилгод хүрэхийн тулд нийгмийн бүхий л байгууллаг, бүрэлдэхүүн хэсгүүд өөр өөрийн үйл ажиллагаа, санаа зорилгоороо нэгдэн ажиллах нь чухал юм. Тухайлбал бүх шатны боловсролын байгуулагууд нь сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан өсвөр насын хүүхэд залуучуудад хариуцлагатай, ухамсартай зан үйл, хандлага төлөвшүүлэх, шашин, спорт, урлагийн зэрэг залуучууд олноор ажилладаг байгууллагууд энэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, гэм хор уршгийг бууруулах чиглэлээр хамтран ажиллах бололцоог эрж хайх шаардлагатай байна.

Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ΔΟХ-ын өвчний шалтгаан, хор уршиг, түүнээс хамгаалах тухай мэдээллийг олон нийтэд тогтмол түгээж байх нь урьдчилан сэргийлэх боловсролын үйл ажиллагаа болох ба хувь хүн бүрийн оролцоо, ойлголтыг дээшлүүлэх ач холбогдолтой. Охид, эмэгтэйчүүдийн боловсролыг дээшлүүлэх, тэдний эрхийг хамгаалах, эрслээс сэргийлэх санаачлага, үйл ажиллагааг дэмжих нь чухал ба хөвгүүд, эрчүүдэд эмэгтэй хүнийг хүндэтгэх зан үйл, соёлыг төлөвшүүлэхэд анхаарах нь зүйтэй юм.

Эцэст нь хэлэхэд ХΔХВ\ΔΟХ-той тэмцэх үйлсэд дээрх бодлого, үйл ажиллагаануудыг төрийн ба төрийн бус байгууллагууд, эмнэлэг, сургууль, олон улсын байгууллагууд хэрэгжүүлж эхлээд байгаа нь сайшаалтайн зэрэгцээ хүн бүр өөрийгөө болон өөрийн хайртай хүмүүсээ хамгаалах хариуцлага, үүргээ ухамсарлаж байгаа гэдэгт бид найдаж байна.

--ooOoo--

II. Хүний эрхийн мэдлэгт:

Сэтгүүлийн 2-р хэсэг.

Сэтгүүлийн энэ дугаараас эхлэн хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон гадаад орнуудын төрийн бус байгууллагуудаас явуулж буй өргөн хүрээтэй үйл ажиллагаа, тактикийн талаар орчуулан хүргэж байна.

Бэлтгэсэн: С.Болд ХЭҮК-ын Олон талт хамтын ажиллагаа хариуцсан референт

Мэргэжлийн хууль зүйн про боно үйлчилгээ

(Эрх нь зөрчигдсөн хүмүүс болон ТББ-уудад мэргэжлийн хууль зүйн үйлчилгээг байнга үзүүлэх про боно³⁴ үйлчилгээг нэвтрүүлэх нь)

Тактик: Тойрог хэсэг бүрдүүлэх

Оролцооны хэлбэр: Сурталчлах

Байгууллага: Институто Про БONO

Тактикийг санаачилсан: Хууль зүйн орчин

Улс: Бразил

Хамраулах хүрээ: Хууль зүйн орчин

2001 оноос хойш Бразилийн Институто Про БONO хуульчид болон хуулийн пүүсүүдийг ашгийн бус байгуулага, боломж муутай хүмүүст үнэ төлбөргүй хуулийн үйлчилгээ үзүүлдэг болгохын төлөө ажилласаар ирсэн.

Бразилид хөрөнгөтний маш том давхарга байдаг ба энэ нь эрх зүйн тэгш бус тогтолцоо руу хөтөлдөг. Маш олон муж улсад нийгмийн хамгааллын газар байдаггүй ба тийм газар байгаа нөхцөлд л зөвхөн тодорхой түвшний ядуугийн зэрэглэлээ баталсан (үүний зэрэглэлийн шалгуур нь маш доогуур) хүмүүст үнэгүй тусlamж үзүүлдэг. Бразилийн Мэргэжлийн хуульчдын холбоо хуулийн пүүсүүдийн хуулийн үнэ төлбөргүй үйлчилгээг хууль бус бөгөөд ёс зүйгүй хэмээн үзсэн тул Бразилийн бусад ядуу иргэд хууль зүйн ямар ч туслалцаа авах боломжгүй хошорч байгаа юм.

³⁴ Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө. УБ., 2004

Хууль зүйн салбарын хэсэг хүмүүс нийлээд 2001 онд Бразилд про болонгийн хуулийн үйлчилгээг хэрхэн сайжруулах талаар семинар зохион байгуулсан. Лос Анжелосын Олон нийтэд хуулийн зөвлөгөө өгөх Төвийн ерөнхийлөгч Даниел Грүнфэлдийн дэмжлэг дээр тулгуурлан эдгээр бүлэг хүмүүс про боно үйл ажиллагааг хуульчлах, хуулийн ажилнуудыг ёс зүйтэй болгох, боломж мутай иргэдэл про болонгийн хуульчдын тусlamжийг хүргэх үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэхийн төлөө ажиллах байгууллагыг байгуулахын тулд төрөл бүрийн ажлуудыг хийсэн. Зорилтондоо хүрэхийн тулд тэрхүү жижиг бүлэг тэдэнд Бразилын хууль зүйн салбарын тэргүүлэх мэргэжлийн хуульчдын дэмжлэг хэрэгтэйг ойлгосон. Тиймээс тэд энэхүү үйл хэрэгтээ тэргүүний хуульчид, эрдэмтэн багш нарыг нэгдэхийг урьсан. Үүний үр дүнд 37 мэргэжлийн хуульчид Сан Паулуний Институто Про Боног байгуулахаар 2001 онд цугларан нэгдэцгээсэн.

Хуульчад итгэх итгэлийг бий болгох нь тэдний хамгийн анхны чухал алхам байв. Тэдний хийсэн өөр нэг алхам бол чухал мэдээлэл харилцаа, холбоогоор хангах АНУ-ын хуулийн пүүс, ашгийн бус байгууллагуудтай холбоо тогтоох явдал байсан. Гэхдээ тэдний хувьд Сан Паулогийн мэргэжлийн хуульчдын холбооны (тэд про болонгийн үйл ажиллагааг хууль бус гэж үзэж байсан) дэмжлэгийг авах явдал нь эн тэргүүний зорилт байлаа. Сан Паологийн Улсын Мэргэжлийн хуульчдын холбоо про боно ажлын хэсгийг зохион байгуулж, түүнд нь ИПБ-гийн зөвлөлийн гишүүд болон Ёс зүй, Сахилга журмын шүүхийн гишүүд орсон байна. Улсдаа нэлээд томоохонд тооцогдох хэсэг хуулийн пүүсүүд, хэд хэдэн нэртэй шүүгчилтэй нэгдсэнийхээ дараа тэд Холбооноос про болонгийн үйлчилгээг зохицуулахыг шаардаж эхэлсэн. Хэд хэдэн удаагийн уулзалт, нухацтай хэлэлцүүлгийн эцэст мужийн мэргэжлийн хуульчдын холбоо про болонгийн тухай тогтоол гаргаж Сан Пауло мужид про болонгийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн.

Хуульчлах ажлын дараа хийгдсэн дараагийн алхамаараа тэд үйл хэргээ олон нийтэд сурталчилж, хуульчад хэрхэн сайн дураараа ажиллах, ТББ-үүд энэ үйл ажиллагаанаас ямар ашиг хүртэж болох талаар мэдээлэл өгсөн. Энэхүү ажлын хүрээнд (www.probono.org.br) хэмээх веб хуудастай болж, эндээс хүмүүс про боно ажлын талаар мэдээлэл авч, хуульчид сайн дураар ажиллах анкет бөглөх боломжтой болсон байна

Веб хуудаснаас гадна интернэтээр дамжуулан про боногийн агуулга, үзэл санааг аль болох өргөн дэлгэрүүлэхийг хичээсэн. Мөн тэд хуулийн пүүсүүдийг про боногийн үндсэн бодлогыг авч хэрэгжүүлэхийг ятгахдаа хэд хэдэн үндэслэл гаргажээ. Амжилттай ашигласан нэг үндэслэл нь хуулийн пүүсүүдэд эдийн засгийн давуу талыг таниулж чадсан ба про боногийн ажил нь нэгдүгээрт, хуульчдын ажилдаа сэтгэл хангалийн байх боломжийг нэмэгдүүлж, тэгснээрээ тэдний хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэн байна. Хоёрдугаарт, про боногийн ажлыг гүйштгэснээр боломжийн үйлчлүүлэгчдийнхээ өмнө өөрсдийн тухай эерэг төсөөллийг бий болгох боломжтой. Томоохон пүүсүүдийн дэмжлэгийг авсныхаа дараа ИПБ үүнийгээ бусад пүүсүүдэд нөлөөлөхөд ашигласан.

Аливаа хурал, семинар нь сайн дурын үйл ажиллагааны уламжлал төдийлөн байхгүй Бразил зэрэг оронд про боногийн үзэл санааг дэлгэрүүлэх үндсэн суурь болж өгдөг. 2003 оны 12 дугаар сарын 4,5-нд ИПБ гурав дахь олон улсын про боно семинарыг зохион байгуулсан. Про боногийн үйл хэргийн талаар хууль зүйн салбарынхны дунд ерөнхий нэгдсэн зөвшилцэлд хүргэхийн тулд тэд (олон улсын болоод дотоодын) бага хуралд дэмжлэг үзүүлэх итгэл хүлээсэн хүмүүсийн сүлжээг бий болгож, дотоодын хуулийн пүүсүүдээ про боногийн үйл хэргийг сайн ойлгож дэмждэг гадаадын зочидтой холбоо тогтоох боломжийг олгож, мөн үүний талаарх ойлголт, мөн чанарын талаарх хичээл явуулсан. Бразилд про боногийн семинар явуулснаар нэлээд ач холбогдол бүхий үр дүн гарч, нэгдэх сайн дурын хуульчид, хуулийн пүүсүүдийн тоо нэмэгдэж, мөн про боногийн үйл ажиллагааны үр нөлөө дээшилсэн. Түүнчлэн уг семинарын үр дүн Улсын мэргэжлийн хуульчдын холбоо орон даяар про боногийн үйлчилгээ явуулахад хориглолт болж буй хууль тогтоомжийн хязгаарлалтыг багасгахаар ажиллах болсон.

Бразилд ИПБ-гийн үйл ажиллагаа сайн дурынхны үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлээд зогсохгүй хууль зүйн мэргэжилтнүүдийн дунд шинэ хандлага, шинэ ёс зүйг хэвшигүүлэх тал дээр тун амжилттай явж байна. Энэ байгууллагынхны үзэж байгаагаар хэрэв хэн нэгэн ИПБ-той адил төстэй байгууллага байгуулахыг зорж байгаа бол хэрхэн про боногийн хууль зүйн үйл ажиллагаагаар нийгмийн шудрага ёсны байдалд нөлөөлөх болон хууль зүйн нийгэм дэх үүрэг хариуслага, сайн дурын үйл ажиллагааны суурь ёс зүйг хэрхэн онцгойлон тодорхойлох талаар сайтар хэлэлцэх шаардлагатай.

Хүний эрхэд нөлөөлж буй бизнесийн нөлөөллийн үнэлгээний хэрэгслийг зохиох нь

Тактик: Аудит

Оролцооны хэлбэр: Сурталчлах

Байгууллага: Данийн Хүний Эрхийн Институт

Тактикийг санаачилсан: Иргэний нийгэм

Улс: Дани

Хамруулах хүрээ: Бизнес

Данийн Хүний Эрхийн Институт - (ДХЭИ) нь Хүний Эрхийн Баримтлах Үнэлгээг (ХЭБҮ) боловсруулсан ба үүна бизнесийн үйл ажиллагааны улмаас хүмүүст, тэр тусмаа өөрийн ажилчид болон орон нутгийн иргэдэл нөлөөлсөн нөлөөг тогтооход анхаарах тодорхой болон бодит хүчин зүйлийн жагсаалтыг оруулсан байна. ХЭБҮ-ний зорилго нь компаниудыг практик үйл ажиллагаанд хөндлөнгийн шалгалт хийх хэрэгслээр хангах, зөрчил гарч болзошгүй газруудыг тогтоож хянах, одоо байгаа зөрчлийг арилгаж, ирээдүйд дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх явдал болно.

Сүүлийн 50 гаруй жилд компаниуд өөрсдийн үйл ажиллагаагаа хил дамнан тэлж, эрчимтэйгээр өргөжүүлж, удирдах төвөө хилийн чанадад байгуулах явдал нэмэгдэж байна. Энэ нь тэд өөрсдийн бүтээгдэхүүнээ хэд хэдэн улсын зах зээл дээр борлуулж болох ба тэдгээр бүтээгдэхүүн нь магадгүй хэдэн мянган милийн тэртээх өөр нэг улсад үйлдвэрлэгдсэн байж болно гэсэн үг юм. Дэлхийн хатуу ширүүн өрсөлдөөнт зах зээл дээр үлдэхийн тулд тэдний өдөр тутмын бизнесийн үйл ажиллагаа нь өөрийн ажилчдын болон орон нутгийнхны хэрэгцээнээс илүү нийт худалдан авагчдынхаа эдийн засгийн шаардлагыг хангахад чиглэгддэг. Тиймээс тэдэнд цогц тогтолцоона хэрэгжүүлэхэд хангалттай сайн атлаа хүний эрхийн асуудлаар огт туршлагагүй менежер ч хэрэглэж болохуйц хангалттай энгийн механизм хэрэгтэй. Төрөөс гадна өөр хэн хариуцлага хүлээх вэ гэдгийг энгийнээр тогтоох нь бизнесийнхний өмнө тулгарч байгаа нэг асуудал мөн. Төр хүний эрхийг нийгэмд хамгаалж, дээдэлж, ханган баталгаажуулах үүрэг хүлээнэ. Нөгөө талаас бизнес нь улс төр биш учраас тэдний хүний эрхийн тал дээр хүлээх хариуцлага нь тэдний бизнесийн үйл ажиллагааны цар хүрээгээр хязгаарлагдана. Ажилтны, нийгмийн болон улстөрийн гэсэн үндсэн гурван эрх хөндөгдөх үед бизнесийн харилцаа хүний эрхийн асуудалтай холбогдоно.

Хүний Эрхийн Баримтлах Үнэлгээ нь Орчны Нөлөөллийн Үнэлгээний загвар дээр үндэслэгдсэн ба 1999 онд Хүний Эрх болон Бизнес Төсөл боловсруулагдсанаас хойш хэрэгжсээр ирсэн. Энэ нь компаниудын хувьд анхны бүрэн хэмжээний хүний эрхийн нөлөөллийн үнэлгээ болсон ба тэдгээрийн үйл ажиллагаа тухайн нутгийн ард иргэд болон өөрсдийнх нь ажилчдын эрхэд хэрхэн нөлөөлж байгааг тогтооход нь компаниудад туслах зорилготой юм. Энэхүү үнэлгээний хэрэгсэл нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1966 оны Хоёр Талын Хамтарсан Гэрээ, ОУХЗБ-ын Суурь Конвенц зэргээс үндэслэн гаргасан 300 гаруй асуулт, 1000 гаруй хүний эрхийн үзүүлэлтүүдийг багтаасан мэдээллийн сан дээр тулгуурладаг.

Дэлхийн янз бүрийн ороод үйл ажиллагаагаа явуулдаг аж үйлдвэрийн салбарыг төлөөлсөн Данийн арван компани уг үнэлгээний хэрэгслийг сайжруулах судалгааны ажилд сайн дураараа нэгдсэн. Хилийн чанад дахь улс төр, нийгэм, эдийн засгийн янз бүрийн орчинд бизнесийнхний өмнө тулгардаг хүний эрхийн асуудлуудыг тодруулж шийдвэрлэх үүднээс ДХЭИ дээрх компаниудтай тус бүрд нь хэд хэдэн удаа яриллага хийсэн. Данийн Бизнес Нийгэмаэг бусад бизнес нийгэмлэгүүдийн адил аар туйлын ялаатай. Тиймээс өөр нэг оролдлого нь ердийн бизнесийн бүтцэл тохирсон хүний эрхийн хэрэгслийг бий болгох явдал байсан. Тухайлбал тухайн нутгийн хэдхэн ажилчнитай хувцасны жижиг компани тэр цөөхөн ажилчдынхаа эрхийн асуудал дээр маш их анхаарал тавьдаг. Засгийн газартай хамтарсан, эсвэл хөрөнгө оруулсан бизнесийн холбоод болон компаниуд илүү өргөн хүрээтэй улс төр, нийгмийн эрхийн асуудлууд болон тэдний үйл ажиллагаа нутгийн ард иргэдэл хэрхэн нөлөөлж болох тал дээр анхаарч ажиллах болно.

Эхний туршилтад хамрагдсан компаниуд тэр даруйдаа хүний эрхийн асуудлын цар хүрээг ойлгож, тэдний бодлого, арга хэмжээнүүд нь олон улсын хууль тогтоомжтой зөрчилдөж байсныг мэдэж авсан. Тэд хүний эрхийн асуудал “бүх зүйл хүний төлөө” гэсэн ташаа гарчгийн дор явж байгаа нь буруу ойлголт юм гэдгийг ойлгосондоо нэлээд талархалтай байсан.

Түүний дараа ДХЭИ компани болон ТББ-уудад тухайн хэрэгслийн талаар бяцхан зөвлөгөөн зохиож, уг хэрэгслийг тайван байдлаар таних боломжийг бүрдүүлж өгсөн.

Хүн наймаалахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хилийн цагдаатай хамтарч ажиллах

Тактик Олонулсын болон орон нутгийн байгууллагуудыг оролцуулах

Оролцооны хэлбэр: Урьдчилан сэргийлэх

Байгууллага Майти, Балба

Тактикийг санаачилсан: Иргэний нийгэм

Улс Балба

Хамруулах сектор: Нийгэм

Балбын Майти байгууллага нь наймаалаагдсан охид, эмэгтэйчүүдийг замд нь аврах ажиллагааг сайжруулах талаар Засгийн газартай нягт хамтран ажиллах байна. Хилээр гарч байх үеэр тэднийг дагалдан яваа хүмүүсийг цагдаа шалгаж байхад Майти-гийн ажилтнууд охид, эмэгтэйчүүдтэй уулзаж ярилцах байдлаар хилийн цагдаа наарт тусалж ажилладаг. Ийнхүү Майти нь өөрийн оролцооны явцад наймаалагдсан охид, эмэгтэйчүүдэд хоргodoх байр болон бусад үйлчилгээ үзүүлэх үүднээс Балба, Энэтхэгийн хилийн дагуу дайран өнгөрөх гэр майхангаар үйл ажиллагаа явуулдаг байна. Майти-гийн энэ үйл ажиллагаа нь зөвхөн хүн наймаалах гэмт хэргийн золиос болсон хэдэн мянган хүнийг аварснаар хязгаарлагдахгүй. Энэхүү тактик нь хүн наймаалагчдын эсрэг байцаан шийтгэх (шүүн таслах) ажиллагааг явуулж, гэмт хэрэгтнүүдийн эсрэг арга хэмжээ авах талаар орон нутгийн удирдлагад шахалт үзүүлсэн ихээхэн үр дүнтэй ажиллагаа болсон байна.

Хүн наймаалах нь Балбын хувьд маш ноцтой асуудал болоод байна. Майти-гийн гаргасан судалгаагаар өнөөдөр хүчээр хил гарган наймаалсны уршгаар 200.000 балба охид Энэтхэгт биеэ үнэлэн амьдарч байна. Энэтхэгийн болон олон улсын зах дээрх биеэ үнэлэгчдийн эрэлт хэрэгшиээ ихсэхийн хирээр охид наймаалах ажиллагаа Балбад ил цэцэглэж байна. Эмэгтэйчүүдийн өдөр тутмын сонинд дурьдсанаар жилд дунджаар 5-7 мянган балба охид, эмэгтэйчүүд Энэтхэгийн шөнийн цэнгээний газруудад хүчинд автан бие үнэлэн амьдарч байна. Нийтдээ 150 мянган балба эмэгтэйчүүд хүн наймаалагчдад өртсөн гэсэн тооцоог гаргажээ.

1993 оны 11-р сард багш, сэтгүүлчид болон нийгмийн ажилтнууд нэгдэн охид наймаалахтай тэмцэх зорилготой нэгдсэнээр Майти-ийн үйл ажиллагаа эхэлсэн түүхтэй. Хүн наймаалахтай тэмцэх нэг гол арга нь наймаалагчыг хилээр гаргахгүй байх талаар урьдчилан сэргийлэх ажил юм. Заримдаа хилийн цагдаа нар хохирогсдыг таньдаг боловч гэмт этгээдүүдийг баривчилж чадлаггүй. Нөгөө талаар авлигад өртсөн албан тушаалтнууд сэжиг бүхий ажиллагаа байсаар байхад нүдээ аниад өнгөрдөг. Майти хүн наймаалахтай тэмцэх өөрийн эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд Засгийн газрыг нөлөө бүхий (маш чухал) түншээ гэж үзэж хүн наймаалахаас урьдчилан сэргийлэх хилийн ажиллагаанд нягт хамтарч ажилладаг байна. Засгийн газрын зүгээс Майти-д хилийн цагдаатай хамтарч ажиллах зөвшөөрөл олгосон байна. Майти хохирогсодтой ярилцахын тулд туршлага, мэдрэмж бүхий ажилтнуудыг (өмнө нь наймаалагдаж байсан эсвэл хил давж байхдаа аврагдсан) уг ажиллагаанд оролцуулсан.

Хилийн ажиллагааны баг нь хилийн цагдаа болон Майти-гийн ажилтнуудаас бүрддэг бөгөөд тэд Балбын хил дагуух болон ядуу районуудаар явж сэжиг бүхий этгээдүүдтэй тулж ажилладаг байна. Тэд зөрөн өнгөрч буй машин бүрийг зогсоож, нэгжлэн явуулахын зэрэгцээ охид, эмэгтэйчүүдтэй хамт эрчүүд явж байгаа тохиолдолд тэдгээр эрэгтэйчүүдэд цагдаа тусгайлан ажиллагаа (асуулж, шалгаах г.м.) явуулж байхад Майти-ийн хүмүүс эмэгтэйчүүдтэй нь уулзаж ярилцана. Яриллагын үеэр “Та яагаад Энэтхэг рүү явж байгаа вэ?”, “Та энэ хүнийг хир сайн мэдэх вэ?” зэрэг асуултуудыг тавьдаг. Яриллагын үеэр ажилтнууд маш анхааралтай ажиглалт хийж байсан. Тухайлбал, тэдний ярьсан зүйл болит байдалтай нийшэхгүй байх, мөн сонин дохио зангаа, хувцаслалт, будаг шунх зэргийг анхааралтай ажигладаг байв. Яриллага авагсад Энэтхэг дэх биен үнэлэх байдлын талаар тэдгээр эмэгтэйчүүдэд маш сайн ярьж, ойлгуулдаг байна.

Тэдний ярьсан зүйл нь болит байдалтай нийшэхгүй байвал эмэгтэйчүүдийг нь тусгаарлан наймаалагчдыг цагдаа нар баривчилдаг. Майти-ийн ажилтнууд тэдгээр эмэгтэйчүүдийг дамжин өнгөрөөх байранд богино хугацаагаар байлгаж хооллож, зөвлөгөө өгөн сайн дурын эмнэлгийн үзлэгээр оруулдаг. Майти тэдний аав, ээжтэй нь холбоо барьж тосгон руугаа ямар ч саалгүй бушаж явахад нь тусалдаг

бөгөөд замын заралыг санхүүжүүлэхийн зэрэгшээ шаардлагатай нөхцөллөө өөрсдөө дагалдан явж хүргэж өгдөг байна. Хэрэв тэдний аав, ээж, хамаатан садан нь тэднийг буцааж авахыг хүсэхгүй байгаа тохиолдолд эсвэл тэд хүн наймаалахад тодорхой үүрэг гүйшэтгэсэн нөхцөл Майти тэдэнд зөвлөгөө өгөх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ санхүүгийн хувьд бие даасан, тогтвортой байхад нь туслах зорилгоор сургалт явуулдаг. Тухайлбал, мөөг тарих, цэвэрлэгжүүлэх, бамбуу модоор элдэв зүйл хийх, хоол хийх, оёх, хатгах, нэхэх зэрэг орлого олох, бий болгоход чиглэсэн сургалт явуулдаг байна.

Охид, бүсгүйчүүдийг дамжин өнгөрөх байранд байхад нь байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар хэрэг үүсгэхийн тулд гэмт хэрэгтнүүдийг таних, тогтооход туслашaa авахаар ажиллаж байна. Майти мөн бүртгэл хөтлөх, бусад ижил төрлийн байгууллагуудтай холбоо (сүлжээ) тогтоох зорилгоор хүн наймаалаагчдын талаарх мэдээ, мэдээллийг идэвхитэй цуглуулдаг байна. Ийнхүү цуглуулсан мэдээллээ орон нутгийн удирдлагад өгч хүн наймаалаагчдын эсрэг шийдвэртэй алхам хийхийг тэднээс шаарддаг.

Энэ тактикийг төрөл бүрийн нөхцөллөх хэрэглэхийн тулд Засгийн газартай нягт хамтарч ажиллах, хилийн цагдаа зэрэг байгууллагуудтай ойр хамтарч ажиллах боломжтой байх шаардлагатай юм. Түүнчлэн хохирогсод дэмжлэг туслашaa үзүүлэх, зөвлөгөө өгөхөөс гадна тухайн орон нутагтаа эргэж очих, хүн наймаалах хэргийн шалтгааныг тогтоох ажиллагаанд тэднийг татан оруулах, энэ талаар дэмжиж ажиллах нь маш чухал юм.

Хөдөө орон нутаг дахь хуулийн боловсрол: Хүний эрхийн талаар хөдөө орон нутгийн хүмүүст сургалт явуулах ба өөрсдийн эрхээ хамгаалахад нь туслах үүднээс хуульчилтай холбож өгөх

Газарзүйн байрлалын хувьд алслагдсан, соёл, ёс заншлын хувьд онцлог, мэдлэг боловсрол дулимаг байгаа нь орон нутгийн хүмүүст өөрсдийн эрхээ эдлэх бүрэн боломж (давуу тал)-ийг хязгаарлаж байгаа гол саад бэрхшээл болж байна. Тайландад хэсэг хүмүүс орон нутгийн боловсролыг сургалт семинар болон урлагийн зарим хэлбэр (жны: хошин шогийн тогтолцот Г.М.)-ийг ашиглан хуулийн тогтолцоог нээлттэй

/хүртээмжтэй/ болгох ажиллагаатай хослуулснаар хүмүүс өөрсдийн эрхийнхээ талаар мэдээд зогсохгүй хүний эрхийн зөрчлийн талаарх өргөдөл гомдоо идэвхитэй тавьдаг болох нөхцлийг хангаж өгсөн байна.

Тонгбай Тонгпao сан (TTC) хөдөөгийн оршин суугчад хуулийн туслацаа үнэгүй үзүүлэхийн зэрэгшээ хүний суурь эрх болон хүмүүсийн өдөр тутмын амьдралыг хөндөж байдаг хууль тогтоомжийн талаарх сургалтыг зохион байгуулсан байна. Тайланд улс 90-ээд онд эдийн засгийн өсөлт маш хурдацтай байсан бөгөөд үүний үр дүнд ихэнхдээ хотуудад амьдралын түвшин эрс дээшилсэн байна. Харин хөдөө тосгодын оршин суугчид эдийн засгийн хөгжлөөс хошорч орчин үеийн Тайландын хуулиар баталгаажуулсан өөрсдийн эрхийн талаар өчүүхэн төдий ойлголт мэдлэгтэй байв. Энэ нь тэднийг авлига, хээл хахуульд идэгдсэн албан тушаалтнууд, мөнгө хүүлэгчийн мөлжлөгөд эмзэг, шүүмжлэлтэй хандахад хүргэсэн байна.

Тус сан нь багш нар, оюутнууд, орон нутгийн бүлгийн удирдагчид, ядуу тариачид, эмэгтэйчүүдэд сургалт явуулдаг. Сангийн ажилтнууд болон сайн дурын хуульчид амралтын өдрүүдээр тосгодод сургалт, семинар зохион байгуулдаг бөгөөд ихэвчлэн төрийн албан хаагчид, албан тушаалтнуудтай холбоотой асуудалтай тулгарсан тосгодын оршин суугчдын хүсэлтээр очиж сургалт явуулдаг. 2 хоногийн сургалтаар оролцогсод үндсэн хууль, хүний эрх, гэр бүл, зээл, хөдөлмөрийн хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн талаар мэдэж авдаг. Шүүхээр хэрэг шийдвэрлэж байгааг жүжигчлэн үзүүлэх нь дээрх лекцii, яриа хэлэлцүүлгийн нэг бүрдэл хэсэг болдог байна.

Сургалт дууссаны дараа оролцогсод өөрсдийнх нь хувийн хуульч (өмгөөлөгч)-ийн нэр, гарын үсэг бүхий фото картыг тараадаг. Карт болгоны ар талд сэжигтний эрх тухайлбал, дуугүй байх, өмгөөлөгч авах (эрх зүйн туслашaa), ямар хэрэгт сэжиглэгдэж буйгаа мэдэх болон барьцаагаар суллагдах зэрэг эрхийн жагсаалт байна. Хөтөлбөр дууссаны дараа 5-7 хүний бүрэлдэхүүнтэй орон нутгийн хуулийн хороог тосгодод байгуулах бөгөөд энэ хороо нь хүний эрхийн хэм хэмжээг хэрэгжүүлэх ажлыг хангах, сургалт явуулахад туслах зэрэг ажлыг зохион байгуулдаг.

Сангийхан зайн сургалт, ерөнхий үзэл баримтлааас илүү тосгонохонд практик мэдээлэл өгөх, ур чадварт сургахыг чухалчилдаг бөгөөд үүний үр дүн тэд өөрсдийн эрхээ хамгаалах чадвартай болдог. Дээр дурьдсан картын боломж (эрх мэдэл)-ийг дутуу үнэлж болохгүй. Өөрөөр хэлбэл зүйл бусаар харьсан тохиолдолд хэн нэгэн хүн рүү утасдах нь зөвхөн сэтгэл зүйн хувьд дэм өгч буй төдийгүй эрх зөрчигдөхөөс хэн нэгнийг урьдчилан сэргийлэх хэрэгсэл болдог гэдгийг ойлгож мэдэх нь чухал юм.

Энэ тактик нь өөрсдийн эрхийн талаар ойлголт мэдлэг байхгүй, шүүхийн үйл ажиллагаа хүртээмжтэй биш дэлхийн аль ч алслагдал, хөдөө орон нутагт маш ач холбогдолтой (үнэ цэнэтэй) байна. Түүнчлэн зүйл бус харьсан тохиолдолд хохирогсын төлөө боломжит аргын нэг болсон хуулийн арга хэмжээ авах боломжийг олгож байгаа юм. Иймэрхүү тактикийг Угандын алслагдамал нутгийн хүмүүст өөрсдийн эрхийн нь талаар ойлголт, мэдлэг олгох, эвлэрүүлэх ажиллагааны орон зайл бий болгоход ашигласан нь үр дүнтэй болсон байна.

ХЭБҮ-ний хэрэгслийн гол зорилт нь бизнесийн үйл ажиллагааны явцад ажилчид, нутгийн оршин суугчид болоод бусад хүмүүсийн эрхийг зөрчихгүй байх талаар бодит мэдээллээр хангаж компанийн нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх явдал юм. Бэлтгэл шатанд бизнесийн орчинд “эмзэг бүлгүүдийг” бүрэн хамгаалах ХЭБҮ-ний стандартыг баталгаажуулахын тулд тэдгээрийг судлах ажлыг хийсэн. Компани болон хүний эрхийн төлөөлөгчдийг сонгон авч хосоор нь дүгнэлтийн багуудад хуваарилсан. Баг бүрт нэг эрх өгсөн ба оролцогчид эхлээд аливаа санал болгож оруулж ирсэн нэмэлт өөрлөлтийн талаар хэлэлцэхээсээ өмнө дор бүрнээ өөрсдөө асуудлаа дүгнэнэ. Хүний эрх болон бизнесийн төслийн нэг төлөөлөгч оролцогчдын дэвшүүлсэн зүйлийг дүгнэх, яриа хэлэлцээ өрнүүлэхэд туслах, санал болгосон өөрчлөлтүүдийг тэмдэглэн авах, аливаа асуултад хариулт өгөх үүрэг хүлээнэ. Дараагийн шатанд хүний эрх болон бизнесийн төлөөлөгчдөөс бүрдсэн санал зөрөлдөөн, маргааныг шийдвэрлэх комиссыг бүрдүүлнэ.

Гуравдах буюу эцсийн шатанд аливаа компани болон бусад байгууллагуудад өөрсдийн бизнесийн хэлбэр, үйл ажиллагааныхаа цар хүрээнд тохирсон мэдээллээ сонгон авч ашиглахад нь зориулан бүтээсэн ХЭБҮ-ний интернетэд сууринсан компьютерийн программа

хэлэлцэж шийдсэн зүйлсийнхээ үр дүнг оруулна. Энэ мэдээллийн дагуу дээрх программ стандарттай зөрчилдэж байгаа хэсгийг тодорхой зааж харуулна.

Энэхүү хэрэгсэл нь компани болон байгууллагуудад олон улсын хүний эрхийн хуулийг ойлгуулахад тус нэмэр болох зорилготой бүтээгдсэн ба янз бүрийн соёл, ээдрээтэй хууль зүйн орчинд хүний эрхийн асуудалд толгой нь эргэлгүй хандахад нь тусална. Цаашилбал энэ нь тодорхой нийгэмд тогтсон янз бүрийн дүрэм журам болоод ёс заншлаар дамжуулан уян хатан байх чадвартай.

ХЭБҮ-г 2001 оны намар 9, 10 дугаар сард Шелл Өмнөд Африкт туршиж үзсэн ба 2001 оны Шеллийн тайланд энэхүү эхний туршилтын талаар орсон. Хоёрдахь туршилт Шелл Оманд явагдаж байгаа ба одоо бараг дуусч байгаа. Одоогийн байдлаар ихэнх нь Европын Холбооны улсад байрладаг 200 гаруй компани хүний эрхийн зорилтод нийцүүлэн өөрсдийн удирдлагын арга барилаа өөрчлөх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн.

Хүний эрхийн интернет лавлагаа:

Бэлтгэсэн Ч.Алтангэрэл ХЭҮК-ын боловсрол хариуссан референт

Хүний эрх сэтгүүл нь энэ удаагийн дугаараас эхлэн хүний эрхийн асуудал холбогдох веб хуудсуудыг цуврал байдлаар танилцуулхаар бэлтгэлээ. Мэдээлэл харилцааны эрин үед хүмүүсийн мэдээлэл эрж хайх, хүлээн авах, судалгаа шинжилгээ хийх зэрэгт интернет хуудсууд улам бүр шийдвэрлэх ач холбогдолтой болсоор байгаа билээ.

Тухайлбал, интернет орчинд ажилладаг онлайн хэлбэрийн асар том номын сангүүд байна. Эдгээр нь хүний эрхийн олон улсын гэрээ конвенци, хууль эрх зүйн баримт бичгүүд, судалгааны тайлан, өгүүлэл, холбогдох чиглэлээр ажиллаж буй байгууллага зэргийн тухай иж бүрэн цогц мэдээллүүдийг нэгэн зэрэг олон хэлээр ашиглах боломж олгодог. Интернет дэх хүний эрхийн мэдээллийн өөр нэгэн төрөлжүүлэлт бол улс орон тус бүрээр хүний эрхийн төлөв байдал, судалгааны тайлан, олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хянан шалгах хороодод гаргаж буй илтгэлүүд, тэлгээрээс авсан санал зөвлөмж зэргийн цогц юм. Олон улсын болон үндэсний хүний эрхийн байгууллага, хүрээлэнгүүд өөрсдийн дүгнэлт, тайлан зэргээ ихэвчлэн онлайн хэлбэрээр нийлүүлэх сонирхолтой байдаг. Тиймээс ялангуяа хүний эрхийн зөрчил, аливаа хүчирхийлийн талаар маш хурдтайгаар мэдээлэл хүлээн авах, улс орны тодорхой эрхийн нөхцөл байдлыг мэдэх зэрэгт эдгээр сайтууд нь ихээхэн чухал ач холбогдолтой байдаг.

Хүний эрхийн мэдээллийн салбар дахь өөр нэгэн хувилбар нь хүний эрхэд холбогдох тодорхой асуудлуудаар дагнасан веб хуудсуудыг бүтээж, олон нийтийн хүртээл болгож байдаг. Ялангуяа НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, эмэгтэйчүүд, хүүхэд, дүрвэгсэд зэрэг нийгмийн тодорхой бүлгүүдийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд зэрэг нь энэ чиглэд ихээхэн үр бүтээлтэй ажилладаг. Мөн үүнээс гадна иргэний ба улс төрийн эрх, эрх чөлөө, эдийн засаг, нийгэм соёлын эрх, цаазаар авах ял, хөгжих эрх зэргийн талаар төрөлжсөн сайтууд мөн олноор бий болсон.

Эдгээрээс гадна хүний эрхийн онлайн сэтгүүлүүд, хүний эрхийн шахим сүлжээнүүд, мэдээллийн хуудас зэрэг маш өргөн хүрээт мэдээллийн эх үүсвэрүүд байдаг. Гэвч хүний эрхэд холбогдох мэдээллийн бааз суурь интернетийн орчинд улам бүр өргөжин гүнзгийрч байгаатай холбоотойгоор тэдгээрийг хайж олох, ашиглахад тодорхой бэрхшээлүүдийг үүсгэж байна.

Иймээс та бүхний хүний эрхийн тухай өөрийн мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх, хүний эрхэд холбогдох олон улсын гэрээ конвенци, хууль эрх зүйн баримт бичгүүдтэй танилцах, судалгааны ажил гүйцэтгэхэд тус дөхөм болно хэмээн зарим интернет хуудсуудыг толилуулж байна. Сэтгүүлийн дараагийн дугааруудад хүний эрхэд холбогдох зарим үр дүнтэй веб хуудсыг үргэлжлүүлэн танилцуулах болно.

A. Ерөнхий веб хуудсууд:

Хүний эрхэд холбогдох бүх талын мэдээллийг агуулсан веб хуудсууд олон байдаг. Эдгээрээс төлөөлүүлэн авч үзвэл:

Миннесотагийн Их Сургуулийн Хүний эрхийн төвийн Номын сан:

Minnesota Human Rights Library

<http://www.umn.edu/humanrts/>

АНУ, Миннесотагийн Хүний эрхийн төвийн энэхүү веб хуудас нь интернет дэх анхны томоохон онлайн номын сан билээ. Энэ электрон номын сан нэгэн зэрэг англи, орос, хятад, араб, испани зэрэг 6 хэлээр хүний эрхийн олон улсын гэрээ, тунхаглал, баримт бичгүүд, олон улсын, бус нутгийн байгууллага, шүүхийн шийдвэр тогтоолууд, тэдгээрт холбогдох бусад санал хүсэлт материалуудыг агуулсан хамгийн баялаг мэдээлэлтэй. Мөн энэхүү сайт нь хүний эрхийн боловсролын чиглэлээр маш арвин баялаг нөөцийг агуулдаг. Үүнд, хүний эрхийн сургалтын хөтөлбөр, сургалтын материалууд, судалгааны дүгнэлт, тайлан материалууд зэргийг агуулдаг. Түлхүүр үгүүдээр сайт дотроос мэдээлэл хайх боломжтой. Мэдээлүүд өдөр тутам шинэчлэгдэн баяжиж байдаг.

Хүний Эрхийн Интернет:

-Human Rights Internet

<http://www.hri.ca>

“Human Rights Internet” бол хүний эрхийн олон улсын баримт бичгийн болоод хэвлэлийн ордон хэмээн алдаршсан олон улсын төрийн бус байгууллага юм. Харьцангуй сүүлд байгуулагдсан боловч хүний эрхийн судлаач, мэргэжилтнүүд болон ТББ-үүдын хувьд хамгийн чухал сайтуудын нэг болж чадсан. Үүнд хүний гол онцлог нь хүний эрхийн ажлын байрны зар мэдээлэл, хурал чуулганы календар, хүний эрхийн сургалтын хөтөлбөр зэргийг агуулсан мэдээллийн томоохон сан юм. Мөн түлхүүр үгүүдээр сайт дотроос мэдээлэл хайх боломжтой.

Дерочос Хүний Эрх:

-Derechos Human Rights

<http://www.derechos.org/>

Энэ сайт нь хүний эрхийн баримт бичгүүд, судалгааны тайлан, үйл ажиллагаа, линкүүд гэсэн бүтэцтэй. Мэдээллийг орон тус бүрээр болон, асуудлаар ангилан төрөлжүүлсэн, өөрийн хайлтын индекс бүхий системтэй. Мөн Derechos нь хүний эрхийн онлайн сэтгүүл, мэдээллийн хуудас, цахим шуудангийн сүлжээ (mailing listserv) болон хүний эрхийн бусад сайтууд руу холбогдох линкүүдийг агуулсан байдаг. Мөн түлхүүр үгүүдээр сайт дотроос мэдээлэл хайх боломжтой.

Б. Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний агентлагиудын веб хуудсууд:

Нэгдсэн Үндэстний Байгууллага:

- United Nations

<http://www.un.org>

НҮБ болоод олон улсын, бус нутгийн олон байгуулагууд хүний эрхийн салбарт ажилладаг бөгөөд тэдгээрийн олонхи мөн арвин баялаг мэдээллийн сангүүдтай байлаг. Энэхүү веб сайт нь НҮБ, түүний системийн бичиг баримт, мэдээллийн төв юм. НҮБ болоод түүний төрөлжсөн байгууллагууд, салбар комисс, хороодын бүхий л гэрээ, конвенци, тунхаглал болон бусад баримт бичгүүдийг агуулдаг. Мөн НҮБ-ын салбар байгууллагудын санал дүгнэлт, зөвлөмжүүд, гишүүн улс орнуудын тайлан илтгэл зэргийг энэхүү сайтаас олж болно. Гол онцлог нь НҮБ-ын баримт бичгийн талаар тодорхой заавруудыг агуулсан байдаг.

-НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссиарын Газар

-UN High Commissioner for Human Rights

<http://www.unhchr.ch>

1996 оны Хүний эрхийн өдрөөр анх байгуулагдсан. НҮБ-ын ХЭДКГ-ын энэхүү сайт нь мөн НҮБ, түүний системийн бүхий л бичиг баримт, тайлан судалгаа, тусгай илтгэгчдийн дүгнэлт зэргийг иж бүрнээр нь агуулсан мэдээллийн сан юм. Одоогоор англи, франц, испани хэлээр мэдээллийг харуулж байгаа. НҮБ болоод түүний төрөлжсөн байгууллагууд, салбар комисс, хороодын дүгнэлт, зөвлөмжүүд, гишүүн улс орнуудын тайлан илтгэл зэргийг энэхүү сайтаас хялбархан олж болно. Мөн НҮБ-ын тогтолцооны хамгийн сүүлийн үеийн мэдээлүүд байнга шинэчлэгдэн тавигдаж байдаг.

**В. Олон улсын Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын
сайтууд:**

Хүний Эрхийн Боловсролын Холбоо:

Human Rights Education Associates

<http://www.hrea.org/>

Энэ сайт нь хүний эрхийн боловсролын төрөлжсөн сайт бөгөөд АНУ дахь Олон улсын хүний эрхийн боловсролын холбоо зохион байгуулдаг. Мэдээлэл ба сургалт гэсэн хоёр үндсэн хэсэгтэй. Сургалтын материалууд, зааварчилгаа зэрэг мэдээллийг орон сэдвээр болон асуудлаар ангилан төрөлжүүлсэн, өөрийн хайлтын индекс бүхий системтэй. Мөн хүний эрхийн долоо хоног тутмын мэдээллийн хуудас, цахим шуудангийн сүлжээ (mailing listserv) болон хүний эрхийн бусад сайтууд руу холбогдох линкүүдийг агуулсан байдаг. Мөн тус байгууллагаас зохион байгуулж байгаа зайны сургалтуудын мэдээ, хөтөлбөрүүдийг татан авч үзэх боломжтой.

III. Хүний эрхийн боловсролын зөвлөмж

Ч.Алтангэрэл ХЭҮК-ын боловсрол хариуцсан референт
/Албан бус орчуулга/

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН БАГА БОЛОН ДУНД СУРГУУЛИЙН БАГШ БЭЛТГЭХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖ

НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас батлан 2005 оны 1-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн хүрээнд “Хүний эрхийн боловсролын багш бэлтгэх” Стратеги Төлөвлөлтийн уулзалт 2005 оны 6 дугаар сарын 1-3 ны өдрүүдээд Нью-Йоркийн Бруклинд зохион байгуулагдсан. Дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн 26 хүний эрхийн боловсролын судлаач, мэргэжилтнүүд цаашид олон улсын, бүс нутгийн болон улс үндэсний түвшинд хэрэгжүүлэх стратегийн төлөвлөлтийг боловсруулах зорилгоор хүний эрхийн боловсролын сургагч багш бэлтгэх асуудлаар судалгаа шинжилгээ, бүтэц сүлжээний талаар хэлэлцэн, харилсан мэдээлэл туршлага солилцов.

Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр нь энэхүү боловсролоор дамжуулан эрэгтэй, эмэгтэй, хүүхэд гэж ялгалгүй хүн бүрийг эрхэмлэн дээдлэх, хүний эрхийн эрхэм зорилго, амалтуудыг хэрэгжүүлэхийн тулд дэлхийг хүн төрөлхтөнийг хамтран ажиллахыг хүсэж байна.

Иймээс, Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн нэгдүгээр үе шат (2005-2007) бага болон дунд боловсролын тогтолцоонад чиглэж байна.

Бага болон дунд сургуулиудад хүний эрхийн боловсролыг олгосноор тухайн сургуулиуд нь хүний эрхийг сургах болон хэрэгжүүлэхүйн үлгэр загвар байх болно. Сургуулийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийн хувьд багш нар энэхүү зорилгыг хангахад голлох үүрэгтэй байна.

Мөн албан боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын ололт амжилт нь хүний эрхийн талаар болон түүгээр дамжуулан сурагчдыг сурган хүмүүжүүлэх үүрэг хариуцлагаа хэрэгжүүлж чадах болно хэмээн найдаж байна.

Улмаар хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх багш нарыг бэлтгэх нь Хүний эрхийн боловсролыг Дэлхийн хөтөлбөрийг дэлхийн бодлого

боловсруулагчдын уулзалтын ширээнээс хүн төрөлхтөний хойч үеийнхний анги танхимд авчирч чадах үр дүнтэй стратеги байна хэмээн найдаж байна.

Ийнхүү багш бэлтгэх тогтолцоонд Хүний эрхийн боловсролыг оруулахтай холбогдуулан Дэлхийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн, үндэсний, бус нутгийн болон глобаль түвшинд эцэг эх, багш нар, суралцагчдыг оролцуулах зарчимд тулгуурлан дараахи зөвлөмжийг нийт оролцогч, хэрэгжүүлэгчдэд өргөн мэдүүлж байна.

I. НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ АГЕНТЛАГУУДАД

1. Аливаа улс орнууд Хүний эрхийн боловсролтой холбогдуулан олон улсын өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг тодорхойлох судалгааны төслийг Хүний Эрхийн Америкийн Хүрээлэнгийн загварын дагуу бус нутаг бүрээр боловсруулах, (Inter-American Institute for Human Rights <http://www.hrusa.org/workshops/HREWorkshops/usa/IAReport.htm>)

2. Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн нэгдүгээр үе шатыг (2005-2007) хэрэгжүүлэхэд багш бэлтгэх/ давтан бэлтгэх болон мэргэжил дээшлүүлэх тогтолцоонд гарч буй санаачлагууд, сургалтын шинэ хэрэглэгдэхүүн боловсруулах зэрэгт хүний ба санхүүгийн нөөцийн дэмжлэг үзүүлэх,

3. Хүний эрхийн боловсролын багш мэргэжилтэн бэлтгэх гарын авлага (ХЭДКГ) болон бусад багш бэлтгэх тогтолцооны үзэл баримтлал, зарчмуудыг тодорхойлох зорилгоор багш бэлтгэх тогтолцооны олон улсын уулзалт хэлэлцүүлэгт хүний нөөцийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх,

4. үндэсний болон бус нутгийн түвшинд хүний эрхийн боловсролын сургагч багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх,

5. Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн багш бэлтгэх хэсгийг (2005-2007) хэрэгжүүлэхэд Засгийн газраас хэрэгжүүлж буй болого, арга хэмжээний тухайд багш бэлтгэх сургуулиуд болон хүний эрхийн байгууллагуудтай хамтран үнэлэх, хариуслага тооцох механизм боловсруулах, хэрэгжүүлэх,

II. БУС НУТГИЙН ЗАСГИЙН ГАЗАР ХООРООНДЫН БАЙГУУЛЛАГУУДАД

1. Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэхэд хүний эрхийн боловсролын сургалтын материал, хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулах,

2. Хүний эрхийн боловсролын сургагч багш бэлтгэх үндэсний болон бус нутгийн сургалт зохион байгуулах,

3. Багш нарыг хүний эрхийн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх байнгын хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэх,

4. Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн эхний үе шатыг хэрэгжүүлэхэд Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг үнэлэх, хариуцлага тооцох механизмыг боловсруулах, хэрэгжүүлэх,

5. Улс орнууд хүний эрхийн боловсролтой холбогдуулан олон улсын өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг тодорхойлох судалгааны төслийг Хүний Эрхийн Америкийн Хүрээлэнгийн загварын дагуу бус нутаг бүрээр боловсруулах,

III. ОЛОН ТАЛТ ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГУУД БОЛОН САНГУУД MULTILATERAL АГЕНТЛАГ

1. Мянганы Хөгжлийн Зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн бодлогодоо хүний эрхийн боловсролын сургагч багш бэлтгэх асуудлыг тусгах,

2. Багш бэлтгэх тогтолцоонаа хүний эрхийн боловсролыг нэвтрүүлэх санаачлагуудад хөрөнгө нөө хуваарилах,

3. Багш болон багш бэлтгэгч мэргэжилтнүүдэд хандсан судалгааны төсөл, тэтгэлэгт хөтөлбөр, Багшийн солилцооны хөтөлбөр, хүний эрхийн сургагч багшийн шагнал зэрэг хүний эрхийн боловсролыг түгээж буй багш нарт зориулсан урамшууллын тогтолцоог дэмжих,

IV. ҮНДЭСНИЙ ЗАСГИЙН ГАЗАР, БОЛОВСРОЛЫН ЯАМДАЛ

1. (1) сургагч багш бэлтгэх, (2) чанар, үр ашигт хяналт тавих (3) мэргэжил дээшлүүлэх чиглэлээр хүний эрхийн боловсролын хөтөлбөр, тогтолцоог бий болгох,

2. Хүний эрхийн боловсролын багш бэлтгэх бодлого, стандартыг багш нартай зөвлөлдсөний үндсэн дээр тодорхойлох,

3. Хүний эрхийн боловсролыг үндсэн хууль болон бус нутгийн засгийн газар хоорондын бүтцэд нэгтгэж, багш нарын стандартыг баталгаажуулахад Засгийн газрыг уриалах,

4. Бусад улс, бус нутаг дахь хүний эрхийн байгууллага, сургуулиудад багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, солилцоо хийх бололцоогоор хангах,

5. Хүний эрхийн боловсролын багш бэлтгэх зорилтыг агуулсан Хүний эрхийн боловсролын Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ба сайжруулах,

6. Олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, хүний эрхийн боловсролд холбогдох хууль тогтоомж, олон улсын хурал зөвлөлгөөний баримт бичгүүдийг орон нутгийн, үндэсний ба глобаль түвшинд түгээн дэлгэрүүлэх,

V. ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГА, КОМИССТ

1. Хүний эрхийг заах сонирхол бүхий сургуулиудтай түншийн харилцаа тогтоох, багш нарыг дэмжих, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

2. Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийн эхний үе шатыг хэрэгжүүлэхэд Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг үнэлэх, хариуцлага тооцох механизм боловсруулах, хэрэгжүүлэх,

VI. ИХ ДЭЭД СУРГУУЛИУД БОЛОН БАГШ БЭЛТГЭХ СУРГУУЛИУДАД

1. Хүний эрхийн боловсролоор чанартай багш бэлтгэх судалгааны арга хэрэгслүүд, арга зүйн зөвлөмж боловсруулах,

2. Багш бэлтгэх/давтан бэлтгэх тогтолцоон дахь хүний эрхийн боловсролд холбогдох судалгаанд дүн шинжилгээ хийх,

3. Багш боловсролд холбогдох хүний эрхийн судалгааг дэмжих, судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулах,

4. Олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, хүний эрхийн боловсролд холбогдох хууль тогтоомж, олон улсын хурал зөвлөлгөөний баримт бичгүүдийг орон нутгийн, үндэсний ба глобаль түвшинд түгээн дэлгэрүүлэх,

5. Багш бэлтгэх/давтан бэлтгэх болон багш нарт зориулсан хүний эрхийн нөөцийн төв байгуулах,

6. Хүний эрхийн боловсролоор багш бэлтгэх орон нутгийн, үндэсний, бус нутгийн ба дэлхийн хэмжээний бага хурал зохион байгуулах,

7. Хүний эрхийн боловсролыг түгээж байгаа болон сонирхож буй их сургуулиуд, багшийн сургуулиудын хоорондын сүлжээг бий болгох,

8. Хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүдийг холбох, өөр үс нутаг дахь байгууллагууд, их сургуулиудтай солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх,

9. Багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудад хүний эрхийн зарчмуудад тулгуурлан хүний эрхийн сургагч, зөвлөх, сургуулиудтай хамт суралцах, ажиллах боломжийг хангах,

10. Багш-оюутнуудад хүний эрхийн боловсролоор бус нутгийн хэмжээнд дадлагажих боломж бүхий түншлэлийн харилцаа тогтоох,

11. хүний эрхийн боловсролын багш бэлтгэх тухай судалгаа, өгүүлэл зэргийг боловсролын сэтгүүлүүдэд хэвлүүлэх,

12. Хүний эрхийг заах сонирхол бүхий сургуулиудтай түншийн харилцаа тогтоох, багш нарыг дэмжих, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

13. Багш нарын зүгээс мэргэжил дээшлүүлэх, хүний эрхийн боловсролын хичээл төлөвлөх, үр ашигтай туршлагуудыг харилсан хуваалцах боломж бүхий интернет хэрэгслийг бий болгох,

VII. ТӨРИЙН БУС БОЛОН ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД

1. Хүний эрхийн зарчмуудыг хэрэгжүүлж байгаа сургуулиуд, хүний эрхийн сургагч багш нарыг хамруулсан мэдээллийн сан бий болгох,

2. Олон улсын хүний эрхийн баримт бичгүүд, хүний эрхийн боловсролд холбогдох хууль тогтоомж, олон улсын хурал зөвлөлгөөний баримт бичгүүд зэргийг орон нутгийн, үндэсний ба глобаль түвшинда түгээн дэлгэрүүлэх,

3. Багш бэлтгэх, хамтран ажиллах чиглэлээр хүний эрхийн боловсролын багш нарын холбоодыг үндэсний, бус нутгийн болон дэлхийн хэмжээнд байгуулах,

4. Хүний эрхийн боловсролоор багш бэлтгэх, давтан бэлтгэх зайны сургалтын хичээлүүдийг боловсруулах,

5. Тухайн орны болоон бус нутгийн өвөрмөц байдалд тулгуурласан жендер, хүүхдийн эрхийн асуудлыг агуулсан засгийн газарт лобби хийх арга замыг боловсруулах,

6. хүний эрхийн боловсролд улсын төсвөөс тодорхой хувийг зарцуулах талаар засгийн газарт лобби хийх

7. Хүний эрхийг заах сонирхол бүхий сургуулиудтай түншийн харилцаа тогтоох, багш нарыг дэмжих, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх,

8. Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх зэрэгт багш наарт дэмжлэг үзүүлэх зорилгоор эрхийн боловсролын хичээл оруулах зэрэг үр ашигтай туршлагуудыг харилсан хуваалцах боломж бүхий интернет сүлжээг өргөтгөх,

9. Хүний эрхийн боловсролын Дэлхийн чуулга уулзалт, бэлтгэл ба хэрэгжүүлэх бүс нутгийн уулзалтуудыг зохион байгуулахад хүний нөөцийн ба санхүүгийн дэмжлэг үзүүлэх,

10. 2006 оны 11-р сарын болох Хүний эрхийн боловсролын Дэлхийн чуулга уулзалтын бэлтгэл, хуралдаан болон түүнээс гарах үр дүнгийн гол бүрэлдэхүүн хэсэг нь хүний эрхийн багш бэлтгэх явдал болохыг бататгах,

[1] Хавсралт 1. Оролцогчдын нэрс

[2] Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр (A/59/525/Rev.1)
Хавсралт Е.20

[3] Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөр (A/59/525/Rev.1)
Хавсралт Е.23

ЗӨВЛӨМЖ

Хүн эрх, эрх чөлөөгөө бодитойгоор эдлэх нэг үндсэн нөхцөл нь хүний эрхийн боловсрол мөн болохыг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас цохон тэмдэглэж, энэ чиглэлээр олон чухал шийдвэр, баримт бичиг гаргасаар байна. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1995-2004 оныг Хүний эрхийн боловсролын 10 жил болгон зарласан бөгөөд түүний залгамж болгон Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийг батлан гаргасан. Энэхүү хөтөлбөрийн нэгдүгээр үе шат (2005-2007) нь хүний эрхийн боловсролыг бүх нийтийн ерөнхий боловсролын бүрэлдэхүүн хэсэг болгох зорилгоор бага болон дунд боловсролын тогтолцоонад чиглэж байна.

Монгол улсад 1990-ээд оноос эхлэн ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн сургалтын агуулга, арга зүйг шинэчлэх, боловсронгуй болгох талаар багагүй ажил хийгдэж иржээ. Энэ чиглэлээр хийгдсэн чухал ажлын нэг бол “Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт”-д хүний эрхийн боловсролын агуулгыг тодорхойлсон явдал мөн. Гэвч бага болон дунд боловсролын тогтолцоonda хүний эрхийн боловсролыг нэвтрүүлэх чиглэлээр хийгдэж ирсэн үйл ажиллагаа нь бидний хүлээж буй үр дүнэд хүрэхгүй, уялдаа холбоо муу байгаа нь харагдаж байна.

Үүнээс гадна албан ба албан бус боловсролын бусад салбарт ч хүний эрхийн боловсролын чиглэлээр дорвийтой ахиц гарахгүй байна. Энэ нь хүний эрхийн боловсролын чиглэлээр төрийн нэгдсэн бодлого байхгүй явж ирсэнтэй холбоотой бөгөөд 2003 онд Монгол Улсын Их Хурлаас батлагдсан Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрт ч хүний эрхийн боловсролын асуудал тусгагдаагүй байна.

Иймээс Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос холбогдох байгууллага, албан тушаалтанда хандан **ЗӨВЛӨМЖ БОЛГОХ НЬ:**

Монгол Улсын Их Хуралд,

1. Хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр төрөөс баримтлах нэгдсэн бодлого, чиглэлийг тодорхойлж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах; Энэхүү бодлого нь Монгол улсад Хүний эрхийг хангах үндэсний Хөтөлбөрийн хүрээнд дэд хөтөлбөр байдлаар боловсруулагдах боломжтой.

2. Хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих, ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн орчныг бүрдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг шинэчлэх;

Монгол Улсын Засгийн Газарт:

3. Төрөөс хүний эрхийн боловсролын талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн төслийг боловсруулах, УИХ-аар батлуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах ба үүнд шаардлагатай хүний болон санхүүгийн нөөшийг бий болгох, хуваарилах;

4. Хүний эрхийн олон улсын баримт бичгүүд, хүний эрхийн боловсролд холбогдох олон улсын болон үндэсний хэмжээний хууль тогтоомж, баримт бичгүүд болон сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүнийг орон нутгийн ба үндэсний түвшинд түгээн дэлгэрүүлэх;

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яаманд:

5. Бага болон дунд боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсролыг нэвтрүүлэх зорилгын хүрээнд багш нарыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, үүний тулд хүний эрхийн хичээлийг багш бэлтгэдэг их дээд сургуулийн заавал судлах хичээлийн агуулга болон багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт тодорхой кредит цагаар оруулах бодлого баримтлах;

6. Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтныг бэлтгэх, давтан бэлтгэхдээ хүний эрхийн сургалтын менежментийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах чадварыг эзэмшигүүлэхд анхаарч ажиллах;

7. Багшлах эрхийг олгох шалгуурт хүний эрхийн мэдлэг, хандлагыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг оруулах;

8. Хүний эрхийн хичээлийг заах багшийн мэргэжил, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг боловсруулж, батлан, мөрдүүлэх;

9. Хүний эрхийн хичээлийн хэрэглэгдэхүүн, сурах бичиг, гарын авлага, сургалтын материалыг боловсруулах, энэ чиглэлээр гарч байгаа үүсгэл санаачлагыг дэмжих;

10. Түүх, нийгмийн ухааны боловсролын стандартын хэрэгжилтэнд тавих төрийн хяналт шалгалтын чанар үр нөлөөг дээшлүүлж, хариуцлага тооцож ажиллах ;

11. Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн удирдлага, багш нарын ажлыг үнэлж, дүгнэх шалгуур үзүүлэлтэнд тухайн сургуулийн дүрэм, журам хүний эрхэд суурисан байдал, сургуулийн хүний эрхийн орчны үзүүлэлтийг тусгах;

12. Хүний эрхийн боловсролын чиглэлээр ажиллаж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, сургуулиуд, судлаачид, багш нар, хувь хүмүүсийн үүсгэл, санаачлага, үйл ажиллагааг тогтмол дэмжих;

13. Бага болон дунд боловсролын зорилго, агуулга, сурах бичиг, хэрэглэгдэхүүн нь хүний эрхэд суурисан байх бодлогыг барьж ажиллах;

Улсын Мэргэжлийн Хяналтын Газарт:

14. Монгол улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, конвенц, боловсролын хууль тогтоомж, эрх зүйн актын дагуу ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн боловсролын стандартын хэрэгжилтэнд тогтмол хяналт шалгалт, үнэлгээ хийж хэвших;

15. Тухайн үнэлгээ, шинжилгээ, шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгаж, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож, хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлж хэвших;

Боловсролын хүрээлэнд:

16. Монгол улсын хүний эрхийн боловсролын чиглэлээр баримтлах бодлого, хөтөлбэрийн шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах, энэ чиглэлээр холбогдох олон улсын болон үндэсний мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах санаачилгыг өрнүүлэх;

17. Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн боловсролын стандарт, хөтөлбөр, сурах бичигт хяналт шинжилгээ хийх ажлыг тасралтгүй явуулж, холбогдох байгууллагуудыг эрдэм шинжилгээ, арга зүйн зөвлөмжөөр хангах;

18. Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газрын арга зүйч, сургуулийн удирдлага, менежерүүд, багш нарын дунд хүний эрхийн боловсролын талаар мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж, зөвлөлгөө өгөх;

19. Хүний эрхийн боловсролыг нийгмийн бүх бүлэг, сургалтын түвшинд хүргэх зорилгоор судалгаа шинжилгээний ажлын чиглэлийг тодорхойлох, үүнд судлаач багш нарыг өргөн оролцуулах;

20. Ерөнхий боловсролын агуулга, сурх бичиг, хэрэглэгдэхүүнийг хүний эрхэд хэрхэн суурилсан байх зарчим, үзүүлэлтийг боловсруулж, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах;

21. Хүний эрхийн боловсролын хандлага, онол арга зүйн талаархи судалгаа шинжилгээний ажил, өгүүлэл нийтлэл зэргийг хэвлэн нийтлүүлэх, олон нийтийн хүртээл болгох ажлыг санаачлан зохион байгуулах,

Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газарт:

22. Ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудад хүний эрхийн сургалтын менежментийн талаар арга зүйн зөвлөмж өгөх, хэрэгжилтэнд хяналт тавих;

23. Ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн сургалтын чанар, стандартын хэрэгжилтэнд хяналт, шинжилгээг тогтмол хийх;

24. Ерөнхий боловсролын сургуульд “Хүний эрх” хичээлийг зааж буй багш наарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжиж ажиллах;

25. Хүний эрхийн хичээл зааж буй багш нарын дунд харицсан туршлага солилцох, хөгжүүлэх зорилгоор уулзалт ярилцлага, мэргэжлийн уралдаан тэмцээнийг зохион байгуулж хэвших;

Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудад:

26. Хүний эрхийн боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулж, багш мэргэжлээр суралцаж буй օюутнуудад заавал судлах хичээл байдлаар оруулах;

27. Ерөнхий боловсролын сургуульд хүний эрхийн хичээл заах багшийг бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

28. Хүний эрхийн хичээлийн ач холбогдол, үнэлэмжийг дээшлүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, багш, оюутнуудыг хүний эрхийн ном, сэтгүүл, гарын авлагаар хангах зорилго бүхий хүний эрхийн боловсрол, мэдээллийн төв байгуулах;

29. Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газрын арга зүйч, сургуулийн удирдлага, менежерүүдэд хүний эрхийн боловсролын талаар мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж, зөвлөлгөө өгөх;

30. Багш боловсролд холбогдох хүний эрхийн судалгааг дэмжих, судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулах;

Ерөнхий боловсролын сургуулиудад:

31. Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер нь хүний эрхийн сургалтыг удирдлагаар хангах мэдлэг, чадвар, хандлагатай байх;

32. ЕБС-ийн хүний эрхийн хичээл заах багш нарыг “Хүний эрх хичээл заах багшид тавигдах шаардлага”-д нийцүүлэн сонгох, сургууль дээрээ мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

33. Хүний эрхийн боловсролын үндэс болсон сургуулийн хүний эрхийн орчныг төлөвшүүлэхэд тэмцүүлэх. Үүний тулд:

Сургуулийн дотоод дүрэм, журмуудыг хүний эрхэд суурилан боловсруулах;

ЕБС-ийн багш бүр хүний эрхийн зохих боловсрол, мэдрэмж, хандлагатай байхыг шаардах, ажил дүгнэх шалгуурт тусгах;

Сургуулийн орчинд хэн ч ялгаварлан гадуурхагдахгүй, эрх тэгш, халдашгүй дархан байх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөхөөс сэргийлж, хүний нэр төр, эрхэм зэргийг хүндэтгэх соёлыг төлөвшүүлэх;

Сурагч, багш нар болон эцэг эхчүүдийн хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр оролцоонд тулгуурласан төрөл бүрийн үйл ажиллагааг зохион байгуулж хэвших;

34. Хүний эрх, хүүхдийн эрхийн төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, багш бэлтгэх болон бусад их дээд сургуулиуд, ЕБС-иудтай хүний эрхийн боловсролын чиглэлээр хамтран ажиллах, харилсан туршлага солицох;

НҮБ, түүний агентлагиуд болон олон улсын байгууллагуудад:

35. Хүний эрхийн боловсролыг дэмжих, бодит үйл хэрэг болгох талаар олон улсын болон бүс нутгийн түвшинд гарч буй бодлого, хөтөлбөр, санал санаачлагыг Монгол улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх;

36. Монгол улсын хүний эрхийн боловсролын бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах, мэргэжлийн болон техникийн туслаалцаа дэмжлэг үзүүлэх;

37. Хүний эрхийн багш бэлтгэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх тогтолцоонд гарч байгаа санал, санаачлагууд, сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах зэрэгт хүний нөөцийн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

38. Үндэсний болон бүс нутгийн түвшинд хүний эрхийн сургагч багш нарыг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх;

Зөвлөмжийг Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2005 онд явуулсан “Хүний эрхийн боловсрол - Ерөнхий боловсролын сургуульд” сэдэвт судалгааны ажлын үр дүн болон, төр, төрийн бүс, олон улсын байгууллагын өргөн төлөөллийг оролцуулсан Дугуйширээний ярилцлагад оролцогчдын саналыг авсны үндсэн дээр боловсруулсан болно.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

ТА БҮХНИЙ СОНОРТ

ХҮНИЙ ЭРХ СЭТГҮҮЛ ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА

Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК) нь улирал тутмын “ХҮНИЙ ЭРХ” сэтгүүлийг хэвлэн гаргадаг уламжлалтай билээ.

Энэ сэтгүүл нь олон улсын, бус нутгийн болон үндэсний хүний эрхийн болдого, баримт бичгүүд, манай улс дахь хүний эрхийн тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх онол, практикийн сэдвээр байгууллага, эрдэмтэн судлаачдын бүтээлүүдийг нийтэлдэг. Мөн ХЭҮК-ын зарим үйл ажиллагааны мэдээлэл, шалгалт судалгааны дүн, тэдгээрийн мөрөөр авсан арга хэмжээ, шаардлага, зөвлөмж, санал зэргийг танилцуулж ирсэн болно.

ХЭҮК нь энэ удаад уг сэтгүүлийн дараагийн дугаарыг хэвлэхээр бэлтгэж байгаа тул хүний эрхтэй холбогдох судалгаа шинжилгээ хийж буй байгууллага, эрдэмтэн судлаачид, идэвхтэн бичигчид та бүхнийг өөрсдийн бүтээлээ “Хүний эрх” сэтгүүлийн зөвлөлд ирүүлэхийг урьж байна.

Сэтгүүлд нийтлүүлэх материалд тавигдах шаардлага:

Хүний эрхийн онол ба практикийн асуудлуудыг хөндсөн байх
Шинэлэг, сонирхолтой байх

Ишлэл зүүлт, ном зүй зэргийг хийж, эрдэм шинжилгээний зохих шаардлагыг хангасан байх

Өгүүллийн хураангуйг англи буюу орос хэлээр хийж хавсаргах
Зохиогчийн тухай товч танилцуулга хавсаргах

Та бүхэн өөрсдийн бүтээлээ шаасан болон электрон хувилбараар доорх хаягаар билэнд ирүүлээрэй. Нэмэлт мэдээлэл шаардлагатай бол дараах хаягаар холбогдоно уу.

Хүний Эрхийн Үндэсний Комисс

Эрх чөлөөний талбай, Улаанбаатар-38, Засгийн газрын 11-р байр

Боловсрол хариуцсан референт Ч.Алтангэрэл

Э-шуудан: altangerelt@mn-nhrc.org

Утас: 976-11-262589

Факс: 976-11-262752

Та бүхнийг бидэнтэй хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

“ХҮНИЙ ЭРХ” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

“ХҮНИЙ ЭРХ” СЭТГҮҮЛИЙГ ЭРХЛЭН ГАРГАСАН:

Хүний Эрхийн Үндэсний Комисс

Хаяг:

Эрх чөлөөний талбай, Улаанбаатар-38

Засгийн газрын 11-р байр, 508 тоот

Э-шуудан: altangerelt@mn-nhrc.org

Утас: 262589